



ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ СУУРЬ СУДАЛГААНУУД





АЛБАН ЁСНЫ ЭРХТЭЙГЭЭР

"СИНГАПУРЫН АМЖИЛТЫН ТАВИН НУУЦ"

Дэлхийн улс орнуудад хөгжлийн сайн туршлага,
гарын авлага болж буй **БЭСТСЭЛЛЭР** ном



УТАС: 70115476 | 94092904

Улсын их дэлгүүр, Аз хур, Интер номын дэлгүүр

Хөгжлийн бодлого судалгаанд үндэслэдэг

Аливаа улс орны хөгжил дэвшлийг урагшлуулагч суурь хүчин зүйл нь зөв бодлого байдаг. Хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд зөв бодлого барьж, түүнийгээ бодитоор хэрэгжүүлж чадсан улс орнууд илүү өндөр хөгжил дэвшилд хүрсэн нь бодит үнэн юм.

Энэ ч үүднээс “Mongolian Economy” сэтгүүл 2024 оны эхний дугаараа Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулах есөн суурь судалгаанд зориуллаа. Манай сэтгүүл анх удаа зөвхөн судалгаанд зориулсан дугаарыг гаргаж буй нь энэ юм. Төрийн албаны чанар, төрийн чадамж, авто замын түгжрэл, эрчим хүч, мах, махан бүтээгдэхүүний экспорт зэрэг есөн чиглэлээр “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-ын судлаачдын хийсэн судалгаа нь үнэ цэнтэй гарын авлага болох нь гарцаагүй. Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн хувьд цаашид судлах, бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд нь эдгээр судалгаа ихээхэн хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэлтэй байна.

Судалгаа тус бүрийн өгөгдөл, судалгааны хамарсан хүрээ, оролцогчид, цуглуулсан дата, санал дүгнэлтэд туссудалгаануудын ач холбогдолоршиж байгаа юм. Нэг жишээ дурдахад, процессын дахин инженерчлэлийн шинжилгээг төрийн байгууллагуудад өргөн цар хүрээтэй, нягт нямбай хэрэгжүүлснээр төрийн албаны үргүй зардал, нөөцийн буруу

хуваарилалт, төрийн албан хаагчдад ирэх дарамт, бүхимдал багасах бол иргэний хувьд ойлгомжгүй, тодорхойгүй байдал арилах, түргэн шуурхай үйлчилгээ авах боломж нэмэгдэх зэрэг



давуу тал үүсэх юм. Энэ мэтчилэн олон улсын стандартын, дэвшилтэт, шинэлэг аргуудыг багтаасан томоохон судалгаанууд энэхүү дугаарт багтлаа. Уг судалгаануудыг цааш нь дэлгэрүүлэн уншихыг хүссэн уншигчдадаа зориулж QR код оруулж өглөө.

“Алсын хараа- 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулсан. Тус бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар 2022 онд “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-ыг байгуулсан билээ. Тус төв байгуулагдаад удаагүй ч Монгол Улсад тулгамдаад буй салбарт анхаарлаа хандуулж, бодит асуудлыг хөндсөн судалгаануудыг хийж ажилласныг онцлон тэмдэглэе.

2024 он мэргэжлийн судалгаанд суурилсан бодлого гаргаж, хэрэгжүүлдэг алхмыг илүүтэй дэмжсэн, хөгжүүлсэн жил болох болтугай хэмээн ерөөж байна.

“Mongolian Economy” сэтгүүл Ковид цар тахлаас үүдэж үндсэн дугаараа сар тутамд тогтмол гаргаж чадахгүй ирсэн билээ. Тэгвэл бид 2024 оноос үйл ажиллагаагаа жигдрүүлж, сар тутмын үндсэн дугаараа ийнхүү тогтмол гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Сэтгүүлийн уншигчдадаа шинэ оны мэнд хүргэж, эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Н.ЭНХБАЯР

Mongolian Economy сэтгүүлийн редактор



ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр (9999 4248)

РЕДАКТОР:
Н.Энхбаяр (9916 1303)

АНГЛИ РЕДАКТОР:
Роберт Йохан Шрайверс
Жаклин Истриж

СЭТГҮҮЛЧИД:
Б.Шүрэнчимэг
У.Сарангэрэл

ОРЧУУЛАГЧ:
М.Ариунзаяа

ДИЗАЙНЕР:
Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН АЛБА:
9409 2904, 7011 5476

ISSN 2664-195X

СЭТГҮҮЛ ЗАХИАЛГА:
Монгол шуудан (Утас: 7007 8916)
Түгээмэл шуудан (Утас: 7011 5015)

ХАЯГ: Улаанбаатар
Сүхбаатар дүүрэг II хороо,
Сөүлийн гудамж Twin Tower-2.403

ВЭБ: www.mongolianeconomy.mn
И-МЭЙЛ: info@mongolianeconomy.mn
FACEBOOK: Mongolian Economy
TWITTER: EconomyMongolia

Агуулга



Д.Амарбаясгалан: Процессын дахин инженерчлэлийн шинжилгээг тогтмол хийх ёстой | 06



Б.Дөлгөөн: Зуун боломж дэлгэрэг! | 08



Б.Баасандорж: Процессын дахин инженерчлэл | 10

Судалгаа-1

Төрийн албан хаагчийн ажлаас гарах төлөвийг загварчлах нь



12

Судалгаа-4

Монгол Улсын төрийн албаны чанарын судалгааг Дэлхийн банкны олон улсын судалгаатай харьцуулсан байдал



34

Судалгаа-7

Авто замын түгжрэлд боловсролын салбарын үзүүлж буй нөлөөлөл



63

Судалгаа-2

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хийсэн процессын дахин инженерчлэл



16

Судалгаа-5

Төрийн чадамжийг бүрдүүлэх нь



41

Судалгаа-8

Улаанбаатар хотын зорчигч хөдөлгөөний математик загварчлал СИМУЛЯЦИ



73

Судалгаа-3

Төрийн албаны чанарын судалгаа



25

Судалгаа-6

Эрчим хүчний сэргэлт



45

Судалгаа-9

Мах, махан бүтээгдэхүүний экспорт



77

"Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" УТҮГ



Монгол Улсын Засгийн газраас улс орны эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, эдийн засагт ковид-19 халдварын үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх, “Алсын хараа- 2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын Их Хурал 2021 оны арвандугаар сард баталсан билээ.

Тус бодлогын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны нэгдүгээр сарын 26-ны өдрийн 55 дугаар тогтоолоор "Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" УТҮГ (ШСБХТ-УТҮГ)-ыг байгуулсан.

Тус байгууллага Дэд бүтцийн хөгжлийн бодлогын газар, Ногоон, бүтээмжтэй хөгжлийн бодлогын газар, Захиргааны удирдлагын хэлтэс гэсэн бүтэцтэй,

30 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулдаг. Засгийн газраас баримталж буй хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэн, хөрөнгө оруулалтыг дэмжих ажлыг эрчимжүүлэхэд боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот хөдөө, ногоон хөгжил, төрийн бүтээмжийн чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд нь зөвхөн нэг яам, нэг агентлаг бие даан хэрэгжүүлэхэд хүндрэлтэй буюу олон салбарыг хамарсан өргөн цар хүрээтэй төслүүд юм. Эдгээр төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт болон хэрэгжилтийг нэгдсэн байдлаар хангаж, оролцогч талуудыг нэг зүгт чиглүүлэх нь "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг амжилттай хэрэгжүүлэх үндэс болох юм. ■

Онцлох зочин

Д.Амарбаясгалан: Процессын дахин инженерчлэлийн шинжилгээг тогтмол хийх ёстой



Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалантай ярилцлаа.

-Та Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын албан тушаалыг хашаад нэг жил гаруй болжээ. Энэ хугацаанд та юунд анхаарч, ажиллаж байна вэ?

-Монгол Улс 1992 оны Үндсэн хуульдаа хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон байгуулахаар тунхагласан. Сүүлийн 30 жилийн хугацаанд Монгол Улсад хийж бүтээсэн зүйлс их ч алдаа дутагдалтай олон зүйл бий. Тухайлбал, бид өнөөдөр Азидаа ардчиллын баянбүрд гэж хэлэгдэх хэмжээнд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлж байгаа боловч зарим талаар өнгөрсөн зууны арга барил, сэтгэлгээнээс хараахан салж амжаагүй байна.

Нэг ёсондоо бид хуучны социалист системийн үеийн дээрээс доош чиглэсэн, захиргаадсан хандлага бүхий дүрэм, журмаасаа бүрэн ангижраагүй байна. Үүнээс шалтгаалж төрийн үйлчилгээ, хөрөнгө оруулалт нь иргэдийн бодит хэрэгцээ шаардлагад үл нийцэх, эргээд шүүмжлэлд өртөх байдал гардаг. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч хаан гэж зарладаг боловч хэрэглэгчдэдээ өөрсдийн зөв гэж үзсэн бүтээгдэхүүнээ шахсаар байгаатай адилхан юм.

Төрийн албан хаагчид, төрийн өмчит компаниудын бүтээмж, ажлын үнэлгээ ч өнгөрсөн үетэй зарим талаар ижил байна. Социализмын үеийн эдийн засгийн системийг “Бид ажиллаж байгаа дүр эсгэдэг бол тэд цалин тавьж байгаа дүр эсгэдэг” гэж зүйрлэдэг байсантай зарчмын хувьд ойрхон хэвээр байна.

Ганцхан жишээ дурдахад, өнөөдөр Улаанбаатар хотод хэт төвлөрөл үүссэнээс агаарын бохирдол, түгжрэл, цахилгаан хангамж, дэд бүтэц гээд олон бэрхшээл бий болсон. Нөгөө талаар, орон нутгийг залуучууд орхиж явах, улмаар эргэж нутагтаа ирж, ажиллаж амьдрахгүй байгаа нь томоохон асуудал болж байна. Энэ бол бид өнгөрсөн хугацаанд иргэдийнхээ хүсэл, зоригийг хангалттай ойлгоогүй, өнгөц илэрч байгаа асуудалд түлхүү анхаарч ажиллаж байсны гор юм.

Тэгэхээр энэ мэт ирээдүйд үүсэж болох ►

► асуудлыг урьдаас харж, бодлогын шийдэл гаргадаг, үзүүлж байгаа үйлчилгээ, холбогдох дүрэм журмаа байнга сайжруулж, засдаг байхад чадварлаг төрийн албан хаагчид чухал үүрэгтэй.

Иймд төрөөс хэрэгжүүлж байгаа бодлого, үзүүлж байгаа үйлчилгээ иргэддээ хэр нийцэж байгааг зураглах зорилгоор процессын дахин инженерчлэлийн шинжилгээний ажлыг иргэдэд хамгийн их үйлчилгээ үзүүлдэг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хийсэн.

Уг шинжилгээгээр зөвхөн нэг яамны хувьд чиг үүргийн давхцалтай 65 үйлчилгээ, сайжруулах шаардлагатай тоймгүй олон асуудал байгааг тодорхойлсон. Уг шинжилгээ нь нэг удаа хийгээд орхих ажил биш бөгөөд тодорхой хугацааны давтамжтай байнга хийх ёстой. Үр дүнд нь үргүй зардал, нөөцийн буруу хуваарилалт, төрийн албан хаагчдад ирэх дарамт, бухимдал багасах бол иргэний хувьд ойлгомжгүй, тодорхойгүй байдал арилах, түргэн шуурхай үйлчилгээ авах боломж нь нэмэгдэх юм.

-Процессын дахин инженерчлэлийн ажлыг төрийн бүх байгууллагад хэзээ хийж дуусах вэ?

-Энэ удаагийнх ойрын хугацаанд хийгдээгүй иж бүрэн шинжилгээ болсон. Тиймээс Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шинжилгээ хийхэд тодорхой хугацаа шаардсан. Үүний дараа, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам зэрэг үйлчилгээ голлодог, өргөдөл гомдол их ирдэг яамдад энэ жилд багтаан хийхээр зорьж байна.

Процессын дахин инженерчлэлийн шинжилгээг яам, төрийн байгууллагуудад байнга тасралтгүй, тодорхой хугацаанд ахин дахин хийх ёстой юм. Нэг удаа хийгээд орхих ажил гэж ойлгож болохгүй. Нэг ёсондоо сайжруулсан ч бас дахин сайжрахын тулд процессын дахин инженерчлэлийн шинжилгээг хийсээр байна гэсэн үг юм.

-2023 оны хавар “Эрдэнэс Монгол” төрийн өмчит компанид хүний нөөцийн нээлттэй шалгаруулалт явагдсан. Төрийн өмчит компаниудын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр ямар бодлого баримталж байна вэ?

-2022 оны аравдугаар сард Засгийн газар, яамдын харьяаны төрийн өмчит хуулийн этгээдийн тоо 130 байсан. Нэг ёсондоо шаардлагатайгаасаа шаардлагагүй хүртэл, зарим талаар чиг үүрэг нь давхардсан цөөнгүй компани үйл ажиллагаа явуулж байсан. Харин өнөөдөр энэ тоо 96 болж буураад байна. Цаашид ч дахин цөөлөх процесс үргэлжилнэ.

Төрийн өмчит компаниуд олшрох, томрох тусам үргүй зардал нэмэгдэх, нөгөөтээгүүр хувийн хэвшлийн орон зайг хүмх нь тодорхой юм. Олон улсын судалгаагаар төрийн өмчит компаниуд хөрөнгийн өгөөжийн хувьд хувийн хэвшлээс дунджаар хоёр дахин бага байдгийг тогтоосон. Төрийн өмчит компаниудыг зөвхөн Монголд ч биш олон улсад ч асуудалтай гэж үздэг.

Нэг жишээ дурдахад, Монгол Улсад авто зам, засвар ашиглалтын 20 компани үйл ажиллагаа явуулж байсан. Бүгдээрээ захиргааны албан хаагчидтай, түүнээс гадна удирдах зөвлөлийн 72 гишүүнтэй байсан. Нийт зардал нь 43 тэрбум төгрөг бол удирдлагын зардал нь таван тэрбум төгрөгт хүрсэн. Эдгээр 20 компанийг нэгтгэснээр зөвхөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалингаас 400-500 сая төгрөг хэмнэж байгаа бол захиргааны зардалд мөн багагүй хэмжээний хөрөнгө хэмнэх боломжтой. Үйл ажиллагааны хувьд техник хэрэгсэл, хүний нөөцөө хуваарилах, ашиглах тал дээр олон давуу тал бий болно гэж дүгнэж байна.

“Эрдэнэс Монгол” компанийн хувьд төрийн өмчит уул уурхайн бүх компанийг нэгдсэн удирдлагад оруулах замаар засаглал, үйл ажиллагааг нь сайжруулах зорилготойгоор шинэчлэн зохион байгуулагдсан. Энэ үүднээс чадварлаг хүний нөөц эн тэргүүний асуудал байсан учраас нээлттэй сонгон шалгаруулалтыг богино хугацаанд хийхийг компанийн удирдах зөвлөл, удирдлагад санал болгосон.

Улмаар энэ оны нэгдүгээр сард 88 ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, 76 хүн шалгаруулсан. Өнгөрсөн сарын байдлаар сонгон шалгаруулалтаар ажилд орсон хүмүүсийн 70 нь ажлаа хийж байна гэсэн мэдээлэл авсан. ■

Ирээдүйд үүсэж болох асуудлыг урьдаас харж, бодлогын шийдэл гаргадаг, үзүүлж байгаа үйлчилгээ, холбогдох дүрэм журмаа байнга сайжруулж, засдаг байхад чадварлаг төрийн албан хаагчид чухал үүрэгтэй

Байр суурь

Зуун боломж дэлгэрэг!



Б.Дөлгөөн

"Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" УТУГ-ын захирал

Дэлхийн түүхэнд улс орнууд хөгжиж, хямарсан олон тохиолдол бий. Хөгжиж буй улсууд, хямарч буй улсаас юугаараа ялгаатай байв гэдэг асуудлыг олон эрдэмтэн судлаач, тэр дундаа эдийн засагчид судалсаар ирсэн. Улс орнууд хэрхэн ялгаатай хөгжсөн нь сүүлийн 40 жилээс маш тодорхой харагдана.

Өнгөрсөн 40 жилийн хөгжил

Дэлхийн нэг хүнд ногдох орлого 1981 онд 5,933 ам.доллар байсан бол (2015 оны ам.долларын тогтмол ханшаар тооцоход) 40 жилийн дараа, 2021 онд 11,000 ам.долларт хүрч, бодитоор 185 хувь өссөн байна. Эл 40 жилийн хугацаанд манай урд хөрш БНХАУ-ын нэг хүнд ногдох орлого 450 ам.доллараас 11,200 ам.доллар буюу 2500 хувь, Энэтхэг улсынх 400 ам.доллараас 1,940 ам.доллар буюу 480 хувь тус тус өсжээ. Энэ дунд Мадагаскар 73 хувь, Хаити 63 хувь гээд 40 жилийн хугацаанд бага өсөлттэй улс орон ч байна. Монгол Улсын хувьд нэг хүнд ногдох орлого тогтмол ханшаар тооцоход 1985 онд 1,428 ам.доллар байсан бол 40 жилийн дараа 4,100 хүрч 285 хувиар өссөн байна.

Хөгжсөн, хөгжөөгүй орны гол ялгаа нь он цагийн уртад тухайн улс орны хэрэгжүүлж буй бодлогоос үүдэлтэй

Хөгжлийн суурь хүчин зүйл

Судлаачид улс орны эдийн засгийн хөгжлийн зөрүүг олон хүчин зүйлтэй холбож судалж байна. Түүхийн явцад зөв бодлого барьж, түүнийгээ амьдрал дээр хэрэгжүүлж чадсан улс орнууд илүү өндөр хөгжил дэвшилд хүрчээ гэдэг дээр санаа нэгддэг. Нэг үгээр хэлбэл, улс орны хөгжилд бодлогын үүрэг оролцоо маш өндөр гэсэн үг. Буруу бодлого барьснаас улбаалж нүдэн дээр хямарч буй улс орон сүүлийн 10 жилд цөөнгүй. Япон, Өмнөд Солонгос, Сингапур зэрэг улсын сүүлийн 60 жилийн үсрэнгүй хөгжил нь тохиолдлын зүйл биш юм. Мэдээж геополитик, технологи, тухайн улс орны түүхэн хүчин зүйл бүгд хамаатай ч, эдгээр улс хамгийн их байгалийн баялагтай, хамгийн олон хүн амтай улс биш. Хөгжсөн, хөгжөөгүй орны гол ялгаа нь он цагийн уртад тухайн улс орны хэрэгжүүлж буй бодлогоос үүдэлтэй. Бодлого боловсруулахдаа нотолгоонд тулгуурлаж боловсруулах чадвартай, мөн үүнийгээ хэрэгжүүлэх чадамж байна гэдэг тухайн улсын төрийн чадамжтай, төрийн чадамжийг бүрдүүлж байгаа институцтэй холбоотой асуудал юм.

Ариун гурвал

“Хорацио минь дээ, чиний зүүдэлж чадахаас илүү их зүйл энэ орчлон ертөнцөд бий” гэж Хамлет хэлдэг шиг амьдрал баян билээ. Дэлхийн улсууд олон бодлого жил бүр гаргадаг ч, эдгээрээс амжилттай хэрэгждэг нь хавьгүй цөөн байдаг. Харвардын Их Сургуулийн профессор Лант Притчетт, Мэтт Эндрьюс нарын хэлж буйгаар бодлого амжилттай хэрэгжих гурван үндсэн нөхцөл байдаг ажээ. Нэг дэх хүчин зүйл бол бодлого онолын хувьд “асуудлаа” шийддэг байх ёстой. Асуудлаа шийдэхгүй бол бодлого амжилттай хэрэгжсэн ч тухайн бодлогыг анх гаргахдаа шийднэ хэмээн зорьсон асуудлууд хэвээр үлдэнэ гэсэн үг. Хоёр дахь нь, улс төрийн дэмжлэг авах, гуравдугаарт тухайн бодлогыг хэрэгжүүлэх байгууллага үг бодлогыг хэрэгжүүлж чадах хэмжээний төрийн чадамжтай байх ▶

► юм. Үүнийг тэд бодлогын “Ариун гурвал” гэж нэрийдсэн.

Шинэ сэргэлтийн бодлого

"Шинэ сэргэлтийн бодлого" (ШСБ) бол эдгээр "Ариун гурвал"-ын хүчин зүйлсийг харгалзан үзсэн бодлогын баримт бичиг юм. Үндэслэлийг гаргахад тооцоо судалгаа, нотолгоо дээр тулгуурласан. Уг бодлогыг боловсруулахад Монгол Улсын Засгийн газрын олон яам, агентлагийн төрийн албан хаагчид оролцсон бөгөөд бодлогын үндсэн агуулга эдгээр төрийн албан хаагчдын оюун санаанд тулгуурлаж бүтсэн билээ. 2021 онд дэлхий даяар үүссэн Ковид19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг хямарч, гадаад, дотоод орчин нөхцөл хүндэрсэнтэй холбоотойгоор нөхцөл байдал дахин үнэлгээ өгч, цаашид баримтлах бодлого боловсруулах бодит шаардлага үүссэн. Энэ цаг үед Ерөнхий Сайд Л.Оюун-Эрдэнэ санаачилгыг гартаа авч, дунд хугацааны хөгжлийн бодлогыг боловсруулах даалгавар өгснөөр ШСБ-ын эхлэл тавигдсан. Нэг талаас, нийгэм-эдийн засгийн захиалга үүссэн, үүнтэй зэрэгцээд улс төрийн хүсэл эрмэлзэл бүрдсэнээр шинэчлэл хийх орон зай гарч ирсэн юм.

Өсөлтийн оношилгоо

"Шинэ сэргэлтийн бодлого"-ын үндэслэлийг боловсруулахад “Өсөлтийн оношилгоо” аргыг ашигласан. Аливаа эдийн засгийн шинэчлэлийг хийх таван үндсэн арга байдлаас уг аргачлал хамгийн үр дүнтэй, асуудлыг бодитоор тодорхойлдог нь юм. Уг аргачлалын дагуу өнөөгийн эдийн засагт тулгарч буй, өсөлтийг хязгаарлаж байгаа хүчин зүйлсийг оношилсон. Ингээд оношилгоо хийсний үр дүнд эдгээр хязгаарлагч хүчин зүйл бол эрчим хүч, тээвэр логистик, тэр дундаа хил давахад тулгарч буй асуудлууд, төрийн чадамж зэргийг тогтоосон юм. Эдгээр хязгаарлагч хүчин зүйлсийг шийдсэний дараа аж үйлдвэрлэл хөгжиж, ажлын байр ялангуяа, бүтээмж өндөртэй ажлын байрууд бий болж, улмаар зөвхөн төв суурин газар гэлгүй хөдөө нутагт хөгжил дагуулна. Тийм ч учраас "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үндсэн агуулга боомт, эрчим хүч, аж үйлдвэрлэл, хот хөдөө, ногоон, төрийн бүтээмжийн сэргэлт гэсэн зургаан

**Шинэ
сэргэлтийн
бодлого
амжилттай
хэрэгжихэд
төр, хувийн
хэвшлийн
хамтын
ажиллагаа
зайлшгүй
шаардлагатай**

сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрөөс бүрдэж байгаа юм.

Бодлогын хэрэгжилт

Засгийн газар "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг 2021 оны арванхоёрдугаар сард батлан хэрэгжүүлж байна. Уг бодлого амжилттай хэрэгжихэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Эрчим хүчний сэргэлтийн хүрээнд хийх төслүүд, цаашлаад сэргээгдэх эрчим хүчийг экспортод гаргахад хувийн хэвшлийн оролцоогүй хийх боломжгүй юм. Засгийн газраас "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг бодитоор хэрэгжүүлэхэд татварын болоод бусад дэмжлэгийг тусгасан. Хөрөнгө оруулалтад тулгарч буй асуудлыг хариуцаж, аливаа саад бэрхшээлийг цаг тухайд нь шийдвэрлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны асуудлыг эрхэлсэн агентлагийг Эдийн Засаг Хөгжлийн яамны харьяа байгуулах шийдвэрийг Засгийн газар гаргасан.

Төрийн зүгээс хийх ёстой чухал ажлууд бий. Зах зээл дангаараа байвал доголдолд хүргэх магадлалтай. Зах зээлийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай өнөөдөр дутагдаж буй өрсөлдөөний механизм, хяналтын тогтолцоог бүрдүүлэх хэрэгцээ ч бий. Энэ бол төрийн үүрэг хариуцлага юм.

Түүнчлэн төрийн байгууллага доторх шат дамжлагыг цөөлөх, процессыг цахимжуулах зэрэг төрийн албан хаагчдын бүтээмжийг нэмэгдүүлэх ажлуудыг тусгаж өгсөн. Эдгээр ажлыг гүйцэтгэх хүрээнд хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, авлига, хээл хахуулийг бууруулах нь "Шинэ сэргэлтийн бодлого"-ын төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд тавьсан зорилт юм. Үүнд нэг анхаарах зүйл байгаа нь төр лүү чиглэсэн эдгээр ажлыг Засгийн газар амжилттай хэрэгжүүлэхийн тулд төрийн чадамжийг сайжруулах зайлшгүй хэрэгцээ бий.

Зуун боломж дэлгэрэг

“Өнгөрсөн бол оршил, юу болж өрнөх нь миний болоод таны мэдлийнх” гэж Вилиам Шекспир өгүүлсэн. Монгол Улс ирэх 10 жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогоо тодорхойлж, хязгаарлагч хүчин зүйлсийг шийдвэрлэх хөсөг нэгэнт хөдөлжээ. Цаашид боломж бололцоо бүрдэж байгаа тул хэрхэн ашиглах нь та биднээс хамаарна. ■

Судалгаа

Б.Баасандорж: Процессын дахин инженерчлэл



Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын дарга

Монгол Улсын Засгийн газраас орчин үеийн төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албаны инновацын бодлогыг нутагшуулах зорилгоор бодлогын инновац, төрийн үйлчилгээний инновац өөрчлөлтүүдийг салбар, яамдуудад хийхээр зорин ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн захиргааны дарга төвтэй удирдлагаас өндөр бүтээмжтэй, үнэ цэнд суурилсан процесс суурьтай багийн менежментийн тогтолцоонд шилжих, төрийн захиргааны байгууллагад тулгарч байгаа хүнд сурталтай, үнэ цэн багатай олон шат дамжлагатай процессыг бууруулах зорилгоор тандан судлах, дүн шинжилгээ хийж сайжруулах хэрэгцээ шаардлага үүссэн.

Төрийн үйлчилгээний чанар, байгууллагын чадамж, бүтээмжийг дээшлүүлэх, иргэд болон төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, процесс суурьтай, оновчтой, үр дүн, үр ашигтай засаглалыг бэхжүүлэх зорилгын хүрээнд олон улсад түгээмэл ашиглагддаг тандан судалгааны аргачлал болон менежментийн эрс шинэчлэл сайжруулалт хийхэд ашиглагддаг

Процессын дахин инженерчлэлийн цогц ажлыг төрийн байгууллагуудад Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас шат дараатай хийж байна

процессын дахин инженерчлэлийн цогц ажлыг төрийн байгууллагуудад Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас шат дараатай хийж байна.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон тэдгээрийн харьяа нэгжүүдэд процессын дахин инженерчлэл хийх ажлыг дэмжиж, хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Сангийн яам, Сэлэнгэ аймгийн Засаг дарга болон холбогдох агентлагуудын төлөөлөлтэй байгуулсан юм. Төрийн захиргааны нийт 65 байгууллагад 2023 оны зургаадугаар сарын 14-ний өдрөөс 2023 оны аравдугаар сарын 1-ний хооронд процессын дахин инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийсэн бол аймгуудад бүсчилсэн хэлбэрээр хэлэлцүүлэг болон процессын шинжилгээний ажлыг хийж, үүнд 13 аймгийн 360 гаруй албан хаагч хамрагджээ.

Процессын дахин инженерчлэлийн ажлын хүрээнд олон улсад түгээмэл ашигладаг найман арга, аргачлалын дагуу цогц байдлаар дараах судалгаа, шинжилгээ хийсэн. Үүнээс дараах үр дүн гарсан:

Яам, дээр дурдсан хоёр агентлаг, тэдгээрийн харьяа нэгж, хэлтэс, газраас үзүүлдэг нийт 211 үйлчилгээний процесст RACI матрицын аргаар чиг үүргийн шинжилгээ хийхэд нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн чиглэлийн нийт 65 үйлчилгээг хүргэх процесс нь чиг үүргийн давхардалтай гарав;

Эрсдэлийн үнэлгээний тандалт судалгааг эрсдэлийн менежмент, олон улсын стандартын 240 шалгуураар байгууллага тус бүрд хийж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 980, үйлчилгээний процесстэй холбоотой 1019 бодит эрсдэлийг тогтоов; ▶

► Процессын шинжилгээг дээр дурдсан салбарын төрийн нийт үйлчилгээ буюу нийгмийн даатгалын 96 үйлчилгээ, нийгмийн халамжийн 72 үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн 43 үйлчилгээг хамруулан иргэний туулдаг процесс, төрийн албан хаагчийн оролцдог процесс тус бүрээр гаргав;

-Яам, хоёр агентлаг, тэдгээрийн салбар, нэгжийн хэмжээнд ашиглаж буй 17 систем, программ хангамжид мэдээллийн системийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргав;

-Ажлын байрны зураг авалтыг иргэнд төрийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий 93 ажилтны ажлын байранд хийж, 7000 орчим үйлдлийг бүртгэн үндсэн, туслах болон бусад чиг үүргийн хамаарлаар, цаг зарцуулалтаар, үйлчилгээний төрлөөр, үйлчилгээний хэрэгслээр ангилсан суурь судалгааг хийв;

-Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааг 1730 гаруй ажилтнаас ярилцлагын болон асуулгын аргаар авч, нэгтгэв;

-Иргэний сэтгэл ханамжийн судалгааг төрийн үйлчилгээ авсан 430 гаруй иргэнээс асуулгын аргаар авч, дүгнэв. Мөн гадаад болон дотоод орчны шинжилгээг 36 байгууллагад хийж, тухайн цаг үед үйлчилгээ авч байсан 245 иргэний үйлчилгээ авах процесст тандалт судалгаа хийв.

-Зардал, үр ашгийн шинжилгээг есөн дүүрэг, 21 аймгийн хөдөлмөр халамж, нийгмийн даатгалын байгууллагуудын ачаалал, зардлаар болон иргэнд ноогдох зардлын харьцаагаар гаргав;

Асуудлын судалгааг дээрх шинжилгээ, судалгаагаар хамгийн өндөр эрсдэл, үл нийцэл, асуудал бүртгэгдсэн үйлчилгээ, үйл ажиллагаа тус бүрээр хийлээ.

Эдгээр судалгаа, шинжилгээнд үндэслэн процессын дахин инженерчлэлийг хэрэгжүүлэх саналыг гаргасан. Нийт 211 төрийн үйлчилгээг үзүүлэхэд нэг үйлчилгээ нь дунджаар 20 дотоод үйл явцыг дамждаг байсныг тус бүр 6-10 болгон цөөрүүлэх, үйлчилгээний хамтарсан төвийн зохион байгуулалтаар нийгмийн даатгал, халамж, хөдөлмөрийн үйлчилгээг үзүүлэх, яамны болон агентлагийн зохион байгуулалтын бүтцийг давхардуулалгүй, үр нөлөөтэй, үр ашигтай хэлбэрээр зохион байгуулах, нийслэлд салбар бүрээр Засгийн газрын агентлаг, нийслэлийн

Төрийн албан хаагчийн сэтгэл ханамж хоёр хувиар дээшлэхэд иргэдийн сэтгэл ханамж нэг хувиар дээшилдэг

агентлаг, дүүргийн газар, хэлтэс давхардсан бүтэцтэй үүрэг гүйцэтгэж байгааг өөрчилж, давхардлыг арилгах, нийт 211 үйлчилгээнд иргэний бүрдүүлдэг баримт бичгийн 70 хувь нь төрд байгаа мэдээлэл тул холбогдох 53 баримт бичгийг иргэдээс шаарддаггүй болох зэрэг асуудлыг энэхүү саналд тусгасан байна.


Санал болгож буюу эдгээр шийдлийг хэрэгжүүлснээр төр, иргэдийн харилцан сэтгэл ханамж, төрийн албан хаагчдын ажлын бүтээмж дээшлэх, хүнд суртал, авлига, ажлын ачаалал буурах, илүү энгийн процесст шилжих зэрэг ач холбогдолтой юм. Олон улсын буюу Канадын жишээг дурдахад төрийн албан хаагчийн сэтгэл ханамж хоёр хувиар дээшлэхэд иргэдийн сэтгэл ханамж нэг хувиар дээшилдэг гэсэн судалгаа байдаг. Тиймээс процессын хоёр талын оролцогчдын сэтгэл ханамжийг зэрэг дээшлүүлснээр төрийн үйлчилгээ ил тод, асуудалгүй, амар хялбар явагдах боломж бүрдэнэ.

Орчин үед төрийн албанд байнгын сайжруулалтын тогтолцоог бий болгох, гарцаас гадна үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарч байгаа бөгөөд хувийн хэвшлийн аж ахуй нэгж, байгууллагууд дотоод бүтэцдээ процессын дахин инженерчлэлийн асуудал хариуцсан нэгжтэй байдаг шиг төрийн байгууллагууд мөн адил хариуцсан нэгжтэй, байгууллагын соёлыг бий болгох хэрэгтэй байна.

Процессын дахин инженерчлэлийг зөв зохистой хийснээр төрийн үйлчилгээг авахын тулд иргэдийн туулдаг үйл явц, процессын тоо багасах; төрийн нэг үйлчилгээг хүргэхэд иргэн нэгээс илүүгүй төрийн албан хаагчтай уулзах зарчмыг хангах; төрийн үйлчилгээ үзүүлэх албан хаагчийн ажлын ачааллыг илүү тэнцвэртэй, хүндрэл багатай зохион байгуулах; байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалтыг илүү оновчтой, үр дүнтэй болгох; төрийн албаны бүтээмж дээшилж, төрийн үйлчилгээ үзүүлж буй албан хаагч, үйлчилгээ авч буй иргэн нь харилцан сэтгэл ханамжтай байх; төрийн байгууллагуудын дундын үйлчилгээ, менежмент зэрэг орчин үеийн төрийн үйлчилгээний хандлага, менежмент, сайн түршлагыг салбарын үйл ажиллагаанд хэрэгжүүлэх зэрэг зорилт богино хугацаанд хэрэгжих нөхцөл байдал үүсэх юм. ■

СУДАЛГАА-1

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖЛААС ГАРАХ ТӨЛӨВИЙГ ЗАГВАРЧЛАХ НЬ



МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТЭС



Төрийн албан хаагчийн ажлаас гарах төлөвийг загварчлах нь


Монгол Улсын төрийн албаны чадамжийг дээшлүүлэх ажлын хүрээнд Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төвөөс Төрийн албаны зөвлөл, Сангийн яам болон Боловсрол, шинжлэх ухааны яамны задгай өгөгдлүүдэд орчин үеийн “machine learning” буюу машин сургалтын загварыг ашиглан төрийн албан хаагчдын ажлаас гарах магадлал өндөртэй бүлгүүдийг тодорхойлж, урьдчилсан таамаг дэвшүүлж дүн шинжилгээ хийлээ. Дүн шинжилгээг дараах үндсэн мэдээллүүдийн хүрээнд боловсруулав. Үүнд:

- Төрийн албан хаагчдын ерөнхий мэдээлэл (2022 оны 10 сарын 10-ны өдрөөр)
- Төрийн албан хаагчдын ажлаас чөлөөлөгдсөн түүх
- Төрийн албанд элссэн түүх
- 2020–2022 онуудын албан хаагчдын цалин, урамшуулал, нэмэгдэл хөлс
- Төрийн албан хаагчдын их, дээд сургуулийн голч дүн

Төрийн албанаас гарсан албан хаагчийг тодорхойлохдоо өгөгдөл хүлээн авахад ажиллаж байсан боловч түүнээс хойш 4 сарын хугацаанд ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын тохиолдлоор судалгааны хүрээг тогтоов.

Жич: Нууцлалтай холбоотойгоор төрийн тусгай албан хаагчдын мэдээллийг судалгаанд ашиглаагүй болно

Зураг 1.1. Төрийн албанаас гарсан албан хаагчийг тодорхойлох схем




Улсын хэмжээнд ажлаас гаралтын хувь

4.4% ▶ **185,825**
дөрвөн сарын хугацаанд
жилд ▶ 13.2%

1. Ажлаас гарах статистик үзүүлэлтүүд

2022 оны 10 дугаар сарын 10-ны байдлаар Монгол Улсын хэмжээнд төрийн тусгай албан хаагчдыг хассан дүнгээр нийт 185,862 албан хаагч байсан бөгөөд үүнээс дараагийн 4 сарын хугацаанд 4.4 хувь нь буюу 8,176 албан хаагч төрийн албанаас гарсан байна.

График 1.1 Ажлаас гаралтын хувь /насны бүлгээр/




Төрийн албанаас гарсан албан хаагчдыг насны бүлэг болон хүйсээр ангилахад 19-27 насны албан хаагчид хамгийн өндөр хувьтай байх бөгөөд 40-өөс дээш насныхан тогтвор суурьшилтай ажиллаж байна. Энэ дүр зураг нь зөвхөн төрийн албанд бус мөн хувийн хэвшил ч ижил байх магадлалтай. Иймд төрийн албаны энэхүү дүр зургийг хувийн хэвшилтэй харьцуулснаар илүү нарийвчилсан дүгнэлт хийх боломжтой юм.

2. Төрийн албанаас гарах өндөр магадлалтай албан хаагчдыг урьдчилан таамаглах

Төрийн албанаас гарах өндөр магадлалтай албан хаагчдыг таамаглахдаа машин сургалт, эконометрикийн салбарт хамгийн өргөн ашиглагддаг “Logistic regression” буюу “суурь загвар”-ын аргыг сонгож тооцоолол хийн сүүлийн жилүүдэд олон салбарт томоохон дэвшлүүдийг авчраад буй “Neural Network” загвар ашиглан тооцоолсон дүнтэй харьцууллаа.

График 1.2. Ажлаас гаралтын хувь, хүйсээр, төрийн албаны ангиллаар



3. Загварын үнэлгээ

Тестийн өгөгдлийг “Logistic regression” загвараар үнэлэхэд 92 хувийн оновчтой./Хүснэгт 1./ “Logistic Regression” загварыг ашиглаж гарсан үр дүн сайн байгаа хэдий ч төрийн албанаас гарсан албан хаагчдын тоо төрийн албанд үлдсэн албан хаагчдын тооноос хэд дахин бага байгаа тохиолдолд нэг аргачлалаар шууд дүгнэлт хийх нь тохиромжгүй юм.

Загварт ашигласан хувьсагчид

- Нас,
- Хүйс
- Улсад ажилласан жил,
- Төрд ажилласан жил,
- Байгууллагад ажилласан жил,
- Аймаг,
- Төрийн албанд зэрэг хашиж буй албан үүргийн тоо,
- Сүүлийн 6 сар авсан дундаж цалин... гэх мэт

ТЕСТ ДАТАНЫ
ХЭМЖЭЭ:
25%

Тус загварыг үнэлэх явцад тухайн загварын зорилгоос хамааран ямар үнэлгээний арга хэрэгслийг ашиглахыг шийддэг. Тухайлбал, аливаа загварыг сургахад ашигласан өгөгдөл нь “imbalanced” буюу тааварлахыг зорьж буй хувьсагчийн ангилал бүрд харгалзах өгөгдлийн хэмжээ тэнцвэргүй үед “Precision”, “Sensitivity”, “F1” гэх зэрэг үзүүлэлтийг авч үздэг.

Хүснэгт 1.1. /Logistic regression – Confusion matrix/

	Загвараар таамагласан		Accuracy: 92.0%	
	Гарна	Үлдэнэ		
Ажиглалтын хугацаанд Тө.Албаас гарсан	0.8%	4.0%	Sensitivity	15%
Ажиглалтын хугацаанд Тө.Албаас гараагүй	4.0%	91.3%	Specificity	96%
Precision:		Negative Predictive Value:		
14.9%		95.8%		

Хүний тархины сурах чадварын процессыг дүүрайлгасан математик загвар буюу Neural Network нь сүүлийн жилүүдэд дэлхий даяар хиймэл оюун ухааны салбар хөгжих, олон салбарт гараад буй хувьсгалуудын хамгийн чухал хүчин зүйлүүдийн нэг болоод байна. Тэгвэл манай улсад ч мөн хиймэл оюун ухаан олон салбарт нэвтэрч, бид судалгааны ажилд ашиглаж байна.

Neural network загварыг хөгжүүлэхэд маш олон байдлаар, өөр өөр бүтэцтэй загваруудыг үүсгэж болдог ба ямар бүтэцтэй байх болон ямар “hyperparameter”-үүдтэй байхыг сонгох нь хүндрэлтэй байдаг. Нарийн төвөгтэй олон давхаргатай сүлжээний бүтэц сонгож болох хэдий ч загварыг томруулснаар гарч буй үр дүнд онцын сайжруулалт гарахгүй байсан тул 2 нууц давхаргатай /hidden layer/ бүрэн холбогдсон сүлжээг сонгосон. Ингэхэд хамгийн сайн үр дүнг “NN (оролтын тоо, 64, dropout = 0.2, 8,1), adam optimizer, class weights = {‘төрийн албанаас гарсан’:12, ‘төрийн албан үлдсэн’:1}” загвар үзүүлсэн /Хүснэгт 1.3/. Тус загварын үр дүнд 94.1 хувь оновчтой, мөн “Precision” 17 хувь болж “Logistic Regression” загварыг давсан үзүүлэлт гарсан. /Хүснэгт 1.2/

Хүснэгт 1.2. /Neural Network (i, 64, 8, 1) – Confusion matrix/

	Загвараар таамагласан		Accuracy: 94.1%	
	Гарна	Үлдэнэ		
Ажиглалтын хугацаанд Тө.Албаас гарсан	0.3%	4%	Sensitivity	7%
Ажиглалтын хугацаанд Тө.Албаас гараагүй	1.6%	94%	Specificity	98%
	Precision:	Negative Predictive Value:		
	17.0%	95.6%		


Хүснэгт 1.3. Оптималчлалын функц болон сургалтын явц дах ангиллуудын жин

Optimizer	Adam			SGD		
Class weight ratio	Accuracy	Precision	Sensitivity	Accuracy	Precision	Sensitivity
{5:1}	95%	6%	5%	95%	13%	5%
{6:1}	95%	14%	5%	95%	16%	5%
{7:1}	92%	13%	4%	95%	3%	5%
{8:1}	95%	9%	5%	87%	11%	4%
{9:1}	95%	0%	5%	95%	16%	5%
{10:1}	93%	14%	4%	90%	12%	4%
{11:1}	95%	17%	5%	93%	14%	4%
{12:1}	94%	17%	7%	89%	11%	4%
{13:1}	61%	7%	3%	92%	13%	4%
{14:1}	74%	9%	3%	87%	10%	4%

Төрийн албанаас гарч болзошгүй албан хаагчдыг урьдчилан таамаглах судалгааны үр дүнд боловсруулсан загварууд маань өндөр оновчлолтой байсан. Тэдгээр загварыг ашиглан төрийн албанд ажиллаж байгаа өндөр үр чадвартай албан хаагчдыг төрийн албанаас гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой. Харин өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд уг асуудлыг хэрхэн зохицуулж, хэрэгжүүлэх нь тодорхойгүй тул цаашид анхаарах шаардлагатай юм.

Судалгаагаар чамлахааргүй үр дүнгүүд гарч байгаа боловч загварчлалд ашигласан хувьсагчид хатуу шинж чанартай, цаг хугацааны туршид төдийлөн өөрчлөгдөхгүй тул (Жишээ нь, хүйс, аймаг, нас, туршлага) энэ загварууд хамгийн төгс бус, учир дутагдалтай талууд ч мөн бий. Иймээс төрийн албан хаагчидтай биеэр уулзаж, албан хаагчдын ажиллах орчин, нөхцөл байдлыг судалж, тэдний оролцоотойгоор төрийн албандаа тогтвор суурьшилтай ажиллахад нь юу саад болж байгаа, юу дэмжлэг болж болох, төрийн албанаас, ажлаасаа гарахад ямар хүчин зүйлүүд нөлөөлж байгааг төрийн албан хаагчдын цахим болон ярилцлагын судалгаануудаар дэлгэрүүлж судалсан юм.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРТ ХИЙСЭН ПРОЦЕССЫН ДАХИН ИНЖЕНЕРЧЛЭЛ



НОГООН, БҮТЭЭМЖТЭЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ГАЗАР



2.2), 2023 оны 6 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд процессын дахин инженерчлэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

"Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" УТҮГ-ын албан хаагчдаас Эрсдэлийн үнэлгээний баг, Сэтгэл ханамжийн судалгааны баг, Ажлын байрны зураг авалтын багуудыг тус тус ахалж ажиллав. Салбарын хэмжээнд сум, дүүргийн анхан шатны нэгжээс яам хүртэлх бүх байгууллагад, цөөн хүнтэй багаар богино хугацаанд урьд өмнө нь цогцоороо хийгдэж байгаагүй процессын дахин инженерчлэлийг анх удаа хийснээрээ онцлог ач холбогдолтой болсон юм.

Нийгмийн даатгал, хөдөлмөр, халамжийн 211 үйлчилгээний процессын зургийг зурж (Хүснэгт 2.1), ажлын байрны зураг авч, чиг үүргийн давхардал, иргэд болон албан хаагчдын сэтгэл ханамжийг тодорхойлж, үйлчилгээ бүрийн эрсдэлийг үнэллээ. Нийгмийн даатгалын 96, нийгмийн халамжийн 72 үйлчилгээний 68-70 хувь нь иргэдээс цаасан баримт шаарддаг байна. Үүнээс 53 үйлчилгээнд иргэдээс цаасан баримт шаардахгүйгээр үйлчилгээ үзүүлэх боломжтойг тодорхойлов. Нийгмийн даатгалын үйлчилгээнүүд дунджаар 22 алхамтай байсныг 6 болгож цөөлөх буюу иргэдэд хүндрэлгүй, түргэн шуурхай

Хүснэгт 2.1 Салбарын үйлчилгээний тоо

Салбар	Үйлчилгээний тоо
Нийгмийн даатгал	96
Нийгмийн халамж	72
Хөдөлмөр	43
Нийт	211

болгох, харьяалал харгалзахгүй нийгмийн хамгааллын үйлчилгээг хүргэх боломжтой зэргийг тогтоолоо.

Мөн “Нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” байгуулж нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээний хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлэх, тодорхой төрлийн үйлчилгээнүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх, нийгмийн даатгал болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагуудын чиг үүргийн давхардлыг арилгах, эрсдэлийн менежментийг нэвтрүүлэх, үйлчилгээний сонголтыг олон төрөлтэй болгох зэрэг саналуудыг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулж Монгол Улсын Засгийн газарт танилцуулсан. Үүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг богино, дунд, урт хугацаанд ангилан 2024 оны 1 дүгээр сараас эхний алхмуудыг хэрэгжүүлж эхлэхээр салбарын яам, холбогдох байгууллагууд ажиллаж эхлээд байна.

Төрийн үйлчилгээг сайжруулахаар хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүд иргэн төвтэй байхад анхаарч, иргэний сэтгэл ханамжийг чухалчлах нь дийлэнх байв. Энэ удаад иргэн болон төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийг хамтад нь чухалчлан процессын дахин инженерчлэлийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт эхлүүлж, энэхүү туршлага дээрээ үндэслэн шаардлагатай бусад салбарт үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн.

Процессын дахин инженерчлэлийн судалгааг дараах үндсэн 4 чиглэлээр хийв. Үүнд:

- 1. Эрсдэлийн үнэлгээ,
 - 2. Ажлын байрны зураг авалт,
 - 3. Сэтгэл ханамжийн судалгаа,
 - 4. Чиг үүргийн судалгаа
- Судалгаа тус бүрийн онцлох үр дүнгүүдээс дурдвал:

Эрсдэлийн үнэлгээ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт төрийн үйлчилгээг иргэнд хүргэх, албан хаагч чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч буй нийт 1999 эрсдэл бүртгэгдэв (Зураг 2.3). Тус эрсдэлүүдийг байгууллагын дотоод болон бусад хяналт шалгалтын тайлангууд, албан хаагчидтай ганцаарчилж хийсэн ярилцлага, албан хаагчдын дунд зохион байгуулсан багийн ажил, хэлэлцүүлэг, тандалт судалгаа зэрэг олон талын эх сурвалжийг үндэслэн тогтоож бүртгэсэн болно.

Ингэхдээ MNS ISO 31000:2020 стандартыг удирдлага болгож, бүртгэгдсэн тохиолдол бүрийг нөлөөлөл,

давамжийн харилцан хамаарлаар үнэлж, эрсдэлийн матрицад суурилан хамгийн өндөр эрсдэлтэй үйлчилгээнүүдийг тодорхойлов.

Тухайлбал, нийгмийн даатгалын үйлчилгээнүүдээс Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, тэтгэмж, тэтгэврийн үйлчилгээнүүд хамгийн өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Хөдөлмөрийн үйлчилгээнүүдээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нь хугацаандаа төлөөгүй төлбөрийн үлдэгдэл их, төсөл сонгон шалгаруулах үйл явц боловсронгуй бус, төлбөр төлөгч гадаадад гарсан, нас барсан тохиолдолд төлбөрийг барагдуулах боломж

Зураг 2.3 Эрсдэлийн үнэлгээ

үүсдэггүй, шүүхийн журмаар өр барагдуулахад чиг үүргийн бус ажлыг мэргэжлийн бус албан хаагч хариуцаж улмаар ажлын ачаалал нь нэмэгддэг зэрэг нөхцөл байдлууд өндөр эрсдэлтэйд тооцогдоход нөлөөлж байна. Халамжийн үйлчилгээний хувьд асаргааны тэтгэмж, ахмад настанд олгох дэмжлэг, хөнгөлөлтийн үйлчилгээ нь өндөр эрсдэлтэй болох нь тогтоогдов (Зураг 2.4). Ийнхүү үйлчилгээ бүрд бүртгэгдсэн эрсдэлийг үнэлж тэдгээрийн шалтгаан, нөхцөлүүдийг тодруулав.

Албан хаагчдаас авсан цахим судалгаанд нийт 765 хүн хамрагдсан. Тэд байгууллагын дотоод үйл ажиллагааны зохион байгуулалт, дээд шатны байгууллага, удирдлагуудын гэнэтийн, уялдаа холбоогүй шийдвэрүүдээс үүдэлтэй эрсдэлүүд хамгийн их байдаг гэж хариулав (Зураг 2.5).

Зураг 2.4 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хамгийн өндөр эрсдэл бүртгэгдсэн үйлчилгээнүүд

Даатгалын үйлчилгээ	Халамжийн үйлчилгээ	Хөдөлмөрийн үйлчилгээ
Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс	Ахмад настанд олгох дэмжлэг, хөнгөлөлтийн үйлчилгээ	Санхүүгийн дэмжлэг үзүүлэх
Тэтгэвэр тогтоох, жил шалган баталгаажуулах, материал хүлээж авах	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ
Ажилгүйдлийн тэтгэмж	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	Ажилд зуучлах

Зураг 2.5 Эрсдэлийн цахим судалгааны дүнгээс:

Цахим судалгаанд хамрагдагсдын 82.4 хувь нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх боломжгүй буюу тогтолцоо бүрдээгүй, 72.6 хувь нь энэ талаар сургалт, мэдээлэл авч байгаагүй, 76.4 хувь нь ажиллаж буй байгууллагадаа эрсдэлийн удирдлагын бодлого зохицуулалт шаардлагатай гэж хариулжээ. Энэхүү судалгааны дүн тус салбарт эрсдэлийн удирдлагын менежмент зайлшгүй шаардлагатайг илтгэж байна. Мөн бүртгэгдсэн эрсдэлийн тохиолдлууд, тэдгээртэй холбоотой санхүүгийн хохирол, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдсэн хэрэг маргаанууд эрсдэлийн удирдлагын тогтолцоо шаардлагатай болохыг давхар нотолсон юм.

Эрсдэлийн үнэлгээгээр процессыг нь дахин инженерчлэх шаардлагатай үйлчилгээнүүдийг шалтгаан нөхцөл, эрсдэлийн давтамж, нөлөөллийн харилцан хамаарлын үнэлгээнд үндэслэн тодорхойлсон юм.

Иргэн болон албан хаагчийн сэтгэл ханамж

Процессын дахин инженерчлэлийн ажлын хүрээнд иргэдийн сэтгэл ханамжийг тодруулах замаар тэдэнд тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийг олж тогтоов. Мөн төрийн албан хаагчдын сэтгэл ханамжийг судалснаараа урьд өмнө нь хийгдэж байсан судалгаануудаас онцлог болсон гэж үзэж байна.

Үйлчилгээ авахаар ирсэн 432 иргэн болон аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж ярилцав. Тэдгээр иргэдийн 75.5 хувь нь үйлчилгээний сэтгэл ханамж сайн, 66.9 хувь нь үйлчилгээ авахад хүндрэл тулгараагүй гэсэн юм. Гэвч үйлчилгээний тухай мэдээлэл авах эхний алхмаас үйлчилгээг бүрэн авч дуусах хүртэл дараах нийтлэг хүндрэлүүд (Зураг 2.6) тулгардаг байна. Үүнд:


Албан хаагчдын хувьд үйлчилгээ үзүүлж буй бүх шатны ажиллагсдыг хамруулахыг зорьсон бөгөөд цахим судалгаанд давхардсан тоогоор 2455 албан хаагч, ярилцлагад 360 албан хаагч хамрагдав.

Анхан шатандажиллаж буй албан хаагчдад тулгарч буй хүндрэлийн 22.1 хувь нь иргэдийн харилцаа хандлагатай холбоотой гэсэн хариулт хамгийн өндөр хувийг эзэлж байна (График 2.1). Удаах хүндрэлүүдэд ажлын ачаалал, салбарын хууль тогтоомж, дүрэм журам хоорондын нийцэл зэргийг нэрлэсэн байна. Мөн анхан шатны албан хаагчдын 99.7 хувь нь ажлаасаа болж стресст орж байсан бол 90.1 хувь нь ачаалал ихтэй байдаг гэжээ.

Зураг 2.6 Иргэний хүндрэл



График 2.1 Анхан шатны төрийн албан хаагчдад тулгарч буй хүндрэл




Нийгмийн даатгалын анхан шатны нэгжид ажиллаж буй албан хаагчид жилд 43 болон түүнээс дээш тооны өөр төрлийн тайлан, мэдээ, судалгааг гаргаж, дунджаар 175 удаа дээд шатны байгууллагад хүргүүлдэг байна (Зураг 2.7). Тайлан, мэдээ, судалгаа гаргах нэгдсэн программгүй тул цаг хугацаа их зарцуулж, ажлын ачаалал нэмэгдэхэд нөлөөлдөг аж.

Судалгаа, тайлан, мэдээг цахим болон цаасан хэлбэрээр авдаг хэдий ч тэднээс хугацаа тулгаж шаарддаг нь хүндрэл учруулдаг гэж судалгаанд оролцогсдын 61.7 хувь нь хариулжээ. Харин дээд шатны байгууллагад ажиллаж буй албан хаагчдын 80.9 хувь нь ирсэн тайлан, мэдээ, судалгаанд эргэлздэг гэжээ. Дээд шатны байгууллагаас бодлого, хууль, дүрэм, журам боловсруулахдаа анхан шатны нэгжид ажиллаж буй албан хаагчдаас санал авдаг гэж 73.8 хувь нь хариулсан боловч тэдний саналыг тусгасан байдалд 62.6 хувь нь дунд болон түүнээс бага үнэлгээ өгсөн байна.

Албан хаагчийн сэтгэл ханамж 2 хувиар нэмэгдэхэд үйлчилгээ авч буй иргэний сэтгэл ханамж 1 хувиар дээшилдэг гэсэн судалгаа бий. Зөвхөн хэрэглэгч, үйлчлүүлэгч төвтэй бус иргэн болон албан хаагчдын сэтгэл ханамжийг хамтад нь анхаарч судлан, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх арга хэмжээний суурь судалгааг процессын дахин инженерчлэлээр хийсэн болно.

Зураг 2.7 Тайлан, мэдээ, судалгааны давхардал



Ажлын байрны зураг авалт

Албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын ачаалал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, үйлчилгээ авахаар ирж буй иргэдийн хэрэгцээ, зорилгод нийцүүлэн чанартай үйлчилж байгаа эсэхийг ажиглалтын аргаар судлан илрүүлэхийн тулд ажлын байран дахь үйл ажиллагааны тэмдэглэл хөтөлж, ажлын байрны зураг авалт хийв.

Нийгмийн даатгалын 21 албан тушаалын 43 албан хаагчийн нэг өдрийн ажлын байран дахь зураг авалтаар 310 цагийн 3,910 үйлдэл бүртгэгдсэн. Үүнээс чиг үүргийн бус, ажилтны хувийн зохион байгуулалттай холбоотой 366 үйлдлийг хасаж үлдсэн 243 цагийн 3544 үйлдэлд анализ хийхэд ажилбарт 193 цаг, зөвлөгөө мэдээлэл

өгөхөд 50 цаг тус тус зарцуулсан байна. Харин ажилбар хийсэн нийт 55:03:53 цаг буюу 28 хувийг өндөр насны тэтгэвэр эзэлж байгаа бөгөөд тус үйлчилгээ нь өөр хоорондоо ялгаатай 40 дэд хэсгээс бүрддэг байна.

Хөдөлмөр, халамжийн 32 албан тушаалын 50 албан хаагчийн ажлын байрны зураг авалтаар 295 цагийн 3031 үйлдэл бүртгэгдсэнээс чиг үүргийн бус, ажилтны хувийн

зохион байгуулалттай холбоотой үйлдэлд зарцуулсан 490 үйлдлийг хасаж үлдсэн 225 цагийн 2541 үйлдэлд анализ хийхэд ажилбарт 177 цаг, зөвлөгөө, мэдээлэл өгөхөд 47 цаг зарцуулсан байна. Харин ажилбар хийсэн нийт цагаас 38:28:47 буюу 21.6 хувийг бусад үйлчилгээ буюу удирдлагаас өгсөн үүрэг, судалгаа, албан бичиг боловсруулах зэрэг ажлууд эзэлж байна.

Чиг үүргийн шинжилгээ

Чиг үүргийн шинжилгээгээр баримт бичигт дүн шинжилгээ хийж, албан хаагчидтай чиг үүргийн давхардлыг тодорхойлох зорилгоор ярилцлага хийв. Нийгмийн даатгал, хөдөлмөр, халамжийн үйлчилгээнүүдийн процессын шинжилгээг чиг үүргийн хуваарилалт, бүтэц орон тоо, ажлын байрны тодорхойлолтод тулгуурлан нэгжийн ажилтнуудын үүрэг оролцоо, хариуцлагын хүрээ, ажлын ачаалал, давхардлыг “RACI” матрицын аргаар тодорхойлсон.

Хүснэгт 2.2 Чиг үүргийн давхцалтай үйлчилгээ


Салбар	Үйлчилгээний тоо	Чиг үүргийн давхцалтай үйлчилгээ
Нийгмийн даатгал	96	37
Нийгмийн халамж	72	7
Хөдөлмөр	43	21
Нийт	211	65

2023 оны байдлаар нийгмийн даатгалын 96, нийгмийн халамжийн 72, хөдөлмөрийн 43, нийт 211 үйлчилгээг төрөөс үзүүлж байна (Хүснэгт 2.2). Үүнээс нийгмийн даатгалын 37, нийгмийн халамжийн 7, хөдөлмөрийн 21 үйлчилгээ чиг үүргийн давхцалтай байгаа нь тогтоогдов.

СУДАЛГААНЫ ҮР ДҮНД

2023 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хийсэн процессын дахин инженерчлэлийн ажлын үр дүнг танилцуулав. Ажлын хэсэг төрийн үйлчилгээг сайжруулах богино, дунд, урт хугацааны дараах шийдлүүдийг санал болгон дэвшүүлсэн бөгөөд 2024 оны 1 дүгээр сараас эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны түвшинд тодорхой ажлуудыг хийж эхлээд байна (Зураг 2.8).

Зураг 2.8 Өөрчлөх, сайжруулах санал



ДАРААХ

ЭХХ болон ЭХМК-ын хурал хэнийг болон юуг хянах гэж байдаг вэ?

Эмч болон эмчийн гаргасан шийдвэрийг хянах

ПДИ-ЫН САНАЛ:

ЭХХ болон ЭХМК-ийн хурлуудыг нэгтгэх

Иргэн дахин биеэр ирж хурлаар орох процессыг халах

Санаатай бүрүү шийдвэр гаргасан эмчид хариуцлагын тогтолцоог тодорхой болгох

ҮР ДҮН:

Иргэний хүлээлт, дамжлага байхгүй

ЭХХ болон ЭХМК хурлуудын чиг үүргийн давхардал арилна

Хариуцлагын тогтолцоо сайжирч шийдвэр гаргалт эзэн биетэй болно

Дотоод дамжлага 2.5 дахин багасна

ЭХМК-т байдаг шаардлагагүй гишүүдийг хасаж НДХ-ийн дарга, Үйлдвэрчин,

Зураг 2.9 Өөрчлөх, сайжруулах санал


ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ПРОЦЕССЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ ОДОО		ӨӨРЧЛӨХ, САЙЖРУУЛАХ САНАЛ ДАРАА
1. Төрийн системд байгаа мэдээллийг цаасаар ДАХИН авах процесс	Цахимд байгаа ХХҮГ-35%, НД-30%/	Төр өөрт байгаа мэдээллийг дахин авахгүй байх боломжтой процесс
2. Төрийн үйлчилгээний байгууллагаас баримт бүрдүүлэх, олон шат дамжлагын процесс	20 гаруй удаа ирэх, явах	2-с дээш удаа ирэхгүй байх боломжтой процессыг бий болгох /1:1 ЗАРЧИМ/
3. НД-ийн шимтгэл төлөлттэй холбоотой өр үүсдэг процесс	Хагас их наяд төгрөгийн өр – 440 тэрбум	Өр үүсэхгүй байх боломжтой процессыг боловсруулан санал болгож байна.
4. Нийгмийн даатгал, хөдөлмөр, халамжийн үйлчилгээг харьяаллын дагуу үзүүлдэг процесс	Өөрийн дүүрэг, хороо	НД-ын үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлэх боломжтой процесс -Дүүрэг, Аймаг
5. Төрийн хийх шаардлагагүй олон төрлийн үйлчилгээ, процесс	Excel sheet-Хөдөлмөр, бусад	Нэгтгэх, багцлах, хувийн хэвшилд шилжүүлэх, хамтран хийх г.м.
6. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмж	Одоогийн хүртээмж 360 цэгт	Үйлчилгээний хүртээмжийг 2 дахин нэмэгдүүлэх боломжтой процесс /720 цэг/
7. Эмнэлэг хяналтын болон ЭХМКомиссын хурлын процесст иргэд биечлэн ирж оролцдог	Сар бүр дунджаар 6500 иргэн	Нэг ч иргэн хуралд оролцохгүй байх боломжтой процесс
8. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээг авах гэж иргэд хүлээдэг	Иргэдийн 68% нь хүлээдэг	Шинэ процессын зураглалаар хүлээх хугацааг багасгах боломжтой
9. Иргэдийн гомдол, саналыг шийдвэрлэх бус дамжуулах, шилжүүлэх процесс	75% нь шийдвэрлэдэггүй	Төр үйлчилгээний сонголтыг олон төрөлтэй болгох боломжтой
10. Төрийн үйлчилгээтэй холбоотой иргэдийн утсаарх дуудлага алдалт	Иргэдийн залгасан дуудлага алдалт 98%	Төр үйлчилгээний процесст дуудлага алдалтыг 0% болгох боломжтой процесс
11. Төрийн албан хаагчийн иргэдэд үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой ёс зүйн асуудал	Асуудал их гэж судалгаагаар гарсан	Харилцагчийн үйлчилгээний стандарт, ажлын гүйцэтгэлтэй уях
12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний ажлын цаг	Ажлын 8 цагт үйлчилгээ үзүүлэх	Нийгмийн хамгааллын үйлчилгээний төв байгуулснаар ажлын цаг уртсах, үр ашигт үйлчилгээний олон улсын тогтолцоо руу шилжих
13. Иргэд үйлчилгээ авахтай холбоотой архивын лавлагаа авдаг процесс	Иргэн өөрөө архивын материалаас авдаг	Төр иргэний өмнөөс архивын лавлагааг авах боломжтой процессыг бий болгосноор иргэдийн ачаалал багасгах, г.м
14. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээ иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангадаг эсэх	Үгүй, иргэдийн бухимдал, гомдол	Нийгмийн хамгааллын үйлчилгээг шинэчлэх, өөрчлөх, дахин боловсруулах процесс – одоогийн үйлчилгээг дахин судлах
15. Нийгмийн хамгааллын салбарын уялдаа холбоо, чиг үүрэг г.м	Чиг үүргүүд давхардалтай	Нийгмийн хамгааллын салбарын бүхий л чиг үүргүүдийн давхардлыг арилгах процесс – бүх түвшинд чиг үүргийн давхардлыг арилгана.
16. 9 дүүрэг, 21 аймгийн нийгмийн хамгааллын үйлчилгээнд үүссэн хяналт шалгалтын давхардал	Процессын шинжилгээ, үр дүн	Хяналт шалгалтын давхардлыг арилгах боломжтой процесс, үйлчилгээний төв – үйлчилгээний төвд дахин ачаалалгүй болно.
17. Нийгмийн хамгааллын салбарын нэгжүүдийн маш их гаргадаг, тайлан мэдээ, судалгаа г.м.	43 тайлан, мэдээ, 175 удаа явуулах	Зохистой тайлан мэдээ гаргах боломжтой процесс – тайлан, мэдээний зохистой түвшинг тодорхойлж өгнө.
18. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийг тодорхойлох, бүртгэх, үнэлэх, эрэмбэлэх асуудал	Процессын шинжилгээ, үр дүн	Эрсдэлийн удирдлагын тогтолцооны өөрчлөлтийг салбарт бий болгох – салбарын түвшинд эрсдэлийг удирддаг болно.
19. Төрийн захиргааны байгууллагын хэлбэртэй тогтолцооны процесс	Процессын шинжилгээ, үр дүн	Төрийн үйлчилгээний хэлбэртэй процесс болгох боломжтой – Төрийн захиргааны процессоос үйлчилгээний процесс руу шилжих болно.

Шийдлүүд хэрэгжсэнээр /иргэнд/ (Зураг 2.8, 2.9, 2.10)

- Иргэнд төрийн үйлчилгээг асуух бүс төр үйлчилгээгээ санал болгодог болно.
- Төрийн үйлчилгээний стандартыг өөрчилснөөр иргэдэд хүргэж байгаа төрийн үйлчилгээг энгийн, хялбар, ил тод болгоно.

- Иргэн төрийн үйлчилгээг авахын тулд зарцуулж буй цаг, дамждаг үйл явц, процессын тоог багасгах.
- Иргэн төрийн үйлчилгээг авахдаа нэгээс илүүгүй төрийн албан хаагчтай уулзах.
- Төрийн системд байгаа мэдээллийг иргэнээс цаасаар дахин авахгүй байх.

Зураг 2.10 Процессын зураг, өмнөх болон дараах



Шийдлүүд хэрэгжсэнээр /албан хаагчдад/ (Зураг 2.8, 2.9, 2.10)

- Төр хийх шаардлагагүй үйлчилгээнүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх.
- Хяналт шалгалтын давхардлыг арилгах.
- Тайлан, мэдээний зохистой түвшнийг тодорхойлох.

Нийгмийн даатгалын үйлчилгээний одоогийн процессын дарааллыг зурж ирээдүйд өөрчлөх боломжтой процессыг шинэчлэн дээрх (Зураг 2.10) байдлаар зурав. Энэ мэтчилэн нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн үйлчилгээний процессуудын дахин инженерчилсэн зургийг боловсруулсан болно.

ТӨРИЙН АЛБАНЫ ЧАНАРЫН СУДАЛГАА



НОГООН, БҮТЭЭМЖТЭЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ГАЗАР



Төрийн албан хаагчдын 27.1 хувь нь төрийн албанаас гарах сэдэлтэй байна

“Шинэ сэргэлтийн бодлогын хүрдасгуур төв” УТҮГ нь Төрийн албаны зөвлөл, Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яамтай хамтран төрийн албан хаагчдын тоон мэдээлэл (2022 оны 9 дүгээр сарын байдлаар)-д тулгуурлан “Төрийн албан хаагчийн тоон мэдээлэл дээрх судалгаа”-г хийлээ. Тус судалгааны хүрээнд төрийн албанаас гарах магадлалтай албан хаагчдыг таамаглах зорилгоор загварын тооцоолол боловсруулсан. Уг загвараар төрийн албанаас гарах магадлалтай албан хаагчдыг нас, боловсролын зэрэг, ажилласан жил, түршлага зэргээр ангилан таамаглал дэвшүүлэх боломж бүрдсэн юм.

Дээд боловсролын гэрчилгээний голч дүнгээр харьцуулахад ажлаас чөлөөлөгдөж байгаа албан хаагчдын голч дүн ажилд орж байгаа албан хаагчдынхаас өндөр байна. Энэ нь төр чадвартай албан хаагчдаа алдаж байна үү гэх асуултад хүргэсэн бөгөөд цаашид нарийвчлан судлах, дараагийн түвшний судалгаануудыг хийх үндэслэл болсон юм.

Иймд төрийн албаны дотоод нөхцөл байдал, ажилчдын сэтгэл ханамжийг илүү нарийвчлан судлах,

гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулах зорилгоор төрийн албаны цахим болон ярилцлагын судалгаануудыг үе шаттай хийлээ.

Монгол Улсад анх удаа төрийн албаны судалгаанд Стэнфордын их сургууль, Лондонгийн их сургуулийн коллеж, Ноттингемийн их сургууль болон Дэлхийн банкнаас хамтран боловсруулсан олон улсын “Төрийн болон нийтийн албан хаагчдын судалгаа”-ны үндсэн модулийг ашигласнаараа онцлог ач холбогдолтой юм.

Судалгааны ажлыг 2 үе шаттайгаар цахим болон ярилцлагын хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд судалгаанд төрийн албан хаагчид (төрийн тусгай албан хаагчдаас бусад)-ыг түүврийн аргаар сонгон, сонгогдсон албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр оролцуулсан болно.

Судалгааны ажлын эхний шатанд 2023 оны 4 дүгээр сард нэг аймгийг сонгон, тухайн аймгийн төрийн албан хаагчдыг хамруулан цахим болон ярилцлагын судалгааг хийсэн. Цахим судалгаанд нийт 1,223 албан хаагч, ярилцлагын судалгаанд нийт 106 албан хаагч тус тус хамрагдав.

Зураг 3.1 Цахим болон ярилцлагын судалгааны зохион байгуулалт болон ялгаатай тал:



Цахим судалгаа

- Төрийн албан хаагчдаас судалгааны агуулгын хүрээнд бэлтгэсэн асуумжийг цахим байдлаар бөглүүлэн ажлын 3-5 хоногт хүлээн авах.
- Цахим судалгаа нь төрийн албан хаагчдын нэр болон хувийн мэдээлэл шаардахгүйгээр нэгдсэн байдлаар авна
- Нийт төрийн албан хаагчдаас авна



Ярилцлага

- Цахим судалгааны хариунд үндэслэн шаардлагатай гэж үзсэн төрийн байгууллагуудад очин албан хаагчтай ганцаарчилсан ярилцлага хийх
- Ярилцлагад оролцогчийг сайн дурын үндсэн дээр ярилцлагад хамруулах
- Цахим судалгаанаас онцлогтой нь төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлтэй холбоотой тулгамдаж буй асуудлын талаар чөлөөтэй ярилцах



Түүврийн аргаар сонгогдсон нэг аймагт 2023 оны 4 дүгээр сард хийсэн судалгаа

Цахим судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 33.2 хувь нь ойрын хоёр жилийн хугацаанд төрийн албанаас гарах сэдэлтэй байсан (График 3.1).

Цахим судалгааны хүрээнд төрийн албан хаагчдын ажлаас гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлоход албан хаагчид ажлаа хийхэд хэт их дүрэм журам нөлөөлж байгаа нь албан хаагчдын цалингийн хүчин зүйлээс илүүтэй төрийн албанаас гарах сэдлийг төрүүлж байна (График 3.2). Удаах хүчин зүйлүүдэд цалиндаа сэтгэл ханамжгүй байдал, сүүлийн 6 сарын хугацаанд ажил үүргээ гүйцэтгэхийн тулд өөрийгөө эрсдэлд оруулсан зэрэг нь гарах сэдэлд ихээр нөлөөлж байна.

График 3.1 Гарах болон үлдэх сэдэл (Цахим судалгаа)






График 3.2 Гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлс /31-р хуудасны графикын утгаас харна уу/




Харин 2023 оны 4 дүгээр сард нэг аймагт хийсэн ярилцлагын судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 65.7 хувь нь ойрын хоёр жилийн хугацаанд төрийн албанаас гарах сэдэлтэй байв (График 3.3).

График 3.3 Гарах болон үлдэх сэдэл (Ярилцлагын судалгаа)



Ярилцлагын судалгааны хүрээнд төрийн албан хаагчдын ажлаас гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахад 46.3 хувь нь цалин хөлснөөс хамаарч байгаа гэсэн бол удаах хүчин зүйлс нь албан хаагчдын ажлын ачаалал, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил гүйцэтгүүлэх буюу чиг үүргийн бус ажлууд, иргэдээс ирэх дарамт шахалт нөлөөлж байна гэсэн дүн гарсан юм (График 3.4).


График: 3.4 Гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлс




Цахим судалгааны хүрээнд ажиллах орчин нөхцөл, ярилцлагын судалгааны хүрээнд албан хаагчийн цалин хөлс төрийн албан хаагчдын ажлаас гарах сэдэлд нөлөөлж буйг дээрх хоёр судалгааны үр дүнгээр тодорхойллоо.

Судалгааны ажлыг цаашид түүврийн хэмжээг нэмэгдүүлж, төлөөлөх чанарыг сайжруулах зорилгоор Төрийн албаны зөвлөлтэй хамтран дараагийн шатны цахим судалгааг 2023 оны 9 дүгээр сард зохион байгуулсан. Тус судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн төрийн албаны 29,165 албан хаагч оролцов (Зураг 3.2, 3.3).

Зураг 3.2 21 аймгийн цахим судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо



Зураг 3.3 9 дүүргээс цахим судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо



Цахим судалгаанд нийт төрийн албан хаагчдын 12.9 хувь хамрагдсан байх бөгөөд энэ нь статистик тооцооллын хувьд төрийн албан хаагчдыг төлөөлөхүйц түүврийн хэмжээнд судалгаа хийгдсэн гэсэн үг юм. Мөн боловсролын түвшин, албан тушаалын төрөл, насны ангилал, төрийн албан тушаалын ангиллын хувьд ч төлөөлөх чадвар хангагдсан болно.

Цахим судалгааны дүнд үндэслэн хангай, зүүн, баруун, төвийн бүс тус бүрээс нэг аймаг, тухайн аймгийн нэг сумыг сонгон 10 болон 11 дүгээр саруудад ярилцлагын судалгааг хийж дүүсгалаа. Нийт 4 аймгийн 58 байгууллагын төрийн үйлчилгээ, төрийн захиргаа, төрийн улс төрийн албан тушаалын 1,012 албан хаагчтай ярилцлага хийж үр дүнг нэгтгэв (Зураг 3.4).

Улсын хэмжээнд цахим судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 27.1 хувь, ярилцлагын судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 34.0 хувь нь төрийн албанаас гарах сэдэлтэй байна.

Зураг 3.4 21 аймгийн ярилцлагын судалгаанд хамрагдсан албан хаагчдын тоо




СУДАЛГААНЫ ҮР ДҮН: 21 аймаг, есөн дүүрэгт 2023 оны 9 дүгээр сард хийсэн цахим судалгаа

Улсын хэмжээнд хийгдсэн цахим судалгааны хүрээнд судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 27.1 хувь нь ойрын хоёр жилийн хугацаанд төрийн албанаас гарах сэдэлтэй гэсэн дүн гарав (График 3.5).

Сүүлийн 3 жилийн хугацаанд ямар нэгэн ёс зүйгүй үйлдлээс болж хохирсон төрийн албанаас гарах сэдэлтэй албан хаагчид нь нийт судалгаанд оролцогчдын 21.2 хувь буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Төрийн албанаас гарахад нөлөөлж буй удаах хүчин зүйлд цалиндаа сэтгэл ханамжгүй байдал, хэт их дүрэм журам ажлаа хийхэд саад болдог зэрэг байна (График 3.6).


График 3.5 Төрийн албанаас гарах сэдэл (Цахим судалгаа)



Төрийн албан хаагчдын төрийн албанаас гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийн тодорхойлсноор гарах үрсгалыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд ач холбогдолтой. Нөгөөтгээгүүр, төрийн албандаа үлдэж ажиллахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулснаар үлдэх сэдлийг нэмэгдүүлэх чиглэлд арга хэмжээ авч

хэрэгжүүлэх боломжийг олгох юм. Иймд төрийн албан хаагчдын төрийн албандаа үлдэх сэдэл, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг мөн тодруулав. Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 46.4 хувь нь ойрын хоёр жилийн хугацаанд төрийн албанд үлдэх сэдэлтэй байна (График 3.7).

График 3.6 Төрийн албанаас гарахад нөлөөлж буй хүчин зүйлс /31-р хуудасны графикын утгаас харна уу/



Төрийн албан хаагчид төрийн албандаа үлдэж ажиллахад нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлоход хариуцсан ажлаа хийж гүйцэтгэх мэдлэг үр чадвартай, үлдэх сэдэлтэй гэсэн албан хаагчид нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын 43.4 хувийг буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Төрийн албанд орсноор үр чадвар нэмэгдсэн гэх үлдэх сэдэлтэй албан хаагчид нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын 41.8 хувь, хамт ажиллагсдын багийн ажиллагаа үр дүнтэй байдаг гэх үлдэх сэдэлтэй албан хаагчид нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын 38.5 хувийг тус тус эзэлж байна (График 3.8).

График 3.7 Төрийн албанд үлдэх сэдэл (Цахим судалгаа)





График 3.8 Төрийн албанд үлдэх сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлс /Цахим судалгаа, 31-р хуудасны графикийн утгаас харна уу/**График 3.2, 3.6, 3.8** графикуудын утга**Төрийн албан хаагчийн цалин**

Төрийн албан хаагчийн цалин хөлс гэсэн хүчин зүйлд дараах үзүүлэлтүүд багтана

- Нийт цалин хөлс (үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллыг багтаасан болно) болон цалингийн эрх тэгш байдлын талаарх сэтгэл ханамж
- Нийт цалин хөлс дотроо гүйцэтгэлийн үнэлгээгээр дамжуулан урамшууллын нөлөөг авч үнэлсэн. Ингэхдээ гүйцэтгэлийн үнэлгээ тогтмол хийгддэг эсэх, үнэлгээний үр дүнд урамшуулал (мөнгөн, мөнгөн бус) хүртдэг эсэх

Ажлын орчин

- Байгууллагын үүр амьсгал буюу хамт олон, удирдлагатай харилцах харилцаа
- Шинэчлэлд нээлттэй эсэх
- Улс төрийн оролцоо байгаа эсэх
- Хэт их дүрэм журам албан хаагчийг ажлаа хийхэд хэрхэн нөлөөлж буй
- Албан хаагчид өмнө нь ямар нэгэн байдлаар хохирч байсан эсэх. Хэрвээ хохирч байсан бол ямар хохирол учирсан. Түүнээс үүдэн аливаа дарамт шахалтад өртсөн эсэх. Дарамт шахалт хэнээс ирдэг эсэхийг харьцуулсан.

Өсөн дэвших боломж

- Төрийн албанд орсон цагаас хойш мэдлэг, үр чадвар сайжирсан эсэх
- Хариуцсан ажлаа үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай сургалтад хамрагдаж чаддаг эсэх

СУДАЛГААНЫ ҮР ДҮН: 21 АЙМАГТ 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ЯРИЛЦЛАГЫН СУДАЛГАА

Ярилцлагын судалгааны дүнг нэгтгэхэд нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын 34.0 хувь нь төрийн албанаас гарах сэдэлтэй байна. Албан хаагчдын төрийн албанаас гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийн 50.4 хувь нь


цалин хөлс бага, ажлын ачаалал их гэсэн хоёр шалтгаанаас бүрдэж байна. Гэсэн хэдий ч албан хаагчдын нас, боловсролын түвшнээс хамаарч төрийн албанаас гарах сэдэлд нөлөөлж буй хүчин зүйлс харилцан адилгүй байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН: 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР САРД ТҮҮВРИЙН АРГААР СОНГОГДСОН АЙМАГТ 9, 11 ДҮГЭЭР САРД ДАВТАН ХИЙСЭН СУДАЛГААНЫ ХАРЬЦУУЛАЛТ

2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Засгийн газрын шийдвэрээр төрийн албан хаагчийн цалинг албан тушаалын ангилал бүрд тодорхой хувиар нэмсэн билээ. “Шинэ сэргэлтийн бодлогын хүрдасгуур төв” УТУГ-аас 2023 оны 4 дүгээр сард түүврийн аргаар сонгогдсон нэг


аймагт хоёр дахь судалгааг цалин нэмсний дараа дахин хийснээр (Зураг 3.5) тухайн аймагт цалингийн өөрчлөлт төрийн албан хаагчийн сэтгэл ханамж, зан төлөв, ажлаас гарах сэдэлд хэрхэн нөлөөлсөн зэргийг харьцуулан судлах боломжтой болсон юм.

Зураг 3.5 Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл




2023 оны 04 сар

Цалингийн сэтгэл ханамж




Цалингийн сэтгэл ханамж/Гарах, үлдэх сэдэл




2023 оны 09 сар

Цалингийн сэтгэл ханамж




Цалингийн сэтгэл ханамж/Гарах, үлдэх сэдэл



Төрийн албан хаагчдын цалин 24.8 - 92.2 хувиар нэмэгдсэн бөгөөд түүврийн аргаар сонгогдсон нэг аймагт 4 дүгээр сарын цахим судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 33.2 хувь нь төрийн албанаас гарах сэдэлтэй байсан бол 9 дүгээр сарын судалгаагаар 30.9 хувь болж 2.3 хувиар буурсан эерэг


дүн гарсан байна. Цалингийн нэмэгдлийн дараа төрийн албан хаагчдын төрийн албанаас гарах сэдэл буурсан боловч цалингийн сэтгэл ханамжийн хувьд 9 дүгээр сарын цахим судалгааны дүн 4 дүгээр сарын судалгааны дүнгээс 11.2 хувиар буурсан сөрөг үзүүлэлттэй байна (Зураг 3.6).

Зураг 3.6 Төрийн албан хаагчийн цалингийн нэмэгдэл




2023 оны 04 сар

Цалингийн сэтгэл ханамж/Төрийн албан тушаалын ангилал



2023 оны 09 сар

Цалингийн сэтгэл ханамж/Төрийн албан тушаалын ангилал



Төрийн албан хаагчийн албан тушаалын ангиллын хувьд төрийн тусгай албан хаагчдын цалин бусад ангиллаас хамгийн бага буюу 24 хувиар нэмэгдсэн боловч цалингийн сэтгэл ханамж 26.4 хувиар буурсан байна.

Олон улсын түршлагаар цалин хөлсний нэмэгдэл нь

цалингийн сэтгэл ханамжийг өсгөн, ажлын сэтгэл ханамжийг нэмэгдүүлснээр ажлаас гарах сэдлийг бууруулдаг ерөнхий чиг хандлага байдаг. Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын хувьд цалингийн сэтгэл ханамж өсөөгүй боловч ажлаас гарах сэдэл буурсан үзүүлэлттэй байна.


Дүгнэлт

Төрийн албан хаагчийн төрийн албанаас гарах сэдэл хамгийн өндрөөр нөлөөлж буй гурван хүчин зүйлсийг ерөнхий мэдээлэлтэй харьцуулахад насны хувьд 18-35 хүртэлх насны албан хаагчид, төрийн албан тушаалын ангиллын хувьд төрийн үйлчилгээний албан хаагчид гарах сэдэл өндөр байна. Иймд тус албан хаагчдыг ажил үүргээ хийж гүйцэтгэхэд тэдэнд тулгарч буй ёс зүйгүй үйлдэл, хэт их дүрэм журмыг бууруулах, гүйцэтгэлийн үнэлгээг гүйцэтгэлд тулгуурлан шударга үнэлж, түүнд тохирсон цалин хөлсийг олгоход анхаарч арга хэмжээ авах хэрэгцээ байгаа нь

судалгааны дүнгээс харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан 29,165 албан хаагч нь Монгол Улсын нийт төрийн албан хаагчдын 12.95 хувийг эзэлж байгаа нь (Төрийн албаны зөвлөлөөс 2023 оны 9 дүгээр сард төрийн албан хаагчдын тоон мэдээллийг шинэчлэн авсан байдлаар) тус судалгааг өргөн цар хүрээтэй хийгдсэн гэдгийг илтгэж байна. Энэхүү судалгааны дүн, өгөгдлийг ашиглан Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд хийгдэх боломжтой төрийн албан хаагчийн олон төрлийн судалгаа, дүн шинжилгээ хийх мэдээллийн бааз үүссэн нь томоохон ач холбогдолтой юм.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЧАНАРЫН СУДАЛГААГ ДЭЛХИЙН БАНКНЫ ОЛОН УЛСЫН СУДАЛГААТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ



НОГООН, БҮТЭЭМЖТЭЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ГАЗАР



Төрийн албан хаагчийн олон улсын судалгаа


Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТУГ-аас Дэлхийн банкнаас явуулдаг “Төрийн албан хаагчийн судалгаа”-ны арга зүйг ашиглан Монгол Улсын төрийн албан хаагчдын судалгааг цахим болон ярилцлагын хэлбэрээр нийт дөрвөн удаа хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгаа нь дэлхийн улс, орнуудын төрийн алба хэрхэн ажилладаг талаарх ойлголтыг тодорхойлж, тухайн улсын засгийн газруудад төрийн албаны менежментийг зөв зохион байгуулахад туслах зорилго бүхий олон улсын судалгааны санаачилга юм.

Судалгаагаар цугларсан дата, мэдээллийг боловсруулан, мэдээллийн баазыг нэгтгэн үүсгэж үр дүнг цогцоор харуулах дашбоардыг (Зураг 4.1) хөгжүүлээд байна. Тус дашбоардыг ашигласнаар судалгааны үр дүнг илүү нарийн тооцох, асуудлын

цаад учир шалтгаануудыг тодорхойлох боломж бүрдэнэ. Урьд өмнө хийгдэж байсан судалгаануудтай харьцуулахад нарийн хэмжиж болохуйц үзүүлэлт, үр дүнг гаргаж байгаагаараа давуу талтай юм. Судалгааны ажлыг давтамжтайгаар үргэлжлүүлэн хийж нэгдсэн мэдээллийн санг баяжуулснаар тухайн улсын төрийн байгууллагуудын хүний нөөцийн менежментийг тодорхойлох, үнэлэх болон харьцуулах суурь бий болно. Ингэснээр төрийн албанд хэрэгжиж байгаа бодлого, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг бодитойгоор хэмжих боломж нээгдэх юм.

Монгол Улсад тус судалгааг хийснээр Дэлхийн банкны судалгааны тайлан, мэдээллийг ашиглан өөрсдийн судалгааны үр дүнг олон улсын нэгдсэн дата мэдээлэлтэй харьцуулж, гадаадын улс, орнуудын төрийн албаны сайн туршлагыг судалж, нэвтрүүлэх боломж бүрдэж байна.

Зураг 4.1 Төрийн албанаас гарах шалтгааны судалгааны дашбоард




Дэлхийн банкнаас хөгжиж буй орнуудад төрийн бүтээмжийг сайжруулахын тулд 2000-2006 онуудын хооронд жил бүр 422 сая ам.долларын санхүүжилттэй ажлуудыг шат дараалалтай хийсэн. Гэвч тухайн үлсүүдэд хангалттай үр дүн гараагүйн дээр төрийн чадамжийг нэмэгдүүлж, авлига хээл хахуулийг бууруулж чадаагүй талаар 2008 онд мэдээлж байлаа. Үүний гол шалтгаан нь бодлогын хэрэгжилтийг хэмжих нэгж, шалгуур стандарт үзүүлэлт дутмаг байсантай холбоотой юм. Иймээс Дэлхийн банк, Станфордын Их сургууль болон Ноттингхамын Их сургуулиас хамтран олон улсын “Төрийн албан хаагчийн судалгаа”-ны үндсэн модулийг боловсруулжээ.

Энэхүү судалгааг 2022 оны байдлаар дэлхийн 23 оронд амжилттай хийж үр дүнг нэгтгэн гаргасан бөгөөд одоогийн байдлаар нийт 32 улс хамрагдаад байна.

Зураг 4.2 Судалгааны зорилго

Дэлхийн банкны судалгаа	
Зорилго	➢ Төрийн албаны үйл ажиллагааг илүү сайн ойлгох ➢ ЗГ-т төрийн албаны менежментийг сайжруулах хэрэгжиж болохуйц үйл ажиллагааг санал болгох
Хамрах хүрээ	➢ Дэлхийн 23 улс ➢ 1300 гаруй төрийн байгууллага ➢ 1,300,000 гаруй Төрийн албан хаагч ➢ Үр 2022 оны 5-р сард танилцуулагдсан. ➢ 2010-2022 онд цуглуулсан дата

Зураг 4.3 Гадаад улс, орнуудын сайн туршлага



Судалгааны үр дүнг ашиглан улс орнууд өөрсдийн төрийн албаны үйл ажиллагааг сайжруулж буй сайн туршлагууд нэмэгдсээр байна. Жишээлбэл, Бүгд Найрамдах Чили улсад төрийн албанд шинээр орж буй албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг чанаржуулж, байгууллагын соёлд дасан зохицох хөтөлбөрийг гаргасны үндсэн дээр төрийн албан хаагчийн ажлаас гаралт буурч, төрийн үйлчилгээг иргэдэд тогтвортой үзүүлэх боломж нэмэгдсэн байдаг. (Зураг 4.3)

Мөн Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп улсад тэтгэвэртээ гарч байгаа албан хаагчид залуу үе, залгамж халаагаа бэлдэн ажлын туршлагаа хуваалцах, ментор хийх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төрийн үйл ажиллагааны тогтвортой байдал хангагдаж, үе хоорондын үл ойлголцол арилсан сайн жишгүүд байна.

Олон улсын судалгааны үндсэн модуль нь төрийн албан хаагчийн ерөнхий мэдээлэл, байгууллагын хүний нөөцийн менежментийн арга барил болон албан хаагчийн хандлага, зан төлөвийг тогтоох асуултуудыг цогцоор нь багтаасан бөгөөд судалгааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг улс хооронд харьцуулах боломжийг олгодог.

“Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-ын удирдлага, албан хаагчид Дэлхийн банкны экспертүүдтэй зөвлөлдөн энэхүү судалгааны бүх модулийг багтаасан асуумжийг Монгол Улсын төрийн албаны орчин нөхцөлд нийцүүлэн боловсруулж, Дэлхийн банкнаас гаргасан стандарт журмуудын дагуу хийж гүйцэтгэлээ.

Төрийн албан хаагчийн олон улсын судалгааны хэрэглээ

1. Төрийн албаны талаарх хэвшмэл ойлголтын зөрүүг арилгана

Төрийн албан хаагчийн талаарх бидний хэвшмэл ойлголт бол “Албан хаагчийн ажилдаа гаргаж байгаа хүчин чармайлт үнэлэгддэггүй, цалингийн нэмэгдэл, эсвэл албан тушаал дэвшүүлэх зэрэгт нөлөөлдөггүй” гэх таамаглал юм. Гэвч судалгааны үр дүн бодит байдал дээр тухайн таамаглалаас өөр гэдгийг батлан харуулж байна. Нийт судалгаанд оролцсон улс орнуудын төрийн албан хаагчдын хариултыг харахад сайн ажлын гүйцэтгэл цалин хөлсний нэмэгдэлд шууд нөлөөлөхгүй (зөвшөөрсөн 32 хувь) ч, албан тушаал дэвшихэд чухал нөлөөтэй (зөвшөөрсөн 69 хувь) гэжээ. (График 4.1, 4.2) Манай улсын төрийн албан хаагчдын хариулт ч мөн олон улсын судалгааны үр дүнгээс хол зөрүүгүй харагдаж байна. (Зураг. 3)

График 4.1 Сайн ажиллавал цалин нэмэгддэг эсэх






График 4.2 Гүйцэтгэлээр албан тушаал дэвших



2. Олон улсын төрийн албаны менежмент болон төрийн албан хаагчдын хандлагын эрс тэс ялгааг ойлгоход тусална

Бид төрийн албыг тогтвортой ажлын байр гэж ойлгох нь элбэг. Гэвч энэ үзүүлэлтийг олон улсын хувьд харьцуулахад Бүгд Найрамдах Словак улсын төрийн албан хаагчдын 21 хувь нь төрийн албыг тогтвортой ажлын байр гэж үзэж байхад, Холбооны Бүгд Найрамдах Бразил улс 69 хувьтай зөвшөөрч байна. (График 4.3) Энэ нь тухайн улсын төрийн байгууллагын удирдлагын эрс тэс зөрүү, төрийн албаны орчин нөхцөлийн ялгааг бодитоор харуулж байна. Манай судалгаанд оролцсон нийт төрийн албан хаагчдын 40 хувь нь ажлын байраа тогтвортой гэж үзжээ. Үүнээс бид төрийн албан хаагчдын олонх нь өөрсдийн ажлын байраа тогтвортой гэж үзэхгүй байгааг харж болно.

График 4.3 Тогтвортой ажлын байр




3. Улс орнуудад төрийн албаны шинэчлэл хэрхэн явагдаж байгааг харьцуулах боломжтой

Дэлхийн банкнаас олон улсын судалгааны үр дүнг нэгтгэсэн дашбоардоос харахад “Төрийн албанд анх ажилд орохдоо нээлттэй зарласан ажлын байрны зарын дагуу сонгон шалгаруулалтаар орсон” гэх асуултаар тухайн улсын төрийн алба нээлттэй байдлаар шинэчлэгдэж байгаа эсэхийг харж болно. Энэхүү үзүүлэлт дээр Хорватын Бүгд Найрамдах улс болон Румын улсын төрийн албан хаагчдын 70-77 хувь нь нээлттэй сонгон шалгаруулалтаар ажилд орсон байхад

Бүгд Найрамдах Чили, Бүгд Найрамдах Эстони улсууд харьцангуй бага буюу шинээр ажилд орж байгаа албан хаагчдын 30-33 хувь нь (График 4.4) нээлттэй зарласан зарын дагуу төрийн албанд орж байна.


График 4.4 Төрийн албанд анх орохдоо нээлттэй ажлын байрны зарын дагуу орсон албан хаагчид



4. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, бодлого боловсруулалтад ашиглана

Судалгааны явцад цуглуулсан мэдээллээр нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, бидний бэлтгэсэн дашбоард нь (Зураг 4.4) зорилтот үр дүнг хараад зогсохгүй шаардлагатай тохиолдолд хэд хэдэн хүчин зүйлийн уялдаа холбоогоор нарийвчлан үр дүнг харах боломжтой болсноороо онцлог юм. Тухайлбал дашбоардноос ямар нэгэн хүчин зүйлээр нь сонгоод (жишээ нь: ажлаас гарах сэдэл) засаг захиргааны нэгжээр нь системтэйгээр харах, эсвэл төрийн албан хаагчийн цалингийн сэтгэл ханамж, цалингийн эрх тэгш байдал болон бусад хүний нөөцийн менежментийн үзүүлэлтээр нь салгаж дата анализ хийх боломжтой.

Зураг 4.4 Гарах сэдэлтэй албан хаагчдын дашбоард




Монгол Улсын Төрийн албан хаагчийн судалгааны үр дүнг олон улсын судалгааны үр дүнтэй харьцуулах нь

Судалгааны аргачлалын дагуу Монгол Улсын төрийн албан хаагчдын төлөөлөх чадварыг тооцон 21 аймаг, 9 дүүргийн нийт 29,165 албан хаагчийг судалгаанд хамруулсан нь үр дүнг Дэлхийн банкнаас явуулсан судалгааны үр дүнтэй харьцуулах боломжийг бүрдүүлсэн.

Манай улсын төрийн албаны менежмент болон төрийн албан хаагчийн зан төлөвөөр харьцуулалт хийв.

График 4.5 Ажлын сэтгэл ханамж



Манай улсын төрийн албан хаагчийн ажлын сэтгэл ханамж 74 хувь байгаа нь (График 4.5) олон улсын дундаж үзүүлэлттэй хамгийн ойрхон харагдаж байна.

Ажлын сэтгэл ханамж нь ажлаас гарах сэдэлтэй урвуу хамааралтай байдаг. Цалин хөлс, өсөн дэвжих боломж, ажил амьдралын тэнцвэр, ажлын тогтвортой байдал, хамт олон, удирдлага гэх мэт олон хүчин зүйлсийн нийлбэрээр ажлын сэтгэл ханамж тодорхойлогддог.

Төрийн албан хаагчийн зөв хандлага, зан төлөв бол төрийн албаны үр нөлөөтэй, чадамжтай байх гол үндэс юм. Сайн төрийн албан хаагчийн зан төлөв, хандлагыг ажлын сэтгэл ханамж, ажлын мотиваци (График 4.6), төрийн албанд тууштай ажиллах шийдвэр (График 4.7), өндөр гүйцэтгэл болон ёс зүйтэй байдлаар нь хэмждэг.

Эдгээр үзүүлэлтээр манай улс олон улсын хэмжээнд дараах байдлаар харьцуулагдаж байна.

График 4.6 Ажлын мотиваци






График 4.7 Төрийн албанд тууштай ажиллах хандлага






Чадахуйн зарчим буюу мерит зарчмын үндсэн шаардлага нь албан хаагчийн гүйцэтгэлийг үнэн бодитоор үнэлж, гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний нэмэгдэл, албан тушаал дэвшүүлэх тогтолцоог нэвтрүүлэх юм. Гүйцэтгэлийн үнэлгээтэй холбоотой үзүүлэлтүүд дээр анализ хийхэд олон улстай дараах (График 4.8) байдлаар харьцуулагдаж байна.

Монгол Улсын төрийн албаны хувьд гүйцэтгэлийн үнэлгээг хийж байгаа үзүүлэлтээр олон улсын дунджаас өндөр байгаа боловч тухайн үнэлгээг бодитоор гаргаж, байгууллагын үйл ажиллагааны чадамжийг нэмэгдүүлж байгаа эсэх нь эргэлзээтэй.

График 4.8 Гүйцэтгэлийн үнэлгээ хийгддэг эсэх


Эцэст нь судалгааны үр дүнг төрийн албан хаагч ажлаас гарах сэдлээр нарийвчлан үзэхэд Монгол Улсын хувьд гарах сэдэл 27 хувь буюу олон улсын дунджаас 12 хувиар илүү бөгөөд цалингийн сэтгэл ханамж нь (График 4.10) сүүлээсээ 2-рт эрэмбэлэгдэж байна

График 4.9 Гарах сэдэлтэй TAX**График 4.10** Цалингийн сэтгэл ханамж**График 4.11** Цалингийн тэгш байдал

Төрийн албан хаагчийн цалинг албан журмаар 2023 оны 7 дугаар сард нэмсэн бөгөөд “Төрийн албан хаагчийн судалгаа”-г цалингийн нэмэгдлийн дараа буюу 2023 оны 9 дүгээр сард авсан хэдий ч сэтгэл ханамж бага хувиар өссөн үр дүн гарсан. Үүнийг цалингийн эрх тэгш байдал хангагдахгүй байгаатай (График 4.11) холбон үзэж болохоор байна. Цалингийн сэтгэл ханамж бага байгаа бусад хүчин зүйлс, шалтгаануудыг нарийвчлан гаргахаар дараагийн шатны буюу ярилцлагын судалгааг хийсэн.

Энэхүү бодитой, хэмжигдэж болохуйц судалгааны үр дүнг ашиглан төрийн албаны чадамжийг нэмэгдүүлж чадахуйц санал, зөвлөмжүүдийг Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Засгийн газрын хүний нөөцийн газар зэрэг холбогдох байгууллагуудад хүргүүлэн хамтран ажиллаж байна.

ТӨРИЙН ЧАДАМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ НЬ



НОГООН, БҮТЭЭМЖТЭЙ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ГАЗАР



Монгол Улсын төрийн албанд Харвардын хөтөлбөрийг нутагшуулж байна

Дэлхийн улс орнууд нийгэмдээ тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэхээр стратеги, төлөвлөгөөг боловсруулж, түүний мөрөөр хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлснээр илүү сайн үр дүнд хүрнэ гэсэн хүлээлттэй байдаг. Гэвч зарим тохиолдолд эдгээр стратеги, төлөвлөгөө, авч хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, арга хэмжээнүүд нь зөвхөн цаасан дээр амжилттай хэрэгжиж, бодит байдал дээр асуудлыг шийдвэрлэлгүй үлдээдэг нь дэлхийн улс орнуудын хөгжлийн зөрүүнээс тодорхой харагдаж байна. Энэхүү байдлыг тодорхойлохын тулд дараах асуултуудад хариулах шаардлага үүснэ. Тухайлбал:

Бодлогын хэрэгжилт яагаад ийм нийтлэг хэв шинжтэй байна вэ? Аль нэг улсад амжилттай хэрэгжиж, асуудлыг шийдвэрлэж чадсан сайн түршлага байхад бусад улс орнууд яагаад түүнийг шүүд, амжилттай хэрэгжүүлж чаддаггүй вэ? Хүрэх хөгжлийн цэгээ тодорхойлон, стратегиа боловсруулж, хэчнээн их цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулсан ч үр дүнгүй байгаа шалтгаан юу вэ? Бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, богино хугацаанд амжилтад хүрч, бодит өөрчлөлтийг бий болгохын тулд сорилт бэрхшээлийг хэрхэн даван туулах вэ?

Харвардын Их Сургуулийн Олон Улсын Хөгжлийн Төв (CID) дахь Төрийн удирдлагын сургууль нь эдгээр асуултуудад хариулт өгч, асуудлыг шийдвэрлэх зорилгоор аливаа улс,

орны төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг төрийн байгууллагын чадамжийг бүрдүүлэх стратеги, тактикийг боловсруулах чиглэлээр судалгааны ажлуудыг гүйцэтгэж байна. Түүнчлэн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан төрийн албан хаагч нарт зориулсан “Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” сургалтын хөтөлбөрийг боловсруулсан.

“Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТУГ-ын гүйцэтгэх захирал Б.Дөлгөөн Харвард Кеннедигийн сургуулийн Төрийн удирдлагын магистрт суралцахдаа тухайн хөтөлбөрт хамрагдсан бөгөөд хөтөлбөрийн сургалтын эрхийг авч, ном, гарын авлага, видео хичээлүүдийг монгол хэлнээ орчуулан Монгол Улсын төрийн албанд нэвтрүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлээд байна. “Төрийн бүтээмжийн сэргэлт”-ийн хүрээнд тус төвөөс “Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” хөтөлбөрийг Монгол Улсын төрийн албан хаагчдад зориулан лекцийн хамт гурван өдрийн цогц сургалт болгон боловсрууллаа. Хөтөлбөрийн дагуу сургагч багш нарыг бэлтгэн, Удирдлагын академитай хамтарсан сургалтуудыг төрийн байгууллагуудад шат дараатайгаар зохион байгуулж байна. 2023 онд тухайн лекцэд давхардсан тоогоор 5500 гаруй төрийн албан хаагч хамрагдсан.


“Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” хөтөлбөрөөс

Зураг 5.1 Хөгжлийг тодорхойлох 4-D хэмжээ



Харвардын их сургуулийн эрдэмтэн, судлаачид улс, орны хөгжлийг улс төр, эдийн засаг, нийгэм, төрийн чадамжийн үзүүлэлтүүдийг багтаасан дөрвөн хэмжээсээр тодорхойлсон. Эдийн засгийн хөгжлийн үр дүнд хүмүүсийн үр чадвар сайжирч, худалдааны механизмтай нэгдсэнээр бүтээмж нэмэгдэж, улмаар эдийн засгийн өсөлтийг хурдасгадаг. Улс төр зөв төлөвшсөнөөр иргэд төлөөлөгчдөө өөрсдөө, шударгаар сонгох боломжтой болж, нийгмийг удирдаж буй удирдлагын тогтолцоо нь ард иргэдийн хүсэл эрмэлзлийг илэрхийлдэг болно. Нийгмийн хөгжил ахихын хэрээр хүйс, шашин шүтлэг, угсаа гарал зэрэг хувь хүнийг тодорхойлогч хүчин зүйлүүд нь хүний амьдралын чухал шийдвэр гаргалтад нөлөөлөх нөлөөлөл багасаж, ач холбогдол нь буурна. Харин сүүлийн хэмжээс болох төрийн чадамж нь төрийн алба илүү ээдрээтэй, том хэмжээний маргаан дагуулсан асуудлуудыг шийдвэрлэх чадвараар хэмжигдэнэ.

Зураг 5.2 Бодлогын гурвал



Харвардын Их сургуулийн профессор Лант Притчетт, Мэтт Эндрьюс, Майкл Вулкок нарын дэвшүүлсэн онолоор аливаа төрийн бодлого, шийдвэр амжилттай хэрэгжих гурван үндсэн нөхцөл байдаг.

1. Төрийн бодлого онолын хувьд “асуудлаа” шийддэг байх ёстой. Бодлого хэлбэрийн хувьд амжилттай хэрэгжсэн ч тухайн бодлогыг анх гаргахдаа зорьсон зорилгодоо бодит байдал дээр хүрээгүй буюу асуудал хэвээр үлдсэн байхыг асуудлаа шийдсэн гэж үзэхгүй.
2. Төрийн бодлого нь улс төрийн дэмжлэг авах боломжтой байх.


3. Тухайн төрийн бодлогыг хэрэгжүүлэх байгууллага уг бодлогыг хэрэгжүүлж чадахуйц хэмжээний чадамжтай байх юм. Үүнийг “Бодлогын гурвал” гэж нэрийдэж буй. (Зураг 5.2)

Шийдвэрлэх асуудал

Асуудлаа зөв тодорхойлох нь оновчтой, үр дүнтэй, зөв шийдэл хэрэгжүүлэх хамгийн эхний чухал алхам юм. Асуудлыг тодорхойлохдоо хэд хэдэн шалгуураар авч үзнэ. Нэгдүгээрт үйл ажиллагаа нь ажиллагаа ихээр шаарддаг эсэх буюу олон хүний оролцоотой шийдэгдэх үү, эсхүл цөөн хүний оролцоотой шийдэгдэх үү гэдгийг тогтооно. Улмаар тухайн үйл ажиллагаанд хувийн шийдвэр гаргалт бий эсэх буюу заавал бие дааж шийдвэр гаргаснаар цааш үргэлжлэх үйл ажиллагаа юу, эсхүл шийдвэр гаргах шаардлагагүй хэрэгжүүлэх боломжтой юу гэдгийг тодорхойлно. Гуравдугаарт тухайн үйл ажиллагаа нь иргэнд үйлчилгээ үзүүлж байна уу, эсхүл хариуцлага ногдуулах төрлийнх үү гэдгээс хамаарна. Эцэст нь шинийг санаачилж хийх шаардлагатай юу, эсхүл танигдсан технологийг ашиглаж үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой юу гэх шалгуур. Эдгээр дөрвөн шалгуураар аливаа үйл ажиллагааг ангилснаар асуудлыг бодлого боловсруулах түвшний, логикийн шинжтэй, гүйцэтгэл ихээр шаардсан үйлчилгээ хүргэх, гүйцэтгэл ихээр шаардсан үүрэг хариуцлага ногдуулах, асар хүнд түвшний гэсэн 5 түвшинд ангилдаг.

Дээрх ангиллаар төрийн чадамжийг нэмэгдүүлэхийн тулд шийдвэрлэх ёстой асуудлууд нь “асар хүнд” түвшнийх байдаг. Асар хүнд гэдэгт ажиллагаа ихээр шаарддаг (олон тооны агент оролцох шаардлагатай), хувийн шийдвэр хамаардаг (агентуудын гаргасан шийдвэр шалгахад бэрх мэдлэг дээр үндэслэдэг), танигдсан аргачлал, технологид үндэслээгүй буюу шинэ аргачлал, технологи шаарддаг, шийдвэрлэх, хэрэгжүүлэх үйл явц хамгийн хүнд, төвөгтэй ажлууд байдаг. Бид асуудлыг оновчтой тодорхойлохын тулд таван үндсэн шалгуураар хэмжих бөгөөд үүнд:

1. Асуудлыг шийдэхэд нөлөөлөх гол хүмүүс үгүйсгэж чадахгүй, өөрөөр хэлбэл асуудал байгаа гэдгийг гол хүмүүс хүлээн зөвшөөрдөг.
2. Өөрчлөлтийг өдөөж, урамшуулдаг.
3. Учир шалтгаанаар нь задлах боломжтой.
4. Бодит дэс дараатай хариу үйлдэл хийх боломжтой.
5. Дотоодын оролцогчдод тулгуурладаг буюу шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, үр дүнг хүртэх буюу эрх ашиг нь хөндөгдөж буй талуудын зөвшилцлийн үр дүнд асуудал тодорхойлогдож, илүү боловсронгуй болдог байх ёстой.

Зураг 5.3 Төслийн менежментийн дутагдал

Асуудлыг оновчтой тодорхойлсон ч төслийн менежментийн аргачлал буюу Логфрейм загвараар шийдвэрлэх гэж оролдох нь бодлого, төсөл, хөтөлбөрүүд амжилтгүй хэрэгжих нэг шалтгаан болдог байна. Учир нь асар хүнд түвшний асуудлыг шийдвэрлэхийн тулд хэрэгжүүлдэг “төлөвлөөд гүйцэтгэ” гэх зарчим нь тухайн гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу байгаа онохгүй байх олон сорилтуудтай тулгардаг. Судалгаагаар хэрэгжиж буй төслийн 70% нь төлөвлөсөн үр дүндээ хүрч чаддаггүй буюу бүтэлгүйтдэг байна. Төслийн менежментийн аргачлалаар хамгийн сайн хэрэгжиж чадсан гаднын сайн туршлагуудыг шууд хэрэгжүүлэх оролдлого хийхэд тухайн байгууллагын чадамж хүрэхгүйгээс болж чадамжийн занганд орж, байгууллага амжилттай байгаа мэт дүр эсгэн бодит үр дүнд бус хэлбэрт анхаарч эхэлдэг. Амжилттай хэрэгжсэн сайн туршлагууд нь байгууллагын чадамжийн нийцлээс гадна тухайн орчин нөхцөлдөө таарсан байдаг. Донор байгууллагын шахалтаар хэрэгжүүлэгч байгууллагад хэтийдсэн их ачаа үүрүүлэхэд байгууллагын бодит чадамжийг бүр доош бууруулах эрсдэлтэй. Иймээс бид асуудлыг шийдвэрлэн, төрийн чадамжийг бүрдүүлэхийн тулд

үр дүнгээ өгдөг, хэрэгжих боломжтой, зөв аргачлалыг ашиглах шаардлагатай байна.

Асуудлаар хөтлөгдсөн давталтад тохируулга

“Төрийн чадамжийг бүрдүүлэх нь” хөтөлбөрийн багш нарын боловсруулсан “Асуудлаар хөтлөгдсөн давталтад тохируулга аргачлал” асуудлыг задлан үндсэн шалтгаануудыг тодорхойлох, асуудлын шийдэлд нэвтрэх цэгүүдийг оновчтой тодорхойлох, боломжит шийдлүүдийг хайх, олсон шийдлийг турших, туршилтаасаа суралцах, дахин дахин турших замаар асар хүнд асуудлыг алхам алхмаар шийдэх боломжийг олгодог. Тус арга нь асуудлын орчин нөхцөлд нь тохирсон шийдлийг бий болгох, нягт эргэх холбоо бүхий динамик процесс юм. Асуудлаар хөтлөгдсөн давталтад тохируулга бол явцдаа суралцах аргачлал юм.

АХДТ аргачлал нь **дөрвөн үндсэн зарчимд** тулгуурладаг:

Зураг 5.4.

Дотоод асуудалд дотоод шийдэл олох

Тухайн орчин нөхцөлд дотоодын оролцогч талуудын дэвшүүлж, чухалчилж авч үздэг асуудалд төвлөрнө.

Зураг 5.5.

Асуудлаар хөтлөгдсөн эерэг үр дүнгүүдийг бий болгох

Туршилт болон туршилтаар өдөөгдсөн эерэг үр дүнг бий болгохыг дэмжиж, урамшуулдаг ингэснээр эрх мэдлийн орчноо нэмэгдүүлж улам далайцтай ажлуудыг хийх боломж бүрдүүлнэ.

Зураг 5.6.

Турших, суралцах, давтах, дасан сайжруулах

Бодит мэдээлэл дээр тулгуурласан, явцдаа суралцах аргыг удирдлагын арга барилд нэвтрүүлнэ.

Зураг 5.7.

Нөхцөл байдалдаа тааруулан тэлэх

Шинэчлэл өөрчлөлтийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай салбар, байгууллага доторх өргөн хүрээний хүмүүсийн оролцоог хангана.

Зураг 5.8 Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй улс орнууд

Төрийн чадамжийг бүрдүүлэх нь хөтөлбөрийг 2012 оноос эхлүүлэн өдийг хүртэл 148 улсын бодлого боловсруулагчид болон албан хаагчдад танилцуулж, “Асуудлаар хөтлөгдсөн

давталтад тохируулга” аргачлалыг суралцаж, турших боломжийг өгсөн бөгөөд үр дүнд нь олон улсын төрийн чадамжийг нэмэгдүүлэхэд ахиц дэвшил гарсаар байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТ



ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ГАЗАР




Эрчим хүчний салбарт хийгдэж буй суурь судалгаа

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн эрчим хүчний сэргэлтэд нийт 4 багц 22 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр баталсан. Үүнээс төвийн бүсийн цахилгаан станцуудын хүчин чадлыг өргөтгөх төслүүд, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүд барих төслүүд, эрчим

хүчний дэд станцуудын тоог нэмэгдүүлэх, шинжлэх ухаан, дэвшилтэт технологид суурилсан эрчим хүчний төслүүд багтаж байна. Дээрх эрчим хүчний сэргэлтийн төслүүдийг хэрэгжүүлэхэд 2022 оны тооцооллоор нийт 14,9 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай.

Зураг 6.1 Эрчим хүчний сэргэлтийн төсөл, хөтөлбөрүүд

 ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦУУДЫН ХҮЧИН ЧАДЛЫГ ӨРГӨТГӨХ ТӨСЛҮҮД		ДЦС-3 325 МВт ДЦС-2 100 МВт Чойбалсан ДЦС 50 МВт Амгалан ДС 116 МВт (100 Гкал/ц) ДЦС-4 уурын зуух 500 тн/ц Хийн эх үүсвэрүүд 219 мвт (185 гкал/ц)	НИЙТ: 4,233.0 тэрбум
 ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИНЭ ЭХ ҮҮСВЭРҮҮД БАРИХ ТӨСЛҮҮД		Тавантолгой ДЦС 450 МВт Эрдэнэбүрэн УЦС 90 МВт Эгийн гол УЦС 315 МВт /Судалгаа/ Багахангай ЦС 300 МВт Багануур ДЦС 400 МВт	НИЙТ: 9,128.8 тэрбум
 ЭРЧИМ ХҮЧНИЙ ДЭД СТАНЦ, ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ АГААРЫН ШУГАМ СУЛЖЭЭНИЙ ТӨСЛҮҮД		Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай 468 км Тавантолгой ДЦС-Оюутолгой 167 км Сайншанд-Цагаансуварга 204 км Багануур-Чингис-Чойбалсан 518 км Багануур-Чойр 188 км Мандалговь-Арвайхээр 287 км Багануур-Налайх-Улаанбаатар 130 км	НИЙТ: 1,280.7 тэрбум
 БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ШИНЖЛЭХ УХААН, ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСЛҮҮД		Цөмийн эрчим хүч Ногоон устөрөгч Байгалын хий Сэргээгдэх эрчим хүч, Нар 35 МВт, Салхи 15 МВт	НИЙТ: 329.1 тэрбум

Дэд бүтэц

Н.БАТДОРЖ: III, IV цахилгаан станцын өргөтгөлийн төслүүдийн боломжит санхүүжилтийн эх үүсвэрийн судалгааг хийж гүйцэтгэлээ

Эрчим хүчний сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн талаар Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төвийн Дэд бүтцийн хөгжлийн бодлогын газрын дарга Н.Батдоржтой ярилцлаа.

-Дээрх төсөл, хөтөлбөрүүдээс эхний ээлжинд ямар төслүүдийн судалгааг хийж байна вэ?

-Манай төвийн зүгээс дараах 2 төсөл дээр холбогдох яамны хүсэлтийн дагуу судалгааг хийсэн.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтад батлагдсан “Дулааны Дөрөвдүгээр Цахилгаан Станц” ТӨХК-ийн нэмэлт 500 тонн/ц хүчин чадал бүхий 9 дэх уурын зуухны төсөл дээр санхүүжилтийн эх үүсвэрийг судлан, боломжит хувилбарыг тодорхойлсон. 2019-2020 онуудад “Дулааны Дөрөвдүгээр Цахилгаан Станц” ТӨХК нь Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр 1-4 дүгээр генераторуудын хүчин чадлыг 89 МВт-аар нэмэгдүүлсэн.

Тус станцын цахилгааны нийт суурилагдсан хүчин чадал нь 772 МВт буюу нийслэл Улаанбаатар хотын 77 хувийг, дулааны нийт хүчин чадал нь 1,586 Гкал/ц буюу 54.8 хувийг дангаар хангаж байна.

Гэвч шинэчилсэн 4 генератор нь бүрэн хүчин чадлаа ашиглах нөхцөл бүрэн бүрдээгүй (нийт 89 МВт-аар нэмснээс 37 МВт цахилгаан үйлдвэрлэж байгаа нь зуухны дутагдлаас үүдэлтэй), үүний улмаас үйлдвэрлэх боломжит хүчин чадал 720 МВт байна. Одоо ажиллаж буй нийт 8 зуухад өвлийн их ачааллын үед гэмтэл, доголдол



гарсан тохиолдолд нөөцгүй, сэлгэн ажиллах боломжгүй бүх чадлаараа ажиллаж байна. Нэмэлт 9 дэх зуухыг барьснаар генераторын нэмэгдсэн хүчин чадлаа бүрэн ашиглах, засвар үйлчилгээ хийх, эрсдэлийг бууруулах, уурын дутагдлыг хангах боломжтой.

-Тус төслийн үр өгөөж, ач холбогдол юунд оршиж байна вэ?

-Төслийн үзүүлэх нөлөөлөл талаас тооцвол цахилгаан эрчим хүч 52 МВт буюу 25,000 айлыг цахилаан эрчим хүчээр, дулааны эрчим хүч 150 Гкал буюу 20,000 айлыг дулааны эрчим хүчээр хангах боломж бүрдэнэ.

Бусад төслүүдтэй харьцуулахад дараах давуу талууд байна.

Тус станц нь Улаанбаатар хотын цахилгаан эрчим хүчний 77 хувь, дулааны эрчим хүчний 54.8 хувийг хангадаг томоохон станц юм

**Тухайн төсөлд
хөрөнгө
оруулалт
татаж чадахгүй
байгаа нь одоо
мөрдөгдөж
буй эрчим
хүчний үнэ
тарифтай шууд
хамааралтай**

• ТЭЗҮ, Зураг төсөл, газрын зөвшөөрөл, дэд бүтэц, тусгай зөвшөөрөл зэрэг технологийн асуудлууд шийдэгдсэн.

• Төсөл хэрэгжсэний дараа төсөл дээр ажиллах мэргэжлийн боловсон хүчин бэлэн.

Шинэ зуухны төслийг хэрэгжүүлснээр “Дулааны Дөрөвдүгээр Цахилгаан Станц” ТӨХК нэмэлтээр 650 сая.кВт эрчим хүчийг эрчим хүчний системд нэмэлтээр нийлүүлэх боломжтой. 2023 оны нийт цахилгаан үйлдвэрлэлийн шаардагдах хэмжээг жилийн дундаж 6.7 хувийн өсөлтөөр тооцвол нэмэлтээр шаардагдах 488 сая кВт. цаг эрчим хүчийг хангахаас гадна импортын хэмжээг 162 сая кВт.цаг эрчим хүчээр бууруулах боломжтой.

Төслийн үр өгөөжийг техник, технологи, бусад нөлөөллөөс гадна эдийн засгийн талаас нь тооцвол импортын эрчим хүчний хэмжээг бууруулах хэмнэлт гаргахаар байгаа. Тооцооллоор нийт 173 тэрбум төгрөгийн (2023 оны ам.долларын ханшаар) хэмнэлтийг импортын эрчим хүч худалдан авалтаас хэмнэх бололцоотой байна. “Дулааны дөрөвдүгээр цахилгаан станц” ТӨХК-ийн 500 тонн/ц хүчин чадалтай уурын зуухны төслийн эдийн засаг болон системд үзүүлэх нөлөөлөл зэргийг тооцвол “Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүчний төслүүдээс эхний ээлжид зайлшгүй хэрэгжүүлэх төслийн нэг.

-Тус төслийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэлүүд тулгарч байна, тэдгээрийн шийдэл юу байна вэ?

-Олон улсад нүүрс суурьтай эрчим хүчний эх үүсвэрүүдэд санхүүжилт олох боломж нэгэнт хумигдсан тул бидний хувьд одоо дотоодын санхүүгийн эх үүсвэр болон бусад тусгай эрхийн гэрээгээр гэсэн сонголт үлдээд байна. Мэдээж тухайн төсөл дээр хөрөнгө оруулалтыг татаж чадахгүй байгаа хүчин зүйл бол одоо мөрдөгдөж буй эрчим хүчний үнэ тарифтай шууд хамааралтай байна. Дээр дурдсанчлан 14,9 их наядын хөрөнгө оруулалтыг шууд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж чадахгүй, нөгөө талдаа станцуудын санхүүгийн

хувьд олон жилийн хуримтлагдсан өр төлбөрөөс шалтгаалж өөрийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийж чадахгүй байгаа гарц шийдэл гэвэл төр, хувийн хэвшлийн түншлэлээр төслийг эхлүүлж болно. Гэхдээ үнэ тарифыг бодит өртөгт хүргэж тодорхой хугацаанд үнийг чөлөөлсөн тохиолдолд хөрөнгө оруулагч нарын сонирхлыг татах боломжтой.

Санхүүжилтийг босгох талаар судалгааны хажуугаар банкны шаардлага, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад нөхцөлийг бүрдүүлэх үүднээс дараах арга хэмжээг авч ажилласан. Энэхүү төслийн ажлын хүрээнд БНХАУ-ын дулааны цахилгаан станцын зуух үйлдвэрлэгч 27 аж ахуй нэгж, үйлдвэрүүдтэй цахим шуудан, утсаар холбоо тогтоон, эдгээр байгууллагуудаас төслийн техникийн үзүүлэлтийн дагуу угсралт, суурилуулалтыг бүрэн хийж гүйцэтгэх ажлын үнийн санал авах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Уг 27 аж ахуй нэгжээс 13 үйлдвэрлэх боломжгүй, 11 үйлдвэрлэлийн хүчин чадлаас давсан хэмжээтэй, 3 аж ахуй нэгж үнийн саналыг ирүүлсэн. Нөгөө талдаа БНХАУ нүүрсний цахилгаан станцуудад хөрөнгө оруулахгүй болсонтой холбоотойгоор зуух үйлдвэрлэгчид үйл ажиллагаагаа зогсоох, үйлдвэрлэлийн хэмжээгээ бууруулах гадаад улсад нийлүүлэхгүй байх зэрэг шалтгаанаар үнийн санал өгөхөөс татгалзсан.

-2 дахь төсөл нь ямар төсөл вэ?

-Дараагийн төсөл бол “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК Төвийн бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд 2022 оны байдлаар цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн 16 хувийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн 31 хувь, үйлдвэрийн уурын хэрэглээний 47 хувийг хангаж байна. Энэ нь нийт суурилагдсан хүчин чадал нь 198 МВт бөгөөд үүний 48 МВт-ийн дунд даралтын станцын тоноглол нь 1968 онд ашиглалтад орсноос хойш элэгдэлд орж эрсдэл өндөртэй ажиллаж байна. Магадгүй олон хүн асууж магад яагаад та нар шинэ эх үүсвэр барих тухай ярихгүй хуучин станц

Зураг 6.2 ДЦС-4 ТӨХ-ийн 500 тонн/ц хүчин чадалтай зуухны нөлөө

Эх сурвалж: ДЦС-4

► болох III, IV станцуудыг хөрөнгө оруулалт хийх гээд байдаг юм бэ гэж асуух юм бол өмнө хэлсэнчлэн эрчим хүчний үнэ тарифыг бодит өртөгт хүргэж, ил тод нээлттэй, хараат бус бие даасан засаглалын хэлбэрийг тогтоож чадвал эрчим хүчний салбарын шинэчлэлийг хийх хангалттай боломжууд нэгдэх байх гэж итгэж байна.

-Уг төсөл дээр өмнө хийгдэж байсан ажлууд байдаг уу? Өмнө нь анхаарахгүй өдийг хүрсэн шалтгаан байдаг уу?

-Монгол Улсын Засгийн газар 2016 онд “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх, станцын цахилгаан, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төслийг баталсан байдаг. Тус станцын хүчин чадлыг 250 МВт-аар нэмэгдүүлэх төслийн ТЭЗҮ-ийг БНХАУ-ын цахилгаан эрчим хүчний судалгаа, зураг төслийн институт 2014 онд боловсруулсан байдаг. 2017 онд ЭХЯ-аас түлхүүр гардуулах гэрээгээр өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх нөхцөлтэй Улаанбаатарын хотын “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн

дунд даралтын 48 МВт-ын хэсгийг буулгаж суурин дээр нь 2х125 МВт-ын шинэ дулааны цахилгаан станц барих, станцын цахилгаан, дулаан дамжуулах сүлжээг өргөтгөх төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зарлаж, үнэлгээ хийж барилга угсралтын гэрээ байгуулсан боловч төслийн санхүүжилтийг тодорхойгүй нөхцөлд оруулж төслийн барилга угсралтын гэрээг цуцалсан байдаг.

-ДЦС-3-д хэрэгжүүлсэн төслийн үр дүнг та хэрхэн дүгнэж байна вэ?

-“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК манай улсын 2 дах том дулааны станц бөгөөд Улаанбаатар хотын дулаан хангамжид чухал нөлөөтэй оролцдог.

Холбогдсон ачаалал нь хүчин чадлаа давсан байгаань техникийн элэгдэл, зардлыг нэмэгдүүлж байна. Өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах боломж улам буурч байна. Төсөл хэрэгжсэнээр тогтвортой, найдвартай дулаан, эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бөгөөд шинэчлэгдсэн төслөөр өргөтгөлийн хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлж тооцсон болно. ■

Цахилгаан түгээх сүлжээнд ухаалаг тоолуурын системийн үзүүлэх үр нөлөө


“Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3-т “Эрчим хүчний салбарын найдвартай байдлыг дээшлүүлэх, санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд шилжүүлнэ” гэх зорилтын хүрээнд эрчим хүчний салбарын бие даасан, найдвартай ажиллагааг дэмжих техникийн шийдэл бол технологийн шинэчлэл юм. Технологийн шийдлийн нэг хувилбар болох ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлснээр цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарийн тооцох, хянах, шугамын алдагдлыг бууруулах, найдвартай, тасралтгүй ажиллагааг дэмжих, ухаалаг, хэмнэлттэй хэрэглээг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах зэрэг олон давуу талыг бий болгох боломжтой.

Тус төвийн зүгээс ухаалаг тоолуурын системийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаж буй асуудлыг олж тогтоож, судалгаа хийх зорилгоор системийг анх нэвтрүүлсэн Дархан - Сэлэнгийн бүсэд ажилласан “Дархан - Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК ухаалаг тоолуурын системийг үе шаттайгаар нэвтрүүлэх ажлын хүрээнд 2010-2021 онуудад 35кв, 10кв болон 0.4кв-ын дэд станцуудын шинэчлэл, 35кв-ын нийт 118 км урт цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэл, диспетчерийн хяналтын систем, камерын хяналтын систем цамхгийн хамт, нийт 11 төрлийн программ хангамж, 47,000 мянган тоолуурыг нийт 55,8 тэрбум төгрөгийн томоохон хөрөнгө оруулалтыг амжилттай хэрэгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн юм.

“Дархан - Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК-д ухаалаг тоолуурын систем нэвтэрснээр доорх зэрэг өөрчлөлтүүд гарсан.

1. Иргэдийн хувьд цахилгааны төлбөр тооцоог хялбар хийх, хэрэглээ, аюулгүй байдлыг хянах, цахилгаан эрчим хүчний төлбөрийг үнэн бодит тооцуулах, хэмнэлтийг гаргах, тодорхой хэмжээний эрчим хүч үйлдвэрлэсэн тохиолдолд үндсэн системд буцаан борлуулах боломжтой зэрэг давуу талууд бий болсон.

Зураг 6.3. Айл өрхийн эрчим хүчний төлбөр, 2021 он



Эх сурвалж: “ДСЦТС” ХК

Түүнчлэн бага төлбөр төлөх боломжийг өгч, тарифын мөрдлөгөөр ухаалаг буюу 2 тарифт тоолууртай хэрэглэгчдийн нэг кВт/ц цахилгаан эрчим хүчний шөнийн тариф энгийн тоолууртай хэрэглэгчдээс бага байна.

Зураг 6.4. Айл өрхөд борлуулах цахилгааны сарын тариф




Эх сурвалж: ЭХЗХ

Мөн тоолуур баталгаажуулалтын зардлыг хэмнэх боломжтой бөгөөд ухаалаг тоолууртай хэрэглэгчид механик тоолууртай хэрэглэгчдээс 50%, импульс тоолууртай хэрэглэгчдээс 25 хувиар бага зардлыг тоолуур баталгаажуулалтад зарцуулж байна.

2. Цахилгаан түгээх сүлжээний хувьд хэрэглэгчийн гомдол, санал, дуудлагын тоо, арилжааны болон шугамын алдагдал, тасалдал буурах, ажлын бүтээмж дээшлэх, 50 гаруй төрлийн мэдээллийг авч боловсруулах боломжтойгоос гадна одоо хэрэглэж байгаа тоолуурын заалтыг үргэлжлүүлэн баталгаажуулах боломжтой.


2023 оны I улирлын байдлаар хамаарах бүс нутгийн нийт хэрэглэгчдийн 92 хувьд ухаалаг тоолуурыг амжилттай суурилуулж, эрчим хүчний техникийн алдагдлыг бууруулж, ухаалаг тоолуур суурилуулсан эхний жилүүдэд дуудлагын тоо өссөн хэдий ч хэрэглэгчид системийг ойлгож, сурсны үндсэн дээр дуудлагын тоо тэр хэмжээгээр буурсан.

График 6.1. Тоолуур баталгаажуулах зардлын хэмнэлт 2021 он



Эх сурвалж: "ДСЦТС" ХК

График 6.2. Ахуйн хэрэглэгчдийн дуудлагад зарцуулж буй хугацаа




Эх сурвалж: "ДСЦТС" ХК

Цахилгаан эрчим хүчний төлбөртэй холбоотой цахилгааны хэрэглээг таслуулсан хэрэглэгчийн цахилгаан хангамжийг сэргээхэд гэр хороололд 68 минут, орон сууцанд 49 минут зарцуулдаг байсан бол ухаалаг тоолуурын системийг нэвтрүүлснээр 3-5 минут болж буурсан нь бодит үр дүнд хүрсэн байгааг илтгэж байсан.


Ухаалаг тоолуурын системийг Монгол Улсын хэмжээнд бүрэн нэвтрүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт 2023 оны байдлаар 432.9 тэрбум төгрөг байна.

Диаграмм 6.1. Ухаалаг тоолуур нэвтрүүлэх зардлын задаргаа, 2017 он



Эх сурвалж: Тэргүүлэх төсөвчин Е.Лхүндэв

Диаграмм 6.2. Ухаалаг тоолуур нэвтрүүлэх зардлын задаргаа, 2023 он



Эх сурвалж: "ШСБХТ" УТҮГ

Эрчим хүчний салбарын эдийн засгийн үр өгөөж, үйл ажиллагааны бүтээмжийг харгалзан үзвэл дээрх технологийн шинэчлэл бүхий ухаалаг тоолуурын системийг цахилгаан түгээх сүлжээнд оролцогч байгууллагууд үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлж чадвал үргүй зардлыг бууруулж, найдвартай, тасралтгүй ажиллагааг дэмжих, ухаалаг, хэмнэлттэй

хэрэглээг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах зэрэг олон давуу тал үүсэх боломжтой.


Мөн Стандарт, хэмжил зүйн газраас Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглаж буй цахилгааны тоолуурын загварыг өөрчлөх, шинэчлэх шаардлагатай байгаа тул одоо мөрдөгдөж буй тоолуурын төрөл болон загварыг нэн яаралтай шинэчлэн тогтоох нь зүйтэй.

Устөрөгчийн эрчим хүч Монгол Улсад

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.1-ийн “Өмнийн говийн нар салхины эх үүсгэврийг ашиглаж сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэн Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд эрчим хүч нийлүүлэх судалгаа хийх” зорилтын хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-ын зүгээс устөрөгчийн технологийн хөгжил, үйлдвэрлэлийн шинэ боломжууд, хэрэгжихээр төлөвлөж байгаа болон хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн уялдааг хангаж дэмжлэг үзүүлэх, бодлогын баримт бичгийн төслийг боловсруулахад зохих түвшинд оролцож байна.

Дэлхий дээр өнөөгийн байдлаар жил бүр 120 сая тонн устөрөгч үйлдвэрлэгддэг бөгөөд нийт үйлдвэрлэлийн 95 хувийг саарал устөрөгч буюу байгалийн хий болон нүүрснээс гаргаж авч байна. Устөрөгч нь их хэмжээний эрчим хүчийг ялгаруулдаг онцлогтой элемент.

График 6.3 Устөрөгчийн ялгаруулах эрчим хүчний хэмжээ (Мж/кг)



Эх сурвалж: "ШСБХТ" УТҮГ

Устөрөгчийг эх үүсвэр, гаргаж буй технологиос шалтгаалж ногоон, хүрэн, саарал, цэнхэр, ягаан, цагаан зэрэг ялгаатай нэрлэж байна. Устөрөгчийг байгалийн хий болон нүүрс буюу шатах түлшнээс гарган авч, устөрөгчөөс хамааралтай үйлдвэрлэлд химийн урвалж нөхцөлд ашиглаж байна. Одоогийн байдлаар устөрөгчийн 96 хувийг нүүрстөрөгчийн өөр өөр агууламжтай шатах түлшний төрлүүдээс гарган авч байгаа бөгөөд ногоон устөрөгчийг хэрэглээнд өргөн нэвтрүүлэхэд тулгарч буй хүндрэлийн хувьд шатах түлштэй үнийн хувьд өрсөлдөхүйц байх хэдий ч нөгөө талдаа сэргээгдэх эрчим хүчний өртөг, цахилгаан станцуудын ажиллах үеийн бүтээмж болон тээвэрлэлт, хадгалалттай холбоотой зардлуудыг анхаарах шаардлагатай. Устөрөгчийн хийг шингэрүүлж усан болон авто замаар, хий байдлаар нь хоолойгоор дамжуулах замаар тээвэрлэх боломжтой. Устөрөгч нь зам тээвэр, эрчим хүч, аж ахуйн хэрэглээ, газар тариаланд бордоо, химийн үйлдвэрлэлийн гол түүхий эдийн хэрэглээ болдог. Дэлхий нийтээр 2050 он гэхэд “net-zero” буюу хүлэмжийн хийг 0 түвшинд хүргэх зорилт тавьсан. Хүлэмжийн хийг бууруулахад ногоон устөрөгчийн хэрэглээ, ач холбогдол өндөр хэмээн үзэж анхаарал хандуулж судалж, түршиж, хөгжүүлж байна.

Устөрөгч нь эрчим хүчийг хадгалах, тэсвэртэй байдлыг бий болгож, их хэмжээгээр шугам хоолойгоор болон бусад хэлбэрээр тээвэрлэх боломжтой тул хүлэмжийн хий бага ялгаруулдаг эрчим хүчний салбарыг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэх элемент болоод байна. Устөрөгчийн технологи хөгжихийн хэрээр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зардал буурч өрсөлдөх чадвар нь нэмэгдэхээр төлөвтэй байна.

Нийт устөрөгчийн хэрэглээний 75 хувийг нь БНХАУ, БНЭУ, Япон, Европ тив болон Хойд Америк тивийн улсуудад ногдож, үүнээс БНХАУ хамгийн том хэрэглэгч

- Олон улсад нэвтэрч байгаа шинэ техник, технологийн хөгжлийг нэвтрүүлэх боломжийг судлахын зэрэгцээ боловсон хүчний бэлтгэл чухал байна.

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглан устөрөгч үйлдвэрлэж экспортлох зорилго бүхий гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд энэ чиглэлд судалгааны түвшинд ажиллаж байна.


Япон улсын туршлагаас:

Япон улсын Засгийн газар 2011 оноос хойш аюулгүй атомын цахилгаан станц, нүүрсхүчлийн ялгаралгүй цэвэр эрчим хүчний технологийн судалгаа, хөгжүүлэлтэд санхүүжилт, бодлогын дэмжлэг үзүүлж ирсэн. Үүний үр дүнд 2030 он гэхэд нүүрсхүчлийн ялгаралгүй цэвэр эрчим хүч гарган авах технологийг хөгжүүлж арилжааны хэлбэрт оруулахаар ажиллаж байна. Уг ажлын хүрээнд нүүрсийг хийжүүлэх аргаар цахилгаан үйлдвэрлэж ялгарсан нүүрсхүчлийг

газрын гүнд шахах байдлаар цэвэр эрчим хүч үйлдвэрлэх, давхар устөрөгч гарган авах технологи бүхий 166 МВт хүчин чадалтай цахилгаан станцыг байгуулсан. Тус станцад нийт 30 гаруй хүн 4 ээлжээр ажиллаж, технологийн хөгжлийг ашиглаж давхар бүтээмжийг авчирч байна. Түүнчлэн хийн хөргүүр бүхий өндөр температурын реактораар цахилгаан, устөрөгч үйлдвэрлэх технологийг хөгжүүлсэн. Фукушимайн атомын цахилгаан станцын ослын дараа Япон улс аюулгүй байдал, технологийн шинэчлэлд анхаарч, үүнийг хөгжүүлэх төслийн баг гаргасан нь үр дүнгээ өгч уг төрлийн туршилтын станц амжилттай байгуулагдсан. Өндөр температурын реактор нь цахилгаан болон устөрөгчийг үйлдвэрлэх бөгөөд сэлгэх чадвар 16 хувиас дээш байгаа нь Монгол Улсын оргил ачаалалд оролцох боломжтой түргэн сэлгэх чадвартайг харуулж байна.

Дэлхий нийтээрээ хүлэмжийн хий, нүүрсхүчлийн хийг ихээр үйлдвэрлэгч эрчим хүчний салбарт анхаарал хандуулж, ногоон үйлдвэрлэлийг дэмжих

Зураг 6.6 Нүүрсийг хийжүүлэх замаар эрчим хүч үйлдвэрлэх технологийн процесс



Эх сурвалж: osaki-coolgen.jp

зорилгоор энэ төрлийн төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт, санхүүжилтийн орон зай хангалттай байгаа нь эрчим хүчний салбарт үстөрөгчийн үйлдвэрлэл хөгжих үндсэн хөшүүрэг болохоор байна.

Монгол Улсад үстөрөгчийн үйлдвэрлэл, хэрэглээг нэвтрүүлэхэд хөрөнгө оруулалтын орчин,

тээвэрлэлтийн нөхцөл, дотоод зах зээлийн хэрэглээ, экспортын боломж, бодлого ямар түвшинд байх, татварын бодлого зэрэг хүчин зүйлсийг оновчтой тодорхойлох нь чухал. Түүнчлэн энэ чиглэлээр нарийн мэргэжлийн боловсон хүчийг бэлтгэхэд анхаарал хандуулах шаардлагатай.

Сэргээгдэх эрчим хүчний экспортын боломж

2001 онд АНУ-ын Сэргээгдэх эрчим хүчний үндэсний лаборатори болон Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний үндэсний төвийн хамтарсан судалгаагаар Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний (салхи+нар) боломжит нөөцийг 2.6 ТВт гэж тогтоосон. 2023 оны байдлаар Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 271 МВт байгаа нь зөвхөн дотоодын хэрэгцээнд ашиглагддаг бөгөөд эрчим хүчний нийт хэрэглээний 20 (БНХАУ-15%, ОХУ-5%) орчим хувийг хоёр хөршөөсөө импортолж байна. Монгол Улсын хувьд эрчим хүчний импортлогч орноос экспортлогч орон болох нь эдийн засаг болон эрчим хүчний хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

Түүхий эдийн экспортоос хэт хамааралтай Монгол Улсын хувьд цахилгаан эрчим хүчийг экспортлох нь эдийн засгийг солонгоруулах нэг том боломж юм.

БНХАУ 2022 онд 27,178 МВт хүчин чадалтай, 2023 оны эхний хагаст 17,019 МВт хүчин чадалтай нүүрсний цахилгаан станцыг ашиглалтад оруулж, цаашид үргэлжлүүлэн нэмэгдүүлж байгаа нь ногоон эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүлэмжийн хийг бууруулах дотоодын болон дэлхийн зорилтыг хангахын тулд сэргээгдэх эрчим хүчний эрэлт хэрэгцээ, орон зай Монгол Улсад байгааг харуулж байна.


Манай орны хувьд хүн ам цөөтэй, тархан суурьшсан, газар нутаг томтой улсын хувьд сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх нь давуу тал болох боломжтой. Харин зарим улс орнууд, тэр дундаа БНХАУ-ын хувьд хүн амын нягтаршил өндөр болон газар зохион байгуулалтын төвөгтэй зохицуулалтууд зэрэг нь сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх, ашиглахад хүндрэлтэй байдлыг үүсгэж байгааг судалгаанууд харуулсан.

Одоогийн боломж

БНХАУ-ын судалгааны байгууллагуудын зүгээс Монголын говь, цөлийн бүсэд нийт 2.1 ГВт хүчин чадал бүхий сэргээгдэх эрчим хүчний төслийг хөгжүүлэх сонирхолтой байгааг илэрхийлсэн. Хоёр улсын хамтарсан компани байгуулах замаар худалдах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах боломжтой. Эрчим хүчний борлуулалтын тодорхой хэсэг нь тоо хэмжээ, тарифыг тодорхойлсон тогтмол урт хугацааны биет гэрээгээр хийгдэж, харин үлдсэн бага хувийг нь Өвөр Монголын цахилгаан эрчим хүчний бөөний/спот зах зээл дээр худалдаж борлуулах юм. Энэхүү төсөл Монгол Улсын дотоод зах зээлээс бүрэн тусдаа үйл ажиллагаа явуулах сонирхолтой бөгөөд нөхцөл байдлаас хамаарч Монгол Улсын импортын хэмжээг тохиролцож эргээд Монгол Улсын дотоодын хэрэгцээг хангах боломжтой. Хэрэв анхны төслийг амжилттай хэрэгжүүлбэл 10 ГВт-ын хүчин чадалтай нар, салхины төслийг хөгжүүлэх сонирхол байгааг хөрөнгө оруулагч талууд илэрхийлсэн.

Оюу Толгойн зэсийн уурхай эрчим хүчний хэрэгцээгээ хангах зорилгоор БНХАУ-тай цахилгаан эрчим хүч импортлох/экспортлох гэрээг байгуулж 2011 онд БНХАУ-тай холбогдсон өөрийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж, 2012 онд нийт 96 км урттай, хоёр хэлхээт 220 кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамыг ашиглалтад оруулсан. Цахилгаан дамжуулах агаарын шугамыг 2015 онд эрчим хүч нийлүүлэх гэрээний дагуу Монгол Улсын Засгийн газарт хүлээлгэн өгсөн бөгөөд дамжуулах систем нь өөрөө давуу эрхтэй, үүнтэй холбоотой хөрөнгө оруулалтын эргэн төлөлт, хил дамнасан зохицуулалтыг аль аль талдаа ашигтай хэлбэрээр хийх шаардлагатай. Эрчим хүч үйлдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,

Зураг 6.7 Өмнийн говийн сэргээгдэх эрчим хүчийг БНХАУ-руу экспортлох цахилгаан дамжуулах агаарын шугамын төсөөлөл



Эх сурвалж: ЭХЯ

цахилгаан экспортлохын тулд дамжуулах системийн үйл ажиллагааны өртөг болон хөрөнгө оруулалтыг тусгасан зохицуулалттай байх шаардлагатай. Цахилгаан дамжуулах шугамын хөрөнгө оруулалтыг зохицуулах үүднээс хоёр улсын хамтарсан компани байгуулж болно. Энэхүү компанийн хувьд шугамын угсралт, ашиглалтад оруулах зэргийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хувийн хэвшилд өгөх, эсвэл өөрөө бие даан уг үйл ажиллагааг явуулж болно. Үүнээс гадна цахилгаан дамжуулах шугамын эзэмшигч нь цахилгаан үйлдвэрлэгч байвал давуу эрхтэй байхаас урьдчилан сэргийлэхийн тулд системийн зохицуулалтыг хийх нь чухал юм.

Цаашид цахилгаан эрчим хүчний экспортын судалгааг хөгжүүлэхэд холбогдох яамнаас гадна хоёр улсын хооронд гадаад худалдааны түншлэлийн хүрээнд яриа хэлэлцээрийг хийж, хөрш орнуудын оролцоог зохистой байдлаар хангаж ажиллах, судалгааг хийх, цахилгаан эрчим хүчний хил дамнасан худалдаанд шаардлагатай хөрөнгө оруулалтын орчныг бий болгох, журмыг боловсруулах, зохицуулалтыг тохиролцох тал дээр хамтран ажиллах шаардлагатай.

Сэргээгдэх эрчим хүчний экспортын төсөл амжилттай хэрэгжсэнээр бусад салбарын гадаадын шууд хөрөнгө оруулалт болон Монгол Улсын газар зүйн стратегийн байр суурийг нэмэгдүүлж, улс төрийн хөшүүрэг болно.


Эрчим хүчний салбарын шинэчлэлийн боломжит хувилбар

"Шинэ сэргэлтийн бодлого"-оор эрчим хүчний салбарыг Монгол Улсын эдийн засгийг хязгаарлагч суурь хүчин зүйлсийн нэг гэж тодорхойлсон бөгөөд "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3 "Эрчим хүчний салбарыг санхүү, эдийн засгийн бие даасан тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлэх" зорилтын хүрээнд холбогдох байгууллагатай хамтран цахилгаан эрчим хүчний хэрэглээний төлбөр, өртөгтэй холбоотой суурь судалгаа, дүн шинжилгээг хийх замаар салбарын шинэчлэлийн замын зураг боловсруулах, холбогдох судалгаа, дүн шинжилгээг хийсэн.

Эрчим хүчний хэрэглээний өсөлт

Монгол Улсын эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 6-7 хувийн өсөлттэй байна. Өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангахын тулд нийт эрчим хүчний нийлүүлэлтийн ачааллаас хамаарч Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд 5 гаруй хувийг импортоор авч байна.

График 6.6 Цахилгааны хэрэглээний өсөлт (сая кВт.ц)



Эх сурвалж: ЭХЗХ


- Гүйцэтгэл
- Урьдчилсан тооцоолол

* Хэрэглээний өсөлтийг жилийн 6 хувиар тооцсон

Эх үүсвэрийн дутагдал

Өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах эх үүсвэрийн дутагдлыг шийдвэрлэх асуудал жил бүр тулгарч байна. "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хөгжлийн төслүүдэд багтсан эх үүсвэрүүд ашиглалтад орсон ч өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах хэмжээнд очихгүй. Үүнээс гадна хэрэглээ, үйлдвэрлэлийн тэнцвэртэй байдалд сөргөөр нөлөөлөх нэг том хүчин зүйл бол оргил ачаалал. Эх үүсвэрийн нэмэлтэд хүндрэл учруулж буй гол хүчин зүйлс нь цахилгаан станцуудын хөрөнгө оруулалтыг нөхөх, бодит өртөгт хүрсэн тарифыг хэрэгжүүлэхгүй байгаа явдал юм.

График 6.7 Цахилгаан эрчим хүчний оргил ачаалалд дотоодын эх үүсвэрийн оролцоо МВт



Эх сурвалж: "ШСБХТ" УТҮГ

Хязгаарлагдмал хөрөнгө оруулалт

Эрчим хүчний эх үүсвэрийн төслүүдийн хөрөнгө оруулалтыг нөхөх хамгийн чухал үзүүлэлт нь эрчим хүчний үнэ тариф, зээлийн эргэн төлөлтийн найдвартай байдал, Засгийн газрын баталгаа зэрэг олон хүчин зүйлсээс хамааралтай. Шинээр төлөвлөгдөж буй сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд тарифын хэлцэл, цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний нөхцөл, найдвартай, тогтвортой байдалтай холбоотой олон асуудал хүлээгдэж байна.

"Шинэ сэргэлтийн бодлого"-д туссан эрчим хүчний хөгжлийн 22 төслөөс 2023 оны байдлаар дараах 5 төсөл хэрэгжиж байна.

Хүснэгт 6.1 Шинэ сэргэлтийн бодлогод туссан эрчим хүчний төслүүдээс хэрэгжиж буй төслүүд

№	Төслийн нэр	Хүчин чадал	Хэлбэр	Санхүүжилт
1	Чойбалсангийн ДЦС	50 МВт	Өргөтгөл	Хөгжлийн банк Улсын төсөв
2	Амгалан ДЦС-ын өргөтгөл	115 МВт	Өргөтгөл	Хөгжлийн банк Улсын төсөв
3	Эрдэнэбүрэнгийн УЦС	90 МВт	Шинэ	Гадаад зээл Улсын төсөв
4	Бөөрөлжүүтийн ЦС	300 МВт	Шинэ	ТХХТ
5	Сэргээгдэх эрчим хүчний төслүүд	45 МВт	Шинэ	Гадаад зээл Хувийн хөрөнгө оруулалт

Эх сурвалж: ЭХЯ


ТӨХК-ийн засаглал

Дулааны цахилгаан станцуудын насжилт, эрчим хүчний зардалд суурилсан тариф, санхүүгийн алдагдалтай байдал зэрэг олон хүндрэлээс үүдэн төрийн өмчит эх үүсвэрүүд гадаад болон дотоод зах зээлээс хөрөнгө оруулалт, санхүүжилт татах боломжгүй байна. Шинэчлэлийг тал бүрээс нь шийдвэрлэх үүднээс ТӨХК-д гүйцэтгэлд суурилсан, зөв менежментийг бий болгосон, сайн засаглалыг хэвшүүлж нэвтрүүлэх ажлыг бий болгох шаардлагатай. Эрчим хүч бол гал үл алдаж болох салбар учир оновчтой түвшинд удирдан зохион байгуулах нь чухал. Мөн төрийн өмчит эрчим хүчний компаниудын хувьцааны тодорхой хувь хэмжээг тухайн компанийн ажилтнуудад эзэмшүүлэх, олон нийтэд нээлттэй ил тод болгож, засаглалын хяналтыг сайжруулж, жишгийг бүрдүүлж чадвал санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх боломжтой. Нөгөө талд үнэ тарифыг бодит өртөлт хүргэн борлуулах боломж нөхцөлийг бүрдүүлбэл хөрөнгө оруулалт болон санхүүжилт татах, үр ашигтай ажиллах нэг хөшүүрэг болно.

2022 оны байдлаар Монгол Улсын өрхийн дундаж орлогын 2.2 хувийг цахилгааны төлбөр эзэлж байгаа нь олон улсын дундаж 5 хувьтай харьцуулахад 2 дахин бага байна.


Мэдээж зарим улс орнуудад тариф хямд байгаа нь өндөр хэмжээний татаастай холбоотой.

График 6.8 Эрчим хүчний ТӨХК-ийн алдагдал (тэрбум төгрөг)



Эх сурвалж: ЭХЗХ

График 6.9 Өрхийн орлого ба цахилгааны төлбөр




Эх сурвалж: YCX, ЭХЗХ

График 6.10 Өрхийн цахилгааны хэрэглээ, улсын хэмжээнд




Эх сурвалж: YCX, ЭХЗХ

График 6.11 Улс орнуудын өрх гэрийн цахилгааны үнэ тариф 1 кВт/ц доллар




Эх сурвалж: World bank, 2022, Global petrol price, 2022

График 6.12 Улс орнуудын эрчим хүчний татаас




Эх сурвалж: globalenergymonitor.org

График 6.13 Өрхийн цахилгааны хэрэглээ, өрхийн хэмжээнд



Эх сурвалж: ЭХЗХ

График 6.14 Өрхийн орлого ба цахилгааны төлбөр



Эх сурвалж: "ШСБХТ" УТУГ

Бодит өртөгт суурилсан тарифын шинэчлэлийг хэрэгжүүлснээр эрчим хүчний салбарын жил бүр өсөн нэмэгдэж буй өр, төлбөр, алдагдлын хэмжээг бууруулах орон зай үүсэх боломжтой.


Хүснэгт 6.2 Тарифын нэмэлт инфляцад үзүүлэх нөлөөлөл

4	Цахилгаан, дулааны эрчим хүчний 1.0 хувийн өсөлтийн жилийн дүнгээр үүсэх инфляц	0.05%
5	Цахигаан, дулааны эрчим хүчний тарифыг 28.0 хувиар өсгөхөд үүсэх инфляц	1.54%

Эх сурвалж: ЭХЗХ

Өрхийн цахилгааны төлбөр 10 хувиар нэмэгдэхэд хэрэглээний үнийн индексээр тооцсон жилийн инфляц 0.2 хувь, нийт эдийн засгийн салбаруудын оролцогч нарын зардал 0.5 хувиар өсөх магадлалтай байна.

График 6.15 Монгол Улсын эрчим хүчний салбарын өр төлбөр, алдагдал



Эх сурвалж: ЭХЗХ

Шинэчлэлийн туршлага, хэлбэр:


Үнэ тарифын шинэчлэл хийснээр салбарын асуудал бүрэн шийдэгдэхгүй, шинэчлэлийг цогцоор нь авч үзэх шаардлагатай. Үүний тулд эрчим хүчний салбарын оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагын тогтолцооны өөрчлөлт хийх шаардлагатай бөгөөд олон улс орны туршлагаас харахад эрчим хүчний шинэчлэлийг хийсэн хэдий ч бүгд амжилттай болоогүй.

Нэг худалдан авагчтай загвар дээр үлдэж гацсан олон улс байдаг бөгөөд Монгол Улсын хувьд салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй хүндрэлүүд зэрэг хүчин зүйлсээс хамаарч дараагийн шат буюу бөөний зах зээлийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Энэ алхмыг хийхэд олон талын оролцоо, дэмжлэг шаардлагатай бөгөөд улс орон бүр өөрийн онцлогт тулгуурлан бөөний зах зээл буюу өрсөлдөөнт зах зээлийг хөгжүүлсэн байдаг.

Эх үүсвэр буюу цахилгаан станцууд, нөөц, эдийн засгийн чадамж, хэрэглэгчийн сэтгэл зүй, бодлогын баримт бичиг, хууль эрх зүйн орчин зэрэг олон хүчин зүйлийн нөлөөллөөс шинэчлэл амжилттай болох эсэх нь тодорхойлогддог.

Бөөний буюу өрсөлдөөнт зах зээл:


Эрчим хүчний бөөний зах зээл нь хэрэгцээ, нийлүүлэлт буюу зах зээлийн зарчмаар явагддаг бөгөөд хэрэглээ байхад нийлүүлэгч тал өрсөлдөөний зарчмаар хэрэглээг хангах юм. Үнэ, гэрээний нөхцөл зэргээс хамаарч өрсөлдөөн үүсэж үүнийг дагаж салбар өөрөө хөгжсөнөөр хөрөнгө оруулалт татах, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, салбарын бие даасан байдал, улсын эрчим хүчний хараат байдал зэрэг хүндрэлтэй асуудлууд шийдэгдэх суурь тавигдах юм.

Зураг 6.8 Олон улсын эрчим хүчний зах зээл

Эх сурвалж: International Energy Agency

Олон улсын туршлагаас Чилийн эрчим хүчний салбарын судалж үзэхэд 1978 оноос шинэчлэл хийсэн бөгөөд тухайн үед Чилийн нэг хүнд ноогдох ДНБ

өнөөдрийн Монгол Улсаас бага байсан. Тус улсын шинэчлэл эх үүсвэрүүд болон дамжуулах сүлжээний хувьчлал, тарифын тохируулга, бодит өртгөөс эхэлсэн.

Зураг 6.9 Чилийн эрчим хүчний шинэчлэлийн он цагийн хэлхээ


Чилийн эрчим хүчний шинэчлэл нь улс төрийн өөрчлөлтөөс үл хамааран үргэлжилсэн нь шинэчлэл амжилттай явагдах суурь нөхцөлийн нэг болсон

Эх сурвалж: "ШСБХТ" УТҮГ

Нэвтрүүлэх боломжит хувилбар

Өрсөлдөөнт буюу бөөний зах зээлийг нэвтрүүлэхэд Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд тохиромжтой байдлаар хийх шаардлагатай бөгөөд дараах холимог өрсөлдөөнт зах зээлийн хувилбарыг тохиромжтой гэж тодорхойлов.

Зураг 6.10 Монгол Улсын эрчим хүчний салбар өрсөлдөөнт бөөний зах зээл рүү шилжих хувилбар



Эх сурвалж: "ШСБХТ" УТҮГ

Жич: Эхний ээлжинд ДЦС-ын үйлдвэрлэлийн тодорхой хувийг өрсөлдөөнт зах зээлд оруулах болно.

Өрсөлдөөнт зах зээл нэвтэрснээр дараах үр дүн гарах боломжтой.


Үйлдвэрлэгч талд	Хэрэглэгч талд
Татаасгүй өртөгтөө хүрсэн борлуулалт хийгдэнэ	Бодит үнээр (татаасгүй) худалдан авалт хийгдэнэ
Хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэл хийгдэх боломж бүрдэнэ	Найдвартай үйлчилгээг шаардах эрхтэй болно.
Хараат бус, бие даасан тогтолцоонд шилжиж, хяналт сайжирна	Хэрэглээгээ бүрэн хянах замаар төлбөрөө зохицуулах боломжтой болно.

Монгол Улсад эрчим хүчний бөөний буюу өрсөлдөөнт зах зээлийг нэвтрүүлэх боломжийг дараах алхмуудаар тодорхойлж байна: Тарифын шинэчлэлийг өрсөлдөөнт зах зээлийн бэлтгэл ажилтай хамт хэрэгжүүлснээр зах зээлийн суурь нөхцөлийг хангах.

1. Бодит өртөгт суурилсан тарифын тогтолцоо руу шилжих.

Эрчим хүч, түүхий эд нийлүүлэгч, тээвэрлэгч, үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч нарын бодит өртгийг тусгасан тооцоололд үндэслэн үйлдвэрлэлийн өртөгт хүрэх тарифыг хэрэгжүүлэх.

Зураг 6.11 Өрсөлдөөнт зах зээл нэвтрүүлэх хувилбарын схем




Эх сурвалж: "ШСБХТ" УТҮГ

Үүнтэй уялдуулан нүүрсний уурхайд, цахилгаан станцууд, диспетчерийн үндэсний төв, дамжуулах, түгээх сүлжээний зардлын хуваарилалтыг байгууллага бүрээр шинэчлэн хийх хэрэгтэй. Бодит өртөгт суурилсан тарифын шинэчлэл хийгдсэнээр эрчим хүч үйлдвэрлэгч талуудын өр, төлбөр, алдагдал буурч, ашигтай ажиллах суурь нөхцөл бүрдэнэ.

2. Өрсөлдөөнт зах зээлийг нэвтрүүлэх хугацаа нь эрчим хүчний эх үүсвэр хэрэглээний хэмжээнд хүрсэн үе буюу 2029 оныг боломжит хугацаа гэж үзэж байна.


График 6.16 2029 он буюу эрэлт, нийлүүлэлт тэнцэх жил



Эх сурвалж: "ШСБХТ" УТҮГ

Монгол Улсын эрчим хүчний салбар өрсөлдөөнт зах зээлийн зарчимд шилжсэнээр эх үүсвэрийн дутагдал, салбарын татаасны сүлжээ, компанийн засаглал, өртөгтөө хүрсэн борлуулалт, хөрөнгө оруулалт, сэргээгдэх эрчим хүчний төслүүд нэмэгдэх зэрэг салбарын тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэгдэх цаашлаад Монгол Улс эрчим хүчний бие даасан орчныг бүрдүүлж, сэргээгдэх эрчим хүчийг экспортлох, Азийн супер сүлжээнд нэгдэх зэрэг ирээдүйн том зорилтууд хийгдэх суурь тавигдах юм. Харин бид энэ шийдвэрийг гаргахад бэлэн үү?

АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛД БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛӨЛ



МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТЭС



Авто замын түгжрэлд боловсролын салбарын үзүүлж буй нөлөөлөл


Авто замын түгжрэл нь Улаанбаатар хотод төдийгүй дэлхийн олон хотод ноцтой асуудал болоод байна.

Агаар орчныг бохирдуулах, эрүүл мэнд цаашлаад, улс орны эдийн засагт ч сөргөөр нөлөөлж буй. Дэлхийн орнууд түгжрэлийг бууруулахын тулд нийтийн тээврийн хүрэлцээг нэмэгдүүлэх, үйлчилгээгээ сайжруулах, явган зорчигчид болон дугуй, скүүтерт зориулсан дэд бүтцийг бий болгох, ажлын уян хатан цаг болон зайнаас ажиллах боломжийг судлах, уриалах, хотын дэд бүтцийг сайтар төлөвлөх, оргил цагаар болон их ачааллын бүсүүдэд зорчих автомашины хөдөлгөөнийг татвар хураамжаар зохицуулах гэх мэт олон аргыг хэрэгжүүлдэг туршлага байдаг. Монгол Улсад ч энэхүү

арга аргачлалыг, эхнээс нь хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч аливаа бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах үр дүн, эдийн засгийн үр ашиг, үр дагавруудыг тэр болгон бодитой хэмжиж, тооцоолж чаддаггүй.

Замын түгжрэл нь авто замын сүлжээн дэх зорчигчдын замын хөдөлгөөнд оролцох эрэлт, шаардлага нөгөө талаас, автозамын дэд бүтцийн нийлүүлэлт хоёрын харьцаа алдагдсанаас үүсдэг. "Авто замын түгжрэлд боловсролын салбарын үзүүлэх нөлөө" сэдвийн хүрээнд хийсэн судалгаагаар нийслэлийн сургууль, цэцэрлэг болон их дээд сургуулийн оюутнууд хичээлдээ явахдаа хол зам түүлах эрэлт хэрэгцээг бууруулснаар ямар үр дүн гарч болохыг харууллаа.

Зураг 7.1 Улаанбаатар хот дахь ЕБС-д хамрагдаж буй сурагчдын гэрээс сургууль хүртэлх зай




Улаанбаатар хотод буй голлох 239 уулзварыг сонгон авч тэдгээр уулзварын GPS координат болон хоорондын холболт болох 670 орчим холбоос замыг чиглэлийн хамт гараар тэмдэглэв.


Нийслэлийн Нийтийн тээврийн газраас 2022 онд хүчинтэй байсан нийт 112 нийтийн тээврийн шугамуудын орон зайн өгөгдлийг, давхардсан тоогоор 4313 автобусны буудлын байршилтай авч, өгөгдлийн цэвэрлэгээ хийн бэлтгэв.

Улаанбаатар хотын газар нутгийг НЗДТГ болон ММСГ судалгааны байгууллагын хийсэн “Улаанбаатар хотын замын хөдөлгөөний зорчих хөдөлгөөний тайлан”-аас санаа аван бүсүүдэд хуваав.


Улаанбаатар Смарт Карт ХХК-аас 2022 оны 3 болон 7 сарын картын төлбөрийн мэдээллийг задгай хэлбэрээр авч ашиглав. Ашигласан талбарууд: Автобусны чиглэл, төлбөр хийгдсэн хугацаа, Суух/Буух, Автобусны буудлын нэр, Буудлын урд/Хойд, Тээврийн хэрэгслийн ID.



Зураг 7.3 Улаанбаатар хотын нийтийн тээврийн сүлжээ 2022 он



Зураг 7.4 Улаанбаатар хотын бүсчлэл/ММСГ/




Судалгааны арга зүй

Боловсролын салбарын нөлөөллийг бодитоор харах боломж бол боловсролын салбарын идэвхтэй болон амарсан үеийг хооронд нь харьцуулан шинжлэх явдал юм.

Өөрөөр хэлбэл, зуны саруудад хичээл сургууль амарч, албан байгууллагуудын амралт эхэлсэн байх үеэр Улаанбаатар хотод замын хөдөлгөөний ачаалал эрс буурах үе /Үндэсний баяр наадмын өдрүүдийг хассан болно/ болон замын хөдөлгөөний ид ачаалалтай үе буюу 3 сарын замын хөдөлгөөний ачааллыг харьцуулж харах, түүнчлэн ажлын болон амралтын өдрүүдийн хооронд гарч буй өөрчлөлтийг ажиглах хэрэгтэй.

Схем 7.1 Боловсролын салбарын нөлөөллийг тодорхойлох



Хүснэгт 7.1 Нийтийн тээврийн төлбөрийн мэдээллийн дата жишээ /Смарт карт ХХК/


Чиглэл	Төлбөр хийгдсэн хугацаа	Суусан/ буусан	Автобусны зогсоол	Зогсоолын байршил	Тээврийн хэрэгслийн ID
Ч:2	2023-03-06 06:59:17	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:18	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:22	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:23	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:26	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:27	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:30	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:32	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:36	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:41	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:46	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 06:59:49	Суух	ШАР ХАДНЫ ЭЦЭС	Зүүн	972609323
Ч:2	2023-03-06 07:03:28	Суух	11-р байр	Урд	972609323
Ч:2	2023-03-06 07:03:30	Суух	11-р байр	Урд	972609323
Ч:2	2023-03-06 07:03:32	Суух	11-р байр	Урд	972609323
Ч:2	2023-03-06 07:03:40	Суух	11-р байр	Урд	972609323
Ч:2	2023-03-06 07:03:44	Суух	11-р байр	Урд	972609323
Ч:2	2023-03-06 07:03:50	Суух	11-р байр	Урд	972609323
Ч:2	2023-03-06 07:05:44	Буух	Парадокс	Урд	972609323
Ч:2	2023-03-06 07:06:28	Суух	Парадокс	Урд	972609323

Замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдийн тухайн байршил болон цаг мөч дэх дундаж хурдыг тооцоолох нь хүндрэлтэй юм. Хамгийн боломжийн найдвартай аргаар тооцохын тулд ЭМПИРИК судалгаа хийх эсвэл Google Maps API ашиглах боломжууд

бий. Гэхдээ эдгээр нь өртөг өндөртэй. Тиймээс нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрийн мэдээллийг ашиглан замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдийн дундаж хурдыг дараах байдлаар тооцоолох аргыг авч ашиглав.

Улаанбаатар хотын автозамын сүлжээний дундаж хурд

Зураг 7.6 Улаанбаатар хотын автозамын дундаж хурд 9 бүсээр



Дээр дурдсан аргачлалуудыг ашиглан Улаанбаатар хотын 9 бүс тус бүрийн хурдыг тооцоолоход /Зураг 7.6/

Хотын зүүн бүс


• 1,2,3 болон 6 дугаар бүс буюу Хотын баруун, зүүн, төвийн бүс болон урд бүсүүдэд/Зайсан орчмоор/ 3 сарын дундаж хурд 7 сартай харьцуулахад хамгийн ихээр удааширч байна.

• 4,5,7,8 болон 9 дүгээр бүс буюу хотын захын бүсүүдэд зуны улиралдаа/7 сар/ илүү удаашралтай байна.

• Өглөөний 7.00–9.00 цагийн дундаж хурдыг онцолж харвал 11.9км/ц хурдтайгаар Зайсан орчмын бүс хамгийн удаан, 12.4км/ц хурдтайгаар хотын төвийн Их тойруугийн бүс дараа нь орж байна.

• Энэ цагийн интервалд, 3 сарын ажлын өдрүүдээс бусад үеүд буюу 7-р сард ба 3-р сарын амралтын өдрүүдэд дундаж хурд 18 км/цаг байгааг харж байна.

Зураг 7.7 Өглөөний 7:00–9:00 цагийн дундаж хурд



Хурдны харьцуулалт

Дүгнэлт: 3-р сарын ажлын өдрийг 7-р сарын ажлын өдөртэй харьцуулахад /Хүснэгт 7.3/, 7-9 цагт 1,2,3 болон 6-р бүсэд хамгийн их буюу 20-40 хувийн хурдны удаашралтай байгаа ба энэ нь

тус цагууд дахь 3 сарын ажлын нөлөөгөөр тус бүсүүдээр зорчиж буй тээврийн хэрэгслүүдийн дундаж хурд 20-40 хувиар удааширч байна.

Хүснэгт 7.3 Гурав болон долоодугаар сарын ажлын өдрүүдийн дундаж хурдны зөрүү										
Бүсээр										
Цагийн интервал	Их тойруу	Баруун бүс	Зүүн бүс	4	5	6	7	8	9	
[7-9]	30%	19%	21%	1%	0%	39%	8%	6%	1%	
[9-10]	15%	3%	-3%	-9%	-15%	15%	-3%	-9%	-15%	
[10-12]	1%	-8%	-6%	-19%	-17%	-5%	-4%	-9%	-17%	
[12-15]	7%	-3%	1%	-5%	-9%	0%	-2%	-1%	-22%	
[17-20]	21%	5%	8%	1%	-11%	-10%	3%	4%	-10%	
[20-23]	2%	-2%	-3%	-5%	-28%	4%	-13%	-1%	-18%	

Хүснэгт 7.4 Долоодугаар сарын ажлын болон амралтын өдрүүдийн дундаж хурдны зөрүү										
Бүсээр										
Цагийн интервал	Их тойруу	Баруун бүс	Зүүн бүс	4	5	6	7	8	9	
[7-9]	2%	3%	0%	13%	7%	-5%	-8%	12%	8%	
[9-10]	12%	4%	3%	-2%	1%	15%	-1%	2%	2%	
[10-12]	13%	8%	8%	5%	3%	24%	2%	1%	6%	
[12-15]	13%	10%	4%	-8%	-7%	16%	1%	5%	9%	
[17-20]	22%	18%	9%	-2%	-11%	22%	5%	4%	12%	
[20-23]	19%	13%	10%	-6%	-3%	21%	6%	1%	8%	

Хүснэгт 7.5 Гурав болон долоодугаар сарын амралтын өдрүүдийн дундаж хурдны зөрүү										
Бүсээр										
Цагийн интервал	Их тойруу	Баруун бүс	Зүүн бүс	4	5	6	7	8	9	
[7-9]	2%	1%	0%	4%	-1%	-9%	0%	7%	-3%	
[9-10]	3%	0%	0%	-5%	-9%	5%	6%	-2%	-4%	
[10-12]	6%	4%	4%	-4%	-8%	10%	2%	-4%	-11%	
[12-15]	12%	9%	4%	-15%	-18%	15%	-2%	3%	-12%	
[17-20]	10%	8%	5%	-6%	-21%	15%	-4%	1%	-12%	
[20-23]	9%	5%	3%	-15%	-23%	14%	-5%	-3%	-3%	


Хүснэгт 7.6 Гуравдугаар сарын ажлын болон амралтын өдрүүдийн дундаж хурдны зөрүү										
Бүсээр										
Цагийн интервал	Их тойруу	Баруун бүс	Зүүн бүс	4	5	6	7	8	9	
[7-9]	30%	21%	20%	10%	8%	41%	1%	12%	11%	
[9-10]	23%	7%	1%	-6%	-4%	24%	-11%	-6%	-8%	
[10-12]	9%	-3%	-1%	-9%	-4%	12%	-4%	-3%	0%	
[12-15]	8%	-1%	0%	1%	1%	1%	1%	1%	1%	
[17-20]	32%	15%	12%	5%	-1%	-1%	11%	8%	14%	
[20-23]	13%	6%	5%	2%	-8%	12%	-1%	3%	-5%	

ЕБС-ийн төвлөрөл ихтэй байршлуудад хурд илүүтэй удааширч байгаа юу?

2022 оны байдлаар Улаанбаатар хотын нийт 293 ЕБС-д 364,000 орчим суралцагч сурч байна. Үүнээс 1,2,3 болон 6-р бүсэд 153 ЕБС үйл ажиллагаа явуулж байгаа ба энэ нь нэг ээлжийн нийт хүчин чадлын 52 хувь юм. Ерөнхий боловсролын сургуулиудын төвлөрөл нь иргэдийн зорчих хөдөлгөөний эрэлтийг нэмэгдүүлж буй

голлох хүчин зүйлүүдийн нэг. НЗДТГ-ын болон ММСГ судалгааны байгууллагуудын хамтран хийсэн судалгааны дүнд өдөрт дунджаар 1,564,814 очих чиглэлийн хөдөлгөөн хийгдэж байгаа бол түүний 21 хувь нь ЕБС, цэцэрлэгт хүүхдээ хүргэх болон авах зорилготой байна. /Хүснэгт 7.7/

Зураг 7.8. Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулиудын байршил




Хүснэгт 7.7 Улаанбаатар хотын нийт зорчилт хөдөлгөөн, өдрөөр/ММCG/

Хөдөлгөөний чиглэл	Зорчилтын зорилго	Нийт зорчилт	Нийт зорчилтод эзлэх хувь	Очих чиглэлийн хөдөлгөөний зорчилтод эзлэх хувь
Очих хөдөлгөөн	Ажилдаа явах	618,788	21%	40%
	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хүүхдээ хүргэх болон авах	327,593	11%	21%
	Амралт, чөлөөт цагаа өнгөрөөх	267,853	9%	17%
	Худалдаа, үйлчилгээ	158,435	5%	10%
	Төрийн болон нийгмийн үйлчилгээ	99,880	3%	6%
	Их дээд сургууль, сургалт дамжаа	92,265	3%	6%
	Нийт очих хөдөлгөөн	1,564,814	54%	100%
Буцах хөдөлгөөн	Буцах хөдөлгөөн буюу гэрийн зүг чиглэсэн зорчилт	1,317,503	46%	
	Нийт (очих + буцах)	2,882,317	100%	

Улаанбаатар хотын авто зам бүрийн хувьд 500м орчимд хэдэн сургууль харьяалагдаж байгааг тооцоолсны үндсэн дээр ЕБС-ийн төвлөрлөөс үүдэн замын ачаалал ямар байгааг/Зураг 7.9/ мөн 3-р сарын хурдны удаашрал болон ажлын өдрийн удаашрал хэрхэн өөрчлөгдөж/Зураг 7.10/ байгааг харуулав.


500 метрийн зайд сургуульгүй эсвэл 1, 2 сургуультай замууд дээр хурд харьцангуй өндөр байна

Зураг 7.9 Дундаж хурд, тухайн бүс дэх сургуулийн тоогоор



7-р сарын ажлын өдөр болон 7-р сарын амралтын өдрүүдийн хурдны зөрүү замын ойр орчимд байгаа сургуулийн тооноос хамаарах хамаарал ажиглагдахгүй, нэгэн хэвийн харагдаж байгаа бол 3-р болон 7-р сарын ажлын өдрүүдийн хурдны зөрүү сургуулийн тооноос хамааран огцом ихсэж байна /Зураг 7.9/

Зураг 7.10 Дундаж хурд, тухайн бүс дэх сургуулийн тоогоор



Эхний харьцуулалтаар харьцуулсан үеүдэд боловсролын чиглэлийн үйл ажиллагаа аль алинд нь явагдахгүй байгаа учраас ЕБС-ийн тооноос хамаарахгүй, харин дараагийн харьцуулалтаар 3-р сард 7-р сартай харьцуулахад ЕБС олон байгаа хэсгээр илүүтэй удааширч байна.

Дүгнэлт

“Авто замын түгжрэлд боловсролын салбарын үзүүлж буй нөлөөлөл” судалгааны үр дүнгээс харахад боловсролын салбараас үүдэлтэйгээр автомашины хурд хотын төв болон урд хэсгүүдээр 20-40 хувь удааширч байна.

ЕБС, цэцэрлэг, их дээд сургуулийн байршил, багтаамж зэргийг сайтар төлөвлөх нь Монгол Улсын иргэдийн боловсролд чухал төдийгүй нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийн асуудалд ч мөн хамгийн тохиромжтой шийдэл болох нь харагдаж байна.

Цаашид бид зөвхөн боловсролын салбарын нөлөөлөл төдийгүй иргэд болон явган зорчигчдын замын хөдөлгөөнд оролцох, зорчих хөдөлгөөний хэрэгцээ шаардлагуудыг зорилго бүрээр нь нарийвчлан судалж, тэдгээрт зориулсан хот төлөвлөлт, бодлогуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Мөн Улаанбаатар хотын автозамын хурдыг тооцоолох, өөрчлөлтийг хянахын тулд "УБ Смарт Карт" ХХК-ийн автобусны төлбөрийн мэдээллийг ашиглах нь хямд болоод үр дүнтэйг ташрамд дурдъя.

УЛААНБААТАР ХОТЫН ЗОРЧИГЧ ХӨДӨЛГӨӨНИЙ МАТЕМАТИК ЗАГВАРЧЛАЛ СИМУЛЯЦИ



МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ
ХЭЛТЭС




Улаанбаатар хотын зорчигч хөдөлгөөний урсгалын математик загварчлал, симуляцийн судалгаа

Сүүлийн 20 жилд Улаанбаатар хотын хүн амын тоо 2.1 дахин нэмэгдсэн бөгөөд энэ хугацаанд нийтийн тээврийн хэрэгслээр зорчих иргэдийн тоо дөнгөж 17 хувиар нэмэгдсэн байна. Монголд үйл ажиллагаа явуулж буй Японы ЖАЙКА байгууллагын хийсэн судалгаагаар хотын иргэд өдөрт дунджаар 2.5 цагийг, жилд 35 бүтэн өдөртэй тэнцэх хугацааг замын

түгжрэлд өнгөрүүлж, алдагдсан боломжийн өртөг нэг жилд 2.5 их наяд төгрөгт хүрээд байгааг сануулжээ. Зураг 8.1-т нийслэлийн ердийн нэг ажлын өдрийн оройн 20:00 цагийн замын хөдөлгөөний урсгалын төлөв байдлыг харуулсан бөгөөд хотын төвийн ихэнх уулзвар хоорондын авто зам өндөр ачаалалтай, ‘улаан’ төлөвт орсон байна.

Зураг 8.1 Улаанбаатар хотын авто замын урсгалын мэдээ



Түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулахад Монгол Улсын Засгийн газар онцгойлон анхаарч нэгдсэн нэг бодлогын дор үйл ажиллагаа явуулан, цаг алдалгүй үр дүн гаргах зорилгоор 2022 оны 341 дүгээр тогтоолоор “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хороо”-г байгуулсан. Түүнчлэн Засгийн газрын 2021 оны 146

дугаар тогтоолыг батлан нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээнд жил бүр 420.0 тэрбум төгрөгөөс доошгүй санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2024 оны улсын төсөвт тусган үе шаттай хэрэгжүүлж байна. Энэ арга хэмжээний хүрээнд замын өргөтгөл, засвар, явган хүний гарц, газар доогуурх нүхэн гарц, ерөнхий


боловсролын болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын хичээлийн байрны засвар, шинэчлэл, шинэ байр, мөн нийтийн тээврийн парк шинэчлэл зэрэг олон ажил хийгдэж байна. Нийслэлийн Замын цагдаагийн газартай хамтран дугаарын хязгаарлалтын журмыг хэрэгжүүлж байгаа бөгөөд эдгээр ажлууд нь тодорхой хэмжээний эерэг, бас зарим сөрөг үр дүн үзүүлсээр байна.

Нөгөө талаас нийслэл хотын тээврийн хэрэгслийн тоо үргэлж өсөн нэмэгдэж байгаа бөгөөд АТҮТ -өөс ирүүлсэн автомашины бүртгэлийн мэдээлэл дээр үндэслэн 2040 он хүртэлх нийслэл хотын авто замын хөдөлгөөнд оролцож буй авто машины тоог Монголд орж ирснээс нь хойших хугацаа буюу Монгол дахь насжилтаар нь тооцоолсныг Зураг 8.2-т харууллаа.

Энэхүү тооцооллоос Зураг 8.2-оос харвал замын сүлжээний өнөөгийн нөхцөл байдалд илүү оновчтой шийдвэр гаргах, судалгаанд суурилсан төлөвлөлт хийх ажлын чанарыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв нь Монгол улсын их сургуулийн дэргэдэх “Математик хэрэглээ” төвтэй хамтран Улаанбаатар хотын авто болон явган замын сүлжээ, дэд бүтэц зэрэг өгөгдөл, мэдээллүүд дээр суурилсан зорчигч хөдөлгөөний урсгалын математик загварыг гаргах, симуляци тооцооны кодыг бичиж, үндсэн тооцооллын дэд бүтэц, платформыг байгуулахаар зорьж ажиллалаа.


Судлаачдын багийн хувьд симуляцийн загварчлал, тооцооны схемийн үнэ цэн, үнэн бодитой байдал нь түүнийг тэжээх өгөгдөл, мэдээллээс хамгийн ихээр хамаарна гэдэг үндэслэлээр худалдаанд байгаа бэлэн програм хангамж, эсвэл нээлттэй эхийн програмчлалын кодыг сонголгүйгээр, харин нийслэл хотын замын хөдөлгөөний үндсэн онцлогуудыг бүрэн тусгасан, өөрсдийн загварыг боловсруулан ашиглав. Ингэхдээ агент дээр суурилсан дискрет үйл явцын загварчлалын арга техникийг симуляцийн загварын

Зураг 8.2 Нийслэл хотын замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн тоо



суурь байхаар сонгон авч, өгөгдөл цэвэрлэх, тооцоонд бэлдэх, симуляцийн үндсэн циклийн тооцоог Python програмчлалын хэлэн дээр боловсруулан бэлдэв. Дараагийн хэсэгт симуляцийн загварын талаар Зураг 8.3-т дэлгэрэнгүй тайлбарлан орууллаа.

Зураг 8.3 Автозамын хөдөлгөөний урсгалын симуляцийн загварын диаграм



Бидний боловсруулсан нийслэлийн автозамын хөдөлгөөний урсгалын агент дээр суурилсан симуляцийн загварын схем нь дараах хэлбэртэй байна.

Манай загвар нь хугацааны динамикийн хувьд дискрет процессын симуляцийн ангилалд орох бөгөөд энэхүү ангиллын загварын нэр томъёонд шилжүүлж харахад автомашинууд нь агентууд, уулзвар хоорондын замууд нь дарааллууд, гэрэл дохионууд нь серверүүд байхыг илэрхийлж байгаа юм. Уг схемийн дагуу симуляцийн загварыг байгуулахдаа бид системийн төлөв байдал 1 секунд бүрт өөрчлөгдөж байхаар тооцоолсон бөгөөд системийн оролцогч элемент бүр өөрийн өнөөгийн төлөв байдлаас хамаарч дараагийн 1 секундэд ямар төлөв байдалтай байхыг тус бүрт нь загварчилж өгсөн болно. Системийн бүрдүүлэгч, симуляцийн загварт оролцогчдыг тодорхойлох 1 – 11 дугаартай блокууд болон эдгээрийг тодорхойлох параметруудийг нэг бүрчлэн авч үзье.


Симуляцид нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын зорчих хөдөлгөөний 200 мянга орчим ялгаатай агентууд оролцож байгаа бөгөөд үүнээс олон агент оролцсон симуляци хийх үедээ энэхүү 200 мянган үндсэн өгөгдлийг буцаалттай түүвэрлэх маягаар буюу статистикийн bootstrapping техникийг ашиглаж байгаа болно. Замын өргөн нь

тухайн уулзвараар нэвтрэх чиглэлүүдийн тооноос зөрж байгаа тохиолдолд аль чиглэлийн дараалал ямар хэмжээний ачаалалтай байгаа дээр тулгуурлан санамсаргүй байдлаар чиглэлд харгалзах эгнээний тоог тодорхойлохоор загварчилсан бөгөөд энэ нь үнэндээ бодит амьдрал дээр явагдаж буй үзэгдлийг дуурайж загварчилж байгаа хэрэг болно.

Симуляцийн платформ нь замын сүлжээ дэд бүтцийн мэдээлэл өгөгдсөн 239 уулзвар дээр ажиллаж байгаа бөгөөд симуляцийн хугацааны нэгжийг 1 секунд, нийт үргэлжлэх хугацааг 7200 секунд буюу 2 цагаар авсан байна. Энгийн өнцгөөс тайлбарлавал, симуляци хийж байгаа процесс нь хөдөлгөөнд оролцох 200 мянган агент буюу автомашиныг хугацааны эхэнд хөдөлгөөнийг эхлүүлж буй уулзварууд дээр нэгэн зэрэг тавьж уралдуулж, замын хөдөлгөөний төлөв байдлыг хянаж байгаа үйл явц юм.

Уг симуляцийг хөдөлгөөнд оролцож буй автомашины тоо 20 мянгаас эхлээд 400 мянга хүртэл нэмэгдүүлэх үед хөдөлгөөнд оролцож буй автомашины дундаж хурд анхны түгжрэлгүй үеийн дундаж хурдтай харьцуулсан хувийг Зураг 8.4-т харууллаа.

Зураг 8.4 Тээврийн хэрэгслийн тооноос хамаарсан хөдөлгөөний дундаж хурдны график



Энэхүү графикаас бид замын хөдөлгөөнд оролцогч авто машины тоо 20 мянгаас 400 мянга хүртэл 20 дахин нэмэгдэх үед хөдөлгөөний дундаж хурд 5 дахин,

харин 200 мянга болон 400 мянган автомашинтай үеийн хооронд 33 хувь хөдөлгөөний дундаж хурдны зөрүү байгааг харж болно.

МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭКСПОРТ



ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ГАЗАР




Манай улсын мах, махан бүтээгдэхүүний экспортын хамгийн өндөр үзүүлэлт 276 сая ам.доллар

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын Аж үйлдвэрийн сэргэлтийн хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг түүхий эдийн нөөцтэй уялдуулан боловсруулах, үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилт тавьсан. Нөгөөтээгүүр, мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх нэгдсэн стратеги боловсруулах, өрхийн мал аж ахуйгаас эрчимжсэн мал аж ахуй, кластерын хэлбэр рүү шилжин хөгжүүлэхийг дэмжих, олон улсын эрүүл ахуйн шаардлагыг хангасан брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүс нутгийн худалдаанд идэвхтэй оролцох зэрэг сорилтуудтай нүүр тулж байна. Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТҮГ-аас холбогдох судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Уг судалгаанд уул уурхайн бүс экспортын голлох бүтээгдэхүүний нэг болох мах, махан бүтээгдэхүүнийг сонгон авч, мал аж ахуй, мал төхөөрөх, махны үйлдвэрлэл, экспортод гаргах үйл явцын зураглалыг гаргаж, тэдгээрийн хөгжлийн хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорив.

Монгол Улсын Засгийн газраас 2016-2024 онуудад уурхайн бүс нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, эрчимжсэн мал аж ахуй, хоршоог хөгжүүлэх, малчдыг чадавхжуулах зорилго бүхий “Малын эрүүл мэнд”, “Монгол мал”, “Монгол малчин”, “Монгол экспорт”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”, “Эрүүл мал”, “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” зэрэг хөтөлбөрийг баталсан. Эдгээр хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн боловч, 2020-2022 онуудад дэлхий нийтийг хамарсан цар тахал, хөл хорио, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, БНХАУ-ын Ковид-19-ын тэг бодлого болон импортын мах, махан бүтээгдэхүүнд тавигдах хүнсний аюулгүй байдлын стандарт шаардлагын шинэчлэл, малын гоц халдварт өвчний дэгдэлт зэрэг гадаад, дотоодын олон хүчин зүйлээс хамаарч манай улсын мах, махан

бүтээгдэхүүний экспортын түвшин буурсан (График 9.1). Харин 2023 оноос БНХАУ-ын хилийн боомтууд хэвийн горимд шилжсэнээр манай улс 2023 оны эхний 11 сарын байдлаар нийт 70.6 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолсноос үхрийн хөлдүү мах 185 тонн, хонь, ямааны мах 9 мянган тонн, адууны мах 30.2 мянган тонн, малын дайвар бүтээгдэхүүн 966.2 тонн, дулааны аргаар боловсруулсан мах (ДАБ) 30.1 мянган тонныг эзэлж байна. Тус хугацаанд нийт 275.7 сая ам.долларын мах, махан бүтээгдэхүүн экспортолж, үхрийн хөлдүү мах 752.7 мянган ам.доллар, хонь, ямааны мах 31.2 сая ам.доллар, адууны мах 116 сая ам.доллар, малын дайвар бүтээгдэхүүн 1.2 сая ам.доллар, ДАБ 126.4 сая ам.долларт хүргэсэн. (График 9.2) Дээрх үзүүлэлт манай улсын мах, махан бүтээгдэхүүний экспортын түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд экспортын бүтээгдэхүүний нэгж тутмын үнэ өсөж байгааг илтгэж байгаа юм. 2023 оны эцэс гэхэд мах, махан бүтээгдэхүүний экспорт 300 сая ам.долларт хүрэх төлөвтэй байна.

График 9.1 Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ, төрлөөр



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

График 9.2 Мах, махан бүтээгдэхүүний экспортын мөнгөн дүн, төрлөөр

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Манай улс илүү тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд 71 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, худалдааны түншлэлийн харилцааг сайжруулах, экспортын орлогыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой. Бид судалгаандаа Япон улсын судлаач Ишикавагийн “Шалтгаан ба үр дагаврын диаграмм” аргачлалыг ашиглан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын үйл явцыг гурван бүлэгт ангилан, бүлэг тус бүрээр экспортын хязгаарлагч хүчин зүйлсийг тодорхойлов (График 9.3).

График 9.3 Мах, махан бүтээгдэхүүнийг экспортод гаргах үйл явцад үүсэж буй хязгаарлагч хүчин зүйлс

 Малыг махны чиглэлээр бэлтгэх үйл явц	 Мах бэлтгэл, боловсруулах үйл явц	 Мах, махан бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд гаргах үйл явц
- Малын идэш тэжээл цаг агаарын байдлаас шууд хамааралтай учир хур тунадас бага жилд хомсдолтой байдаг - Малын гоц халдварт өвчний тархалт, вакцинжуулалттай холбоотой асуудлууд - Мал сүргээ махны чиглэлээр тусгайлан бэлддэггүй тул сүрэг сэлгэх, селекцийн асуудлууд - Махны нийлүүлэлт улирлын чанартай учир тогтвортой бус - Зарим нутагт бэлчээрийн даац хэтэрсэн тул отор газрын маргаан их байдаг - Малын бүртгэл, мөшгих систем хэвийн ажилладаг хэдий ч хэрэглэгчийн талаас тухайн мэдээллийг шаардах шаардлага бага байдаг - Орон нутагт мал эмнэлгийн шинжилгээний лаборатори, малын эмч нарын хүрэлцээ муу - Малаа тээвэрлэхэд тээврийн стандарт дүрэм журам дагадаггүй.	- Махны ченжүүд махаа уламжлалт буюу гар аргаар боловсруулахыг илүү үздэг учир боловсруулах үйлдвэрийн ашиглалтын хувь бага байдаг. - Бүрэн стандартад нийцсэн мах боловсруулах үйлдвэрийн тоо цөөн - Үйлдвэрийн үйл ажиллагааны ариун цэврийн хяналт сул, мэргэжлийн байгууллагын хяналт шалгалт танилын хүрээнд явагддаг - Мах, махан бүтээгдэхүүн хөлдөөх, гүн хөлдөөх агууламж дутмаг - Хөргүүртэй мах тээвэрлэх машины тоо цөөн, өртөг өндөр байдаг - Шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэхэд зах зээлийн судалгаа, өндөр тоног төхөөрөмж, технологи шаардлагатай.	- Экспортлогч орны тавигдах шаардлага, бичиг баримт, шинэчлэгдсэн стандарт, дүрэм журмын талаар мэдээлэл ил тод бус байдаг - Экспортын зөвшөөрөл буюу квот олгох үйл явц тухайн үйлдвэрийн төлөвлөгөө, холбогдох журмын дагуу бус танилын хүрээнд ил тод бус явагддаг - БНХАУ-ын Гаалийн Ерөнхий газраас Монгол Улсад ирж хяналт шалгалт хийхдээ шалгалт хийх үйлдвэрийн тоонд хязгаар тогтоодог. - Хил гаалийн хяналт, хорио цээрийн хяналтад зарцуулдаг цаг багасч байгаа мөн цаашид багасгах боломжтой - Монгол махыг олон улсад сурталчлах, гадаад хамтрагчтай худалдааны гэрээ хийх мэргэжилтэн дутмаг.

Мах, махан бүтээгдэхүүний экспортын хязгаарлагч хүчин зүйлсийн үүсэх шалтгааныг нарийвчлан судалсны үр дүнд дараах арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзлээ.

1. Зарим эрх бүхий байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийх

Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, олон улсын шаардлагад нийцсэн зохистой байдлаар малаа төхөөрөх, ариун цэвэр, эрүүл ахуйн олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах нь тогтвортой махны экспортын үндэс билээ. Гэвч дотоодын болон олон улсын судалгаа, шинжилгээний материал, тайлан, гарын авлагуудад үйлдвэрлэлийн гинжин хэлхээний

Шигтгээ 1.

Ковид-19 цар тахлын дараа махан бүтээгдэхүүн хэрэглэгчдийн зан төлөв өөрчлөгдөж байна.

2023 онд “McKinsey&Company”-аас гаргасан хэрэглэгчдийн зан төлөвийн судалгаанд Их Британи, ХБНГУ, АНУ-ын хэрэглэгчид мах, махан бүтээгдэхүүн худалдан авахдаа махны үнэд хамгийн их ач холбогдол өгдөг бол БНХАУ-ын хэрэглэгчид махны үнэ, амт чанар, тогтвортой нийлүүлэлтээс илүү махны гарал үүсэл, хүнсний эрүүл, аюулгүй байдлыг анхаарч худалдан авалт хийдэг. Мөн хэрэглэгчдийн дийлэнх хувь нь ресторанд хооллохыг илүүд үздэг тул хөлдөөсөн махны хэрэглээ ирэх жилүүдэд 8 хувиар өсөх хандлагатай байна. Эндээс дүгнэхэд, Хятадын хэрэглэгчдийн худалдан авах чадвар сайжрахын зэрэгцээ хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбар хөгжсөн улс орнуудын Хятадын зах зээлд өрсөлдөхүйц үнэтэй, чанартай мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх өрсөлдөөн улам ширүүсэж байна. Хятадын хэрэглэгчид малын гарал үүсэл, эрүүл ахуйн аюулгүй байдалд ихэд анхаарал хандуулж, цаашид бэлчээрийн гаралтай, органик хөлдөөж бэлтгэсэн үхрийн махыг илүү худалдан авах хандлагатай байна. Мөн тэд эдгээр шаардлагыг бүрэн хангаж байгаа мах, махан бүтээгдэхүүнд мөнгөө зарцуулахад бэлэн байна. Харин бид бэлэн үү?

үе шатанд эдгээр стандартыг дагаж мөрддөггүй, мөн мэргэжлийн байгууллагын хяналт, шалгалтын үйл ажиллагаа хангалтгүй байгаа талаар тусгасан байдаг. Байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийснээр, давхардах эсхүл алдагдаж буй албан үүргийг бодитоор тодорхойлох, үнэлгээ өгөх, байгууллага хоорондын уялдаа холбоо, үйл ажиллагааг сайжруулах санал, зөвлөгөө боловсруулах боломжтой болдог. Иймд мал эмнэлгийн хяналт шинжилгээ хийх үүрэг бүхий байгууллагуудад чиг үүргийн шинжилгээ хийж мэргэжлийн байгууллагын мэргэжилтнүүдийн үр чадвар, хөдөлмөрийн бүтээмжийг бодитоор тооцох нь зүйтэй гэж үзэж байна. Мөн тэдгээр байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг боловсронгуй болгох, чиг үүрэг, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, мэргэжилтнүүдийн чадавхыг бэхжүүлэхэд анхаарч ажиллах шаардлага үүсэж байна.

2. Монгол махны маркетинг хөгжүүлэлтийг хариуцсан нэгж байгуулах

“McKinsey&Company”-аас гаргасан олон улсын хэрэглэгчдийн зан төлөвийн судалгаагаар хөгжингүй орны хэрэглэгчид бэлчээрийн маллагаатай, органик бордоогоор бордсон, антибиотик, нэмэлт бодис тариагүй малын махыг худалдан авахыг илүүд үзэж байна гэсэн дүгнэлт гарсан. Манай улс нүүдэлчин өв соёлтой, бэлчээрийн уламжлалт мал аж ахуй эрхэлж генийн өөрчлөлтгүй, органик бүтээгдэхүүн бэлтгэдэг харьцангуй давуу чанараа ашиглан олон улсын зах зээлд мах, махан бүтээгдэхүүнийг үнэ цэнд хүргэх бүрэн боломжтой. Монголын бэлчээрт 2,800 гаруй төрлийн ургамал ургадгаас 800-аад дээд зүйлийн ургамлыг мал иддэг гэсэн эрдэмтдийн судалгаа бий. Иймд манай улсын брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх, маркетингийн сүлжээ, бизнесийн түншлэл бий болгох чиг үүрэг бүхий нэгжийг байгуулан холбогдох мэргэжлийн холбоо эсхүл харьяа төрийн байгууллагын үйл ажиллагааны чиг үүрэгт нэгтгэн оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

3. Махны экспортын дунд хугацааны бодлого боловсруулан хэрэгжүүлэх

Ковид-19 цар тахлын дараа улс орнууд ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг хөдөө аж ахуйн хөгжлийн бодлогыг боловсруулж

байна. Хөгжиж буй орнууд хөдөө аж ахуйн салбарын экспортын дунд хугацааны бодлогыг хэрэгжүүлж, бодлогын засаглалын залгамж халааг сайн хангаж чаддаг учир гадаадын хөрөнгө оруулагчдын найдвартай түнш болж чаддаг.

Манай улсын хувьд мах, махан бүтээгдэхүүнийг олон улсын стандартын дагуу бэлтгэн боловсруулах, худалдааны шинэ чиглэл бий болгох, бүтээгдэхүүний нэр төрлөө төрөлжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилго бүхий нэгдсэн бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна. Энэ хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв” УТУГ-аас мах, махан бүтээгдэхүүний экспортын дунд хугацааны хөгжлийн бодлогын төслийг боловсруулсан. Экспортын нэгдсэн бодлого байхгүй тохиолдолд махны үйлдвэр, мах бэлтгэгч аж ахуй нэгжүүдэд ирэх жилүүдийн бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэлийн төлөвлөгөө гаргахад хүндрэлтэй байдал үүсэх, цаашлаад гадаадын хөрөнгө оруулагчдын хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулах сонирхол буурах зэрэг сөрөг нөлөөтэй.

Шигтгээ 2.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунляо аймгийн махны үхрийн аж ахуй

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Тунляо аймаг нь сүүлийн 10 жилийн хугацаанд махны чиглэлийн үхрийн аж ахуйг хөдөө аж ахуйн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, орон нутгийн ДНБ-ий 20 хувийг бүрдүүлдэг. Чингэхдээ дан ганц мал аж ахуйн салбарыг хөгжүүлээд зогсохгүй үр тариа, малын тэжээлийн тариалалтыг орхигдуулалгүй хөгжүүлсэн. Орон нутгийн засаг захиргаа малын тэжээл, үржил шим, таргалалтаас эхлээд мах боловсруулах, эцсийн бүтээгдэхүүнээ тээвэрлэх хүртэл үйл ажиллагааг сайжруулах олон тооны төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. Жишээлбэл, орон нутгийн засаг захиргаанаас махны чиглэлийн өндөр ашиг шим бүхий үхрийн үржил селекцын ажлыг хариуцан зохион байгуулж, 160 мянган малын гүн хөлдөөсөн үрийг үнэ төлбөргүй олгосноор 62 мянган үхэр хээл авч, 37 мянган тугал төрсөн. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх тогтвортой хөтөлбөр хэрэгжүүлснээр Хорчин суманд 2018 оноос 2022 оны хооронд махны чиглэлийн үхрийн тоо 166 мянгаас 407 мянга, үхрийн мал аж ахуй эрхлэгчдийн тоо 15 мянгаас 30 мянга, хоршоодын тоо 200-аас 400 болж нэмэгдсэн бодит үр дүн гарсан.

Шигтгээ 3.

Австрали улсын махны экспортын зах зээлийн хөгжил

Австрали улсын мал аж ахуйн салбар нь бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулсан 200 гаруй жилийн түүхтэй. Дэлхийн үхрийн тоо толгойн 1.5 хувь, хонины 5 хувь тус оронд байдаг. 2021 онд махны экспорт тус улсын нийт экспортын 3.7 хувийг эзлэн амьд малын болон махны экспорт 14.6 тэрбум ам.долларт хүрснээс түүхий мах, боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний экспорт 13 тэрбум ам.доллар, амьд малын экспорт 1.6 тэрбум ам.долларт хүрсэн байна. Австрали, Хятад нь худалдааны найдвартай түнш орнууд бөгөөд Австралиас мах, махан бүтээгдэхүүн Хятад руу экспортлоход гаалийн татвар төлдөггүй байна. Мөн Хятад улс нь Австрали улсын гуравдахь том үхрийн мах импортлогч, хоёрдахь том хурганы мах импортлогч, хамгийн том хонины мах импортлогч орон юм. Австрали улсын махны экспорттой холбоотой цогц мэдээлэл, гарал үүслийн баталгаа, шаардлагатай маягт хуудаснууд, экспортын зарим статистик мэдээллийг Хөдөө аж ахуй, загас агнуур, ойн яамны албан цахим хуудаснаас авахад маш хялбар байдаг. Мөн мах импортоор авдаг улс орнуудын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагын дэлгэрэнгүй мэдээлэл (улс орон, бүтээгдэхүүн тус бүрээр), импортлогч оронд мөрддөг хууль дүрэм, журам, холбогдох акт, стандартууд, импортын тариф зэрэг мэдээллийг бүрэн эхээр авах боломжтой.

Монголын уламжлалт аж үйлдвэрийн салбар нь хөдөө аж ахуйн нөөц, хүний нөөц, санхүүгийн нөөц, хөрөнгө оруулалт болон худалдааны чадамжаас шууд хамааралтай байдаг. Түүхий эдийн бэлтгэлийн сүлжээ өрсөлдөөний зарчмаар ажиллаж байж хөдөө аж ахуйн нөөцийг гүйцэт ашиглах боломж бүрддэг. Манай улсын хувьд ногоон, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ухаалаг хөдөө аж ахуйн хөгжлийг дэмжихийн тулд одоогийн үйлдвэрлэлийн технологи, нөөцийн удирдлагын арга барилыг сайжруулах хэрэгтэй. Мөн мал сүргийн эрүүл мэндийг сайжруулах, бэлчээрийн хяналт, зохицуулалт, малын тэжээл, малын дайвар бүтээгдэхүүний менежмент зэрэгт Засгийн газрын түвшинд анхаарч ажиллах шаардлагатай байна.



FIRST NATIONAL
INSURANCE



УЧИРЧ
БОЛЗОШГҮЙ
ЭРСДЭЛЭЭС
УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЖ
ТА ДААТГАЛАА
ХИЙЛГЭЭРЭЙ



ТАНЫ ЦАХИМ ТУСЛАХ
CHATBOT

Mongol Daatgal JSC
insurance@mongoldaatgal.mn
www.mongoldaatgal.mn

1800-1990
ДААТГАЛЫН ЛАВЛАХ



Иргэдийн гэнэтийн
ослын даатгал



Гадаадад зорчигчдын
гэнэтийн ослын даатгал



Хөдөлмөрийн чадвар
түр алдалтын даатгал



Үл хөдлөх
хөрөнгийн даатгал



Байгууллагын
хариуцлагын даатгал



Хүнд машин
механизмын даатгал



Хүүхдийн гэнэтийн
ослын даатгал



Гэр, хашаа
байшингийн даатгал



Эрүүл мэндийн
даатгал



Лангуу түрээслэгч, жижиг
худалдаа эрхлэгчдийн даатгал



Бараа материал
үлдэгдлийн даатгал



Электрон тоног
төхөөрөмжийн даатгал

Тээврийн
хэрэгслийн даатгал

✓ Сайн дурын даатгал

Таны тээврийн хэрэгсэлд
✓ учирсан хохирлыг
барагдуулна.

Та хөдөлгөөний үеийн осол
болон байгалийн эрсдэл
(аадар бороо, мөндөр, үер)
✓ үндсэн эрсдэл дээр нэмэлтээр
өөрт учирч болох эрсдэлийг
сонгон даатгуулах боломжтой.

Таны тээврийн хэрэгслийн зах
зээлийн үнэ болон сонгосон
✓ эрсдэлээс хамааран
хураамжийг тогтооно.

Нөхөн төлбөрийн хэмжээ нь
танд учирсан хохирлоос
✓ хамааран автомашины зах
зээлийн үнэлгээ хүртэл байна.

Жолоочийн хариуцлагын
албан журмын даатгал

Хуулийн дагуу жил бүр тээврийн
✓ хэрэгслийн өмчлөгч бүр заавал
даатгуулна.

Таны буруутай үйлдлийн улмаас
бусдын амь нас, эрүүл мэнд, эд
✓ хөрөнгөд учирсан хохирлыг
барагдуулна.

Тээврийн хэрэгслийн мэргэшсэн
жолооч болон C, D ангиллын
✓ үнэмлэхтэй хөдөлгөөнд оролцох
жолооч нь давхар жолоочийн
даатгалд заавал даатгуулна.

Нөхөн төлбөрийн хэмжээ B
ангилал 5 сая төгрөг хүртэлх, C, D
✓ ангилал 10 сая төгрөг хүртэлх
олгоно.



МАНДАЛ
ЛАЙФ

**ХАЙРЫГ НЬ
ОРЛОХГҮЙ Ч**

**ХАЛАМЖИЙГ НЬ
ҮРГЭЛЖЛҮҮЛНЭ**

Амьдралын Даатгалын Компани



www.mandallife.mn